


Training Manual on the Human Rights of Persons with Disabilities

The participation of the organizations of people with disabilities and their families in the process of ratifying, monitoring and implementing the United Nations Convention on the Rights of Persons with Disabilities



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай гарын авлага

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийг соёрхон батлах,
хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс,
тэдгээрийн гэр бүлийн гишүүд болон байгууллагуудын оролцоо

Training Manual on the Human Rights of Persons with Disabilities



ing

LIBRARY - BIBLIOTHEQUE
OHCHR

Edited by Giampiero Griffo and Francesca Ortali

HRE/KOND/5R/1

This document was created in the context of the project Strengthening the Skills of the National Federation of DPOs of Mongolia in Promoting and Defending the Rights of People with Disabilities Implemented by the Italian Association Amici di Raoul Follereau – AIFO

In active cooperation with Disabled People International – DPI Italy
Produced with the contribution of the United Nations


We would like to thank:

The National Commission of Human Rights of Mongolia
The Ministry of Health of Mongolia
The Ministry of Social Welfare and Labour of Mongolia
The National Federation of Disabled People's Organizations of Mongolia and its Member Organizations
The National Centre of the Rights of Women with Disabilities of Mongolia
The National Federation of the Blinds of Mongolia
The National Federation of the People with Hearing Difficulties of Mongolia

DDC
305.908.16'023
G-85
ISBN
978-99929-56-23-2

Published at:
"Best Colour International" Printing House
Jamyang Gun Street, Sukhbaatar district, Horoo #1, Ulaanbaatar, Mongolia
E-mail: bci@mongol.net
Tel/fax: +976-11-318632

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай гарын авлага



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийг соёрхон батлах,
хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс,
тэдгээрийн гэр бүлийн гишүүд болон байгууллагуудын оролцоо

Боловсруулсан: Жиаппиеро Гриффо
Франческа Ортали

Улаанбаатар хот
2007 он

Энэхүү баримт бичгийг “Раул Фолерогийн анд нөхдийн холбоо” – Итали улсын төрийн бус байгууллага (АИФО), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын холбооны Итали улс дах салбар (DPI Italy)-тай идэвхтэй хамтран ажиллаж, хэрэгжүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд, НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулав.

Хамтран ажилласан дараах байгууллагуудад
талархал илэрхийлье:
Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
Монгол улсын Эрүүл Мэндийн Яам
Монгол улсын Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам
Монгол улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын
Үндэсний Холбоо, түүний гишүүн байгууллагууд
Монгол улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Эмэгтэйчүүдийн Эрхийн Үндэсний Төв
Монгол улсын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо
Монгол улсын Сонсголын бэрхшээлтэй Иргэдийн Үндэсний Холбоо

DDC
305.908.16'023
G-85
ISBN
978-99929-56-23-2

“Best Colour International” хэвлэлийн компанид хэвлэв.
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъяан Гүний гудамж, 9-1
Э-шуудан: bci@mongol.net
Утас/факс: +976-11-318632

Contents

Project background	
Foreword	
Introduction	
Methodological Note on Training	
Key Training Concepts.....	
The Condition of People with Disabilities	
The United Nations Convention on the Rights of Persons with Disabilities DPOs in the Promotion and Protection of Human Rights	
A National Strategy to Support and Participate in the Process of Ratifying the Convention	
Annexes	

Project background

The present project is the result of a long presence of AIFO – Associazione Italiana Amici di Raoul Follereau - in Mongolia and its collaboration with Ministry of Health, the National Rehabilitation Centre for people with disabilities and the National Federation of DPOs. The first feasibility study in Mongolia was held in 1991 by AIFO; between 1992 and 1996, AIFO held training courses for trainers at National level on CBR strategies and elaborated ways of adaptation in Mongolian specific context. Between 1997 and 2001, CBR project covered 50 % of the total populations, which means 11 provinces in the west part of Mongolia out of 21 provinces and Ulaanbaatar 6 districts. Between 2001 and 2005, CBR project reached all the 12 provinces of the western part of Mongolia, including Bayan-Ulgii province (Kazak minority) and Nalaih and Baganuur districts within Ulaan Bataar, the capital city. In the present phase, the project focuses on organising the communities and empowering people with disabilities and organisation of people with disabilities. The project was discussed and plan of actions were elaborated together with the local partner, collaborators to ensure involvement and full sharing of decision making.

Since the beginning of its presence in Mongolia, AIFO has been paying special attention to strengthen the capacity building of the Organisations of People with disabilities – DPOs and the National Federation. Moreover, in 2005, AIFO supported a project implemented jointly with the Federation on “Disability Amendments in the existing laws of Mongolia” in collaboration with the local NGO¹ “Consensus”. The working group, formed by lawyers and members of the Mongolian Federation of DPOs, analyzed more than 20 existing laws and the latest version of Draft Comprehensive and Integral International Convention on the Protection and Promotion of the Rights and Dignity of Persons with Disabilities. The Disability Amendments were presented to the 2005 Autumn session of the Great Khural, the Parliament of Mongolia. After the approval of United Nations Convention on the Protection and Promotion of the Rights and Dignity of Per-

¹ Consensus/Lobby Center/NGO is a non-governmental, non-party and non-profit organization. Its mission is: the promotion of new mechanism of cooperation between main political stakeholders; the achievement of political consensus in favor to the essential interest of people of Mongolia; the encouragement of mechanism of direct democracy supporting citizens' participation in the public governance and combating corruption. The adopted strategy is: establishing a “Lobby Center”, promoting a lobbying system and human rights and legal literacy, producing legal and political researches and policy documents on priority issues such as gender, human rights, corruption, laws.

Агуулга

Төслийн тухай	
Өмнөтгөл	
Танилцуулга	
Сургалтын арга зүй	
Сургалтын гол ойлголтууд	
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдал	
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц	
Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд ХБИБ-ууд	
Конвенцийг соёрхон батлуулах явцыг оролцох болон хөхиүлэн дэмжих Үндэсний Стратеги	
Хавсралтууд	

Төслийн тухай

Монгол улсад хэрэгжиж байгаа “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах” төсөл нь АИФО байгууллагын Монгол дах суурин төлөөлөгчийн газар, Монгол улсын Эрүүл мэндийн яам, Сэргээн засалтын үндэсний төв, Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбооны олон жилийн хамтын ажиллагааны үр дүн юм. 1991 онд АИФО байгууллагын төлөөлөгчид Монгол улсад анхны айлчлалаа хийж, нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг хэрэгжүүлэх боломж байгааг тодорхойлж, 1992-1996 онд үндэсний түвшинд хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын стратегийн талаар сургагч багш бэлтгэж, түүнийг Монгол орны нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон юм. 1997-2001 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах” төсөл нийт хүн амын 50 хувийг буюу баруун бүсийн 11 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүргийг хамран хэрэгжсэн бөгөөд 2001-2005 онд Баян-Өлгий аймаг хамрагдсанаар нийтдээ 12 аймагт үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнчлэн Улаанбаатар хотын Налайх, Багануур дүүргүүдэд төслийн үйл ажиллагаа хүрч өргөжлөө. Одоогийн байдлаар төсөл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чадавхжуулах, хамт олныг зохион байгуулахад анхаарлаа хандуулж байна. Шийдвэр гаргах явцад бүрэн оролцоог хангах үүднээс төсөл болон түүний хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг орон нутгийн түншлэгч, хамтран ажиллагсдын идэвхтэй оролцоотойгоор хэлэлцүүлж боловсруулж байна.

Монгол оронд АИФО байгууллага ажиллаж эхэлсэн үеэсээ эхлэн Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагууд болон Байгууллагуудын Үндэсний Холбооны чадавхийг бэхжүүлэхэд онцгой анхаарал тавьж ирсэн билээ. 2005 онд АИФО байгууллага Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын Үндэсний Холбоо, “Консенсус” төрийн бус байгууллагатай хамтарч хэрэгжүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох: Монгол улсын хууль дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах” төслийг санхүүжүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны гишүүд болон хуульчдаар ажлын хэсэг байгуулж одоо хэрэгжиж байгаа 20 гаруй хууль

¹ Консенсус /Лобби төв/ ТББ нь төрийн бус, нам бус, ашгийн бус байгууллага юм. Түүний зорилго нь: Монголын ард түмний язгуур эрх ашгийн төлөө улс төрийн хүчнүүдийн хамтын ажиллагаа, улс төрийн зөвшилцөлд хүрэхэд чиглэгдсэн улс төрийн шинэ тогтолцоог бий болгоход хувь нэмэр оруулах, иргэдийн санаачлага, төр засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, авилгатай тэмцэх санаачилгыг дэмжих замаар шууд ардчилалын механизмыг дэмжихэд оршино. Стратеги нь: Лобби төвийг байгуулж, лоббизмийн эрх зүйн институцийг бий болгох, хүний эрх ба хууль зүйн мэдлэг олгох, хууль эрх зүйн болон улс төрийн судалгаа хийх,хүйс, хүний эрх, авилгал, хуулийн талаарх бодлогын баримт бичиг боловсруулах зэрэг нь хамаарна.

sons with Disabilities, the amendments were modified and updated and finally they will be discussed during the Parliament spring session of 2007.

The main objective of the present project was to improve the skills of the National Federation of DPOs in Mongolia and the partner organizations in promoting and defending the rights of persons with disabilities. As a result of the project, firstly the Federation was strengthened with well-educated human resources, who are better aware of human rights and better advocate the rights of persons with disabilities at the political level, pushing the Human Right approach in legislation and supporting new legislation based on the UN Convention approach. Secondly, the Federation's organizational and managerial capacity improved through different subjects of training. Therefore, the capacity building process was strengthened and the Federation helped to become a more dynamic and self-reliant organization at the end of the project implementation.

The training courses organised set out in two levels: one theoretical on Human Rights approach through cascade training, and technical level on Management field, computer skills and English language.

The increasing demand of people with disabilities to obtain a role in decision making and precise responsibilities brought to a self consciousness of the need of further training, on technical and managerial issues, as well as on the empowering process based on human rights strategy. The present "Training manual on the human rights of people with disabilities" is the result of the perceived needs and analysis of the situation of the organizations of people with disabilities in Mongolia. The starting idea was to get a training manual flexible and constructed in modules, to be used in the different Countries of the world, in different cultural, social, political and economic backgrounds and actual contexts. It is mainly addressed to the participation of the organizations of people with disabilities and their families in the process of ratification, monitoring and implementation of the United Nations Convention on the rights of people with disabilities.

Foreword

Two thousand and five hundred years ago, when the young prince Siddhartha, secretly slipping out of his father's palace, discovered illness, old age and death, he definitely met also disability. His choice to devote his whole life searching the way to eliminate the pain, becoming the Buddha, he affirmed the right of each one to get free from suffering for ever.

In this process, with regards either to persons with disabilities as well as every human being, essential requirements are some abilities like: capability to make communities recognise and declare specific and universal human rights and to know how to make them due; to know how to identify new rights, rewriting the existing ones.

This is a belief that AIFO acquired and that comes from leprosy millenary history. It is not enough to treat this illness, neither to recover from it. Once it is contracted you live a double condition: you have leprosy and you are a leper, which is, signed by a mark which socially marginalizes and excludes from the community.

Likewise, in the present world, a person out of ten has a disability and is also disabled. Thanks to old and new technologies, it has not been difficult to find any technical remedy to avoid the functional consequences of disability. Much more difficult is to remove the debarring stigma which maliciously flutters around every disable person. This is a different issue from the needs of medical, surgical or prosthetic correction: the fundamental rights of human beings are here involved. It is for this reason that I like to think that Janraisig, the bodhisattva of compassion, and the saviour goddess Tara would appreciate the offer of this manual.

It is a happy coincidence that this Manual, carried out with the financial contribution of UNO, sees the light few months after the approval of the UN Convention on the rights of persons with disabilities. For the work (background) from which it comes and for its operational stances which it contains, it is an extraordinary example of implementation of the spirit of the Convention itself.

It is the result of decisive convergence of the participation of persons with disabilities, their families and their organisations, and of the receptiveness towards change of the Mongolian Government and institutions.

This is a Manual of active citizenship, exemplary product of a bottom-up capacity building, not only theoretical but concrete, in the field of the rights of persons with disability in Mongolia. Its foundations lay on the recognition of the intrinsic dignity of every human being, and extraordinary value of every person in his/her way of being alive.

тогтоомжинд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, тэдний эрхэм зэргийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай олон улсын конвенцийн төслийн эцсийн хувилбарт дүн шинжилгээ хийсэн бөгөөд дээрх хуульд нэмэлт өөрчлөлт хийх төслийг Монгол улсын Улсын Их Хурлын 2005 оны намрын чуулганд өргөн барьсан болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, тэдгээрийн эрхэм зэргийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц батлагдсаны дараа эдгээр хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг дахин боловсруулсан бөгөөд 2007 оны УИХ-ын хаврын чуулганд ярилцахаар болсон.

Энэ удаагийн төслийн гол зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо, түүний гишүүн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхэд оршсон. Төслийн үр дүнд нэгдүгээрт, хүний эрхийн талаар илүү сайн мэдлэгтэй, НҮБ-ын Конвенцийн дагуу шинэ хууль дүрмийг дэмжих, хууль дүрмэнд Хүний Эрхийн хандлагыг тусгаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг улс төрийн түвшинд өмгөөлөхөд сайн сургагдсан хүний нөөцтэй болсон. Хоёрдугаарт, төрөл бүрийн сургалт зохион байгуулж Үндэсний Холбооны зохион байгуулалтын болон удирдлагын чадвар сайжирсан. Төслийн хэрэгжүүлэх хугацаа дуусахад Үндэсний Холбоо нь илүү өөртөө итгэлтэй, илүү эрч хүчтэй болж, чадавх нь бэхжсэн.

Сургалт хоёр түвшинд зохион байгуулагдсан: нэг нь хүний эрхийн онолын сургалт. Энэ нь цаашаа сургах сургагч багш нарыг бэлтгэсэн. Нөгөөх нь менежмент, компьютер, англи хэлний чадварыг сайжруулах техникийн түвшин. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шийдвэр гаргах явцад оролцох шаардлага болон тодорхой хариуцлага нь ирээдүйд техникийн болон удирдлагын асуудлаар болон хүний эрхийн стратегид тулгуурласан эрх мэдэлжүүлэх үйл явцын талаар сургалт хэрэгтэй байгааг харуулж байна. Энэхүү “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай гарын авлага” нь Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, олж авсан хэрэгцээний үр дүнд бий болсон. Анхны санаа нь соёл, нийгэм, улс төр, эдийн засаг нь өөр орнуудад ашиглагдах сургалтын модультай, уян хатан сургалтын гарын авлага боловсруулахад оршиж байсан. Энэхүү гарын авлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийг соёрхон батлах, хянах, хэрэгжүүлэх үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн гэр бүлийн гишүүд болон байгууллагуудын оролцоонд голлож анхаарсан.

Өмнөтгөл

Хоёр мянга таван зуун жилийн тэртээ залуу ханхүү Сиддхартха аавынхаа ордноос нууцаар оргон гарч, өвчин, хөгшрөл, үхэл, мөн мэдээж хөгжлийн бэрхшээлийг нээж илрүүлжээ. Тэрээр өөрийнхөө бүх амьдралыг өвчин зовлонгоос ангижрах арга замыг хайхад зориулж Будда болсноор хэн боловч өвчин зовлонгоос ангид байх эрхтэй гэдгийг баталсан юм.

Бүх хүн төрөлхтөн, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зарим нэгэн чадвартай байх үндсэн шаардлага тавигддаг: хамт олон хүний эрхийн түгээмэл, тусгай эрхүүдийг мэдэх болон олон нийтэд таниулах чадвартай байх, тэднийг хэрхэн тохиромжтой болгохыг мэддэг байх; одоо байгаа эрхийг дахин бичиж, шинэ эрхийг хэрхэн нээхийг мэддэг байх гэх мэт.

Үүнийг уяман өвчний мянга мянган жилийн түүхээс АИФО-гийн олж авсан итгэл үнэмшил юм. Энэ өвчнийг зүгээр нэг эмчлэх, анагаах нь хангалттай биш. Нэгэнт ийм өвчтэй болсон цагт та хоёр нөхцөлд амьдарч эхэлнэ: та уяман өвчтэй, мөн та хамт олноос гадуурхагдсан уяман өвчтэй хүн болно.

Үүний нэгэн адилаар одоогийн ертөнцөд арван хүний нэг нь хөгжлийн бэрхшээлтэй байгаа ба түүнийг мөн хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж нэрлэдэг. Хуучин, шинэ технологиудын ачаар хөгжлийн бэрхшээлээс болж гардаг үр дагавараас урьдчилан сэргийлэх техникийн анагаах аргыг олоход төвөггүй болсон билээ. Энэ нь эмнэлгийн, мэс заслын эсвэл протезийн засварын хэрэгцээнээс өөр асуудал юм: энд мөн хүний үндсэн эрх хамрагдана. Тийм ч учраас энэрэн нигүүлсэнгүй Жанрайсаг бурхан, болон аюулаас хамгаалдаг Дарь эхүүд энэхүү гарын авлагыг гарахад дэмжлэг үзүүлсэн гэж би бодох дуртай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц батлагдсанаас цөөн хэдэн сарын дараа тус байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр энэхүү Гарын авлага гарч байгаад маш баяртай байна. Үүсч бий болсон энэ ажлын хувьд ч, мөн үйл ажиллагааны байр суурийн ч хувьд энэ нь Конвенцийн утга санааг хэрэгжүүлэх онцгой загвар юм.

Энэ нь Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн гэр бүл, байгууллагууд өөрийнхөө Засгийн газар болон байгууллагууд руу шийдвэртэй алхам хийсний үр дүн юм.

Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талбарт зөвхөн онолын биш жинхэнэ бодит, доороос дээшээ чадавх бэхжүүлэхийн загвар болсон энэхүү бүтээгдэхүүн нь идэвхтэй оршин суугчдын гарын авлага юм. Хүн төрөлхтөний салшгүй эрхэм зэрэг, хүн бүрийн амьд байх ер бусын онцгой үнэт зүйл дээр үндэс суурь тогтож байгаа юм.

Besides, the organized and conscious action of persons with disabilities in Mongolia shows the huge value of the knowledge that every persons with disability has with regards to his/her own life condition.

Thanks to the achieved empowerment, persons with disabilities acquired on the field the status of experts of their own condition and are consequently and obviously trainers.

Therefore, it is not only a question to implement computer science or English language or management or international law courses. There is something more. Through training courses set out with the support of DPI and AIFO, it was set in motion a recursive process which produces new empowerment, new critic consciousness, new knowledge, new capabilities on human rights, to be used for every human being.

In this way persons with disabilities, who previously were the stones rejected by the builders of society, have now become the capstone in the building of a democratic Mongolia and of solidarity, equality and freedom.

Therefore, the national symbol of Mongolia, the Soyombo conceived by Zanabazar, among its many meanings, may in this way enumerate also the freedom, dignity and autonomy of persons with disability.

The Manual is of course a tool for new concrete goals, for the wellbeing of the last, which, according to the theory of justice of John Rawls, constitutes an essential parameter of the civilization of a society.

It is necessary to make fundamental rights and available resources distributed in the most possible equal way, avoiding inequalities. As Rawls does, we however admit a positive inequality, an exception of justice to the formal equity.

When you work in favour of those who are in concrete disadvantaged conditions, it is necessary to fill the gap of opportunities in order to reduce this disadvantage. It is not right to make equal parts among unequals.

For this reason, AIFO is deeply engaged to make international cooperation integrate the knowledge of disable condition in each project of intervention, appreciating the human meeting on an equal footing, among faces that look at each other and recognise them a value itself original and unalienable.

It is a concern of active love, of political non-violent love, to which we invite each reader or user of this Manual.

Francesco Colizzi
President
Associazione Italiana Amici di Raoul Follereau - AIFO

Introduction

The adoption in the United Nations of the Convention on the Rights of Persons with Disabilities on 13 December 2006 is the culmination of years of struggles by members of the global community of persons with disabilities for the recognition and respect of their rights. This is an initiative which members of the disability movement have worked so hard over decades, to achieve. The work for the convention has witnessed how the global movement of persons with disabilities has set aside their individual issues in favor of uniting to speak with one common voice to demonstrate their commonality of issues, including the day-to-day experience of discrimination which many persons with disabilities are subjected to. Such experience of discrimination has unified disabled persons to fight for disability rights to be recognized as human rights. Today, we celebrate the signing of the treaty by over a hundred member-states of the United Nations and the ratification of the same by 2 countries as of July 2007. But it is not right to assume that the work is done. In fact, it has just begun. The Convention indeed is a strong tool that can bring about change nationally and internationally. It can facilitate creation of a level playing field that equalizes opportunities and thereby help build better lives for all persons with disabilities and their families. It can likewise serve to hasten the inclusion of persons with disabilities in the life and activities of their communities wherever in the world they live. Disability rights as human rights are an issue whose time has finally come.

As many of us are aware of, our colleagues with disabilities in many developing countries are not even aware that they have rights. Many persons with disabilities need to be assisted in understanding what the Convention means and how it can be used as a tool to improve their own situation in the countries where they live. It is in this light that I wish to congratulate and commend the initiative of the DPI-Italy which has produced a training manual through the support of AIFO and UNDESA, to help persons with disabilities in developing countries understand what are human rights as applied in the context of disability and how to use the Convention as an effective tool for them to get their governments address the many issues that have contributed to the economic deprivation, isolation and marginalization of the poorest persons with disabilities the world over.

As has been said repeatedly, disabled persons are the experts of their own situation. Nothing about us, without us.

Venus M. Ilagan
Chairperson
Disabled Peoples' International
World Council

Түүнээс гадна, Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зохион байгуулалттай, өөртөө итгэлтэй үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр өөрийнхөө амьдралын нөхцөл байдлыг хүндэтгэж байгаа нь мэдлэгийн асар их үнэт зүйлийг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийнхөө нөхцөл байдалд мэргэжилтэн болсон ба энэ нь мэдээж сургагч багш нарын үр дүн юм. Энэхүү хүрсэн эрх мэдэлд баярлалаа. Тиймээс энэ нь зөвхөн компьютерийн шинжлэх ухаан, Англи хэл эсвэл менежмент, эсвэл олон улсын хуулийн сургалтуудыг хэрэгжүүлэх тухай биш. Энд илүү их зүйл агуулагдаж байгаа. АИФО болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын байгууллагын (DPI) дэмжлэгтэйгээр зохион байгуулсан сургалтуудаар хүн бүрт хэрэгтэй шинэ эрх мэдэл, шинэ чухал мэдрэмж, шинэ мэдлэг, хүний эрхийн талаарх шинэ чадваруудыг бүтээх дахин давтагдаж байх үйл явцыг эхлүүлсэн юм.

Иймэрхүү аргаар өмнө нь нийгмийн барилгачдын хаясан чулуу шиг байсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өнөөдрийн эв нэгдэл, тэгш байдал, эрх чөлөөний ардчилсан Монголын барилгын гадна талын өнгөлгөөний, гоёлын чулуу болсон.

Өндөр Гэгээн Занабазарын бүтээсэн Монголын үндэсний бэлэг тэмдэг болох Соёмбын агуулдаг олон утгуудаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх чөлөө, эрхэм зэрэг, автономит байдлыг нь нэрлэж болох юм.

Мэдээж энэ гарын авлага нь нийгмийн соёл иргэншлийн үндсэн параметрийг үүсгэдэг Жон Роулзын шударга ёсны онолын дагуу төгсгөл хүртлээ сайн сайхан байх гэсэн шинэ бодит зорилгод хүрэх хэрэгсэл болно.

Үндсэн эрх, боломжит нөөц бололцоог хамгийн боломжит тэгш аргаар нийлүүлэх нь чухал. Роулзын хэлснээр шударга ёсны бодол төсөөллийг албан ёсны тэгш байдалд хүргэхэд бид эерэг тэгш бус зүйлийг зөвшөөрдөг.

Үүнэхээр давуу бус нөхцөл байдалд байгаа хэн нэгний төлөө та ажилладаг бол тэрхүү давуу бус талыг багасгахын тулд боломжуудын цоорхойг нөхөх нь чухал. Тэгш бус байдлын дунд тэгш хэсэг гаргах нь зөв биш.

Тийм ч учраас бие биенээ хараад анхдагч, салгаж болшгүй үнэт зүйл гэж таних, ижил тэгш алхах хүмүүстэй АИФО уулзаж, төсөл бүрдээ хөгжлийн бэрхшээлийн нөхцөл байдлын талаарх мэдлэгийг олон улсын хамтын ажиллагаанд нэвтрүүлэхэд онцгой анхаарал тавьж ажилладаг.

Энэ нь идэвхтэй энэрэл хайр, улс төрийн хүчирхийлэлгүй энэрэл хайрын ойлголт учир уншигч авхай таныг ч энэхүү гарын авлагыг уншихыг урьж байна.

Франческо Колиззи

Ерөнхийлөгч

Раул Фолерогийн Анд Нөхдийн Холбоо - АИФО

Танилцуулга

2006 оны 12-р сарын 13-нд Нэгдсэн Үндэстний Байгууллага Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг баталсан нь эрхээ хүндлэх, түүнийг таниулан мэдүүлэхийг хүссэн дэлхий нийтийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон жилээр зовж тэмцэж ирсний үр дүн болсон юм. Олон арван жилийн туршид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлгөөний санаачлага амжилтанд хүрсэн нь энэ. Энэхүү Конвенц нь олон мянган хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өдөр тутамд алагчлалд өртөж байгаа болон өөр бусад нийтлэг зүйлүүдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дэлхийн хөдөлгөөнөөр дамжуулж нэг дуу хоолойгоор илэрхийлснийг гэрчилсэн ажил болсон. Алагчлалын энэ туршлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эдлэх ёстой эрхээ эдлэхэд тэмцэлд нэгтгэж чадсан юм. Өнөөдөр бид Нэгдсэн Үндэстний Байгууллагын зуу зуун Гишүүн Орнууд гэрээнд гарын үсэг зурж, 2007 оны 7-р сар гэхэд 2 орон соёрхон баталсныг баярлан тэмдэглэж байна. Гэхдээ ажил дууссан гэж бодож бид бодохгүй байна. Үнэнийг хэлэхэд ажил одоо л эхэлж байна. Энэхүү Конвенц нь үндэсний болон олон улсын түвшинд өөрчлөлт хийж чадах хүчтэй хэрэгсэл юм. Энэ нь тодорхой түвшинд боломжийг тэгш болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амьдралыг илүү дээр болгоход тус болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амьдарч байгаа газарт нь хамт олны амьдрал болон үйл ажиллагаанд оролцуулахад тусална. Хөгжлийн бэрхшээлийн эрх нь цаг нь болсон хүний эрх юм.

Бидний ихэнх нь мэдэж байсан боловч хөгжиж байгаа оронд амьдарч байгаа бидний нэгэн адил найзууд тэд эрхтэй гэдгээ мэддэггүй байсан. Олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ Конвенц ямар утгатайг ойлгуулах, үүнийг амьдарч байгаа орондоо нөхцөл байдлаа сайжруулахад хэрхэн хэрэгсэл болгон ашиглах талаар нь тэдэнд туслах шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлийн талбарт хүний эрх гэж юу болох, дэлхий дээрх нэн ядуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлах, анхаарахгүй байх, эдийн засгийн хоосрол зэрэгт хувь нэмрээ оруулах зэрэг асуудалд засгийн газраа хандуулахын тулд уг Конвенцийг хэрхэн үр дүнтэй хэрэгсэл болгон ашиглах талаар ойлгуулж хөгжиж байгаа орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах зорилгоор АИФО болон НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн хэлтсийн дэмжлэгтэйгээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын байгууллагын Итали дах салбар (DPI-Italy) санаачилж энэхүү гарын авлагыг бүтээж гэрэл гэгээ гаргаж байгаад нь баяр хүргэхийг хүсч байна.

Өмнө нь хэлж байсанчлан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол өөрийн нөхцөл байдалд мэргэжилтэн нь байдаг. Бидэнгүйгээр бидний талаар юу ч байхгүй.

Венус М. Илаган

Тэргүүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын байгууллага - DPI

Дэлхийн Зөвлөл

Methodological Note on Training

Training for a specific goal, in this case to promote the participation of the organizations of people with disabilities in the decision-making processes that affect their lives, requires particular attention to the local situation, the cultural context, the level of ability and awareness of the organizations and their leaders, the available technology and the disability policies of the country involved.

This means that we cannot have a one-size-fits-all intervention model, but must personalize the course as much as possible. Cultures and socioeconomic, political and social situations shall be kept in mind and the suggestions of experts and DPOs collected through specific preparation. It is important to use appropriate language that is understandable by the course participants, to be familiar with the country's situation and to judge the level of dialogue with local and national authorities achieved by the organizations of people with disabilities, in order to identify realistic and achievable goals.

Given the nature of the training it would be preferable to use trainers and experts from the same world of the organizations of people with disabilities. Indeed, this would reinforce the contents of the lessons by offering role models that could stimulate course participants to identify with a real leadership. This also applies to the parts of the course concerning the national situation in the country in which the course is carried out.

This choice will also allow the trainers to use not just a traditional teacher-centred education model, but also lessons involving cooperative learning activities and group peer counselling-type exercises. The lessons will therefore aim to bring out the lived experiences of the course participants by building on the methods of working and action used in their country. Moreover, as these techniques are particularly effective at an individual level, but delicate in group activities, appropriate pedagogical tools should be used to facilitate interpersonal and cooperative communication and participation in the training activities. In this regard exercises in subgroups, simulations and pedagogical tools based on cooperative activities are useful.

Introduction

Another factor to bear in consideration is the possibility of transferring training from the centre outwards. In this regard, it would be useful to provide for two levels of training: the first central level involving the national leaders of organizations of people with disabilities and their families and other persons, who have the responsibility for passing on the training received from the national to the local level (especially in rural areas where often not much information reaches). It seems appropriate in this regard to identify some prerequisite abilities for potential trainers. The second training level can consist of more or less simplified training modules, to be worked out based on the various welfare and skills systems delegated to local authorities, aimed at local DPO leaders and their families. It is important to homogenize the skills of the local and national associations through a human rights-based approach.

Сургалтын арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг өөрсдийнх нь амьдралд хамаарах шийдвэр гаргах явцад оролцоход нь дэмжлэг үзүүлэх тусгай зорилго бүхий энэхүү сургалтыг зохион байгуулахад тухайн орны нөхцөл байдал, соёлын зан заншил, өвөрмөц онцлог, оролцогч байгууллагууд, тэдгээрийн удирдагчдын мэдлэг чадварын түвшин, технологийн боломжит байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ талаар төрөөс явуулж буй бодлого зэрэгт анхаарах шаардлагатай болно. Энэ байдал нь бүгдэнд нь таарах нийтлэг нэг сургалтын загвар байхгүй бөгөөд харин аль болох түүнийг оролцогчдод тохируулах шаардлагатайг харуулж байна. Соёл, нийгэм, эдийн засаг, улс төр нийгмийн байдлууд төдийгүй мэргэжилтнүүдийн зөвлөгөө, тусгай аргаар цуглуулж авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын саналыг ч сургагч багш анхааран ажиллах нь зүйтэй. Үүний зэрэгцээ бодит, хүрч болохуйц зорилгыг тодорхойлохын тулд тухайн орны нөхцөл байдалд танил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын амжилтанд хүрсэн орон нутгийн болон үндэсний эрх бүхий байгууллагуудтай ярилцсан ярилцлагын түвшинг шүүн тунгааж болохуйц, сургалтанд оролцогчдод ойлгомжтой, тохирох хэлийг ашиглах нь чухал.

Сургалтыг зохион байгуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд нь ижил төрлийн байгууллагуудын мэргэжилтн, сургагч багш нарын оролцоог хангах нь илүү үр дүнтэй. Энэ нь сургалтын агуулгыг илүү эрчимжүүлж сургалтанд оролцогчдыг одоогийн байгаа манлайлалын хэлбэрийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон тухайн орны үндэсний нөхцөл байдлыг анхаарч үзэх нь сургалтын нэг хэсэг болдог.

Сургалтын энэ хувилбар нь сургагч багшид зөвхөн уламжлалт багш төвтэй боловсролын загварыг ашиглах биш хичээлийг хамтарч суралцах, харилцан зөвлөж, ярилцах бүлгээр ажиллах боломжийг олгодог. Тийм учраас хичээл нь тухайн оронд ашиглагддаг ажлын арга барилаар сургалтанд оролцогчдын туршлагыг хуваалцах боломж олгохыг зорьдог. Энэ мэт аргууд нь хувь хүнд илүү үр өгөөжөө өгөх боловч бүлгийн ажилд төдийлөн тохиромжгүй тул сургалтын үйл ажиллагаанд хувь хүмүүс хоорондын харилцаа, хамтын ажиллагаа болон оролцоог эрчимжүүлэх сургалтын тохирох арга зүйг сонгох хэрэгтэй. Ийм нөхцөлд хамтран ажиллах үйл ажиллагаан дээр түшиглэсэн сургалтын арга зүйг ашиглаж, ижил төстэй байдлаар нь баг болгож, дасгал хийх нь илүү үр дүнтэй.

Мөн, өөр нэг үр дүн бүхий сургалтын арга бол багшийн багш бэлтгэх үйл ажиллагаа юм. Үүний тулд сургалтыг хоёр түвшинд зохион байгуулах нь үр дүнтэй: Эхний түвшин нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, тэдний гэр бүлийн гишүүдийн идэвхтнийг үндэсний түвшинд сургаж, улмаар тэднээр дамжуулан орон нутгийн түвшинд (ялангуяа мэдээлэл төдийлөн байнга хүрдэггүй хөдөө орон нутагт) мэдлэг, ойлголт түгээх үйл ажиллагаа байна. Энэ үе шатанд аль болох оюуны чадавхтай сургагч багш болж чадах боломжтой хүнийг оролцуулах нь зүйтэй. Сургалтын хоёрдугаар түвшин нь орон нутгийн эрх бүхий байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын удирдлага, тэдний гэр бүлийн гишүүдэд зориулсан төрөл бүрийн халамжийн болон чадвар олгох агуулгаар боловсруулсан арай хялбаршуулсан сургалтын модуль байна. Үндэсний болон орон нутгийн нийгэмлэгүүдийн ур чадварыг хүний эрхэд суурилсан хандлагаар жигдрүүлэх нь чухал.

Legend

The text includes sentences taken from some of the fundamental international documents for a human rights-based approach to disability. In order to identify the origins of the quotations in the text the reader should note that:

- quotations from the text of the Convention on the Rights of Persons with Disabilities (2006) refer, in round brackets, to the Preamble with the relevant Point, e.g. (Preamble Point t), to the Articles with the relevant number, e.g. (Art. 5), and to the Articles of the Optional Protocol with the relevant number e.g. (Protocol Art. 6); the same applies for references to this Convention without direct quotations in the text;
- quotations from the text of the United Nations Standard Rules on the Equalization of Opportunities for Persons with Disabilities (1993) carry, again in round brackets, the label Standard Rules, e.g. (Standard Rules);
- references to other sections of the manual are indicated by the section number in round brackets, e.g. (see section 3.2.3).

Quotations from the Convention on the Rights of Persons with Disabilities and the United Nations Standard Rules on the Equalization of Opportunities for Persons with Disabilities refer to the official texts.

Тайлбар


Энэхүү гарын авлагад хөгжлийн бэрхшээлийн тухай хүний эрхэд суурилсан хандлага бүхий олон улсын үндсэн баримт бичгийн зүйл заалтаас иш татсан болно. Ишлэлүүдийн эх сурвалжийг үзэхийн тулд уншигч та дараах зүйлийг анхаарна уу:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн (2006) холбогдох зүйл заалтаас иш татсан тохиолдолд түүнийг дугуй хаалтанд оруулж бичсэн. Тухайлбал: Оршил хэсгээс ишлэсэн бол (Оршил, Заалт t), Конвенцийн холбогдох заалтаас ишлэсэн бол (5 дугаар зүйл), Нэмэлт протоколын холбогдох дугаар бүхий заалтаас ишлэсэн бол (Протокол. 6 дугаар зүйл) гэх мэтээр тэмдэглэсэн болно. Түүнчлэн гарын авлагад шууд үгчлэн ишлээгүй конвенцийн зүйл заалтыг энэ мэтчилэн тэмдэглэсэн.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох Нэгдсэн Үндэстний Байгууллагын Стандарт Дүрэм (1993)- ээс иш татсанг мөн дугуй хаалтан дотор Стандарт дүрэм гэж бичсэн байна. (Стандарт Дүрэм) гэх мэт.
- Энэхүү гарын авлагын өөр хэсгээс дахин ишлэсэн бол мөн дугуй хаалтанд эх сурвалж болсон хэсгийн дугаарыг тавьсан байна. Тухайлбал (хэсэг 3.2.3 –аас үзнэ үү)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох Нэгдсэн Үндэстний Байгууллагын Стандарт Дүрмээс авсан ишлэлүүдийг албан ёсны эх сурвалжаас нь үзнэ үү.

Chapter 1

Key Training Concepts



1. Key Training Concepts

Learning Goals

The participants will gain a basic knowledge of:

- the UN and international institutions related to disability and human rights;
- the basic concepts of human rights legislation and culture.

1.1 Introduction to Human Rights

1.1.1 The history of human rights and the Universal Declaration of Human Rights

1.1.1.1 Brief history of the concept of human rights

The history of the concept of “human rights” reveals its historical evolution and political and social use from the Second World War until the Universal Declaration of Human Rights (1948). Since then the international instruments protecting human rights have broadened and developed, including at the regional level. The universality, indivisibility, interdependence and interrelation of all human rights and fundamental freedoms are universally accepted. Disability is a new area of action in the protection of human rights.

1.1.1.2 The human rights context at the level of the continent and national culture

Declarations and conventions have multiplied, affecting different cultures and institutions and various continents (Europe, the Americas, Africa, the Middle East and North Africa region, Asia and the Pacific region).

1.1.2 The cultural, political and legal motivations that form the basis for the protection of human rights

1.1.2.1 Protection of people at risk of human rights violations

Protection mechanisms derive from the realization that discrimination and human rights violations affect various specific groups, which the United Nations have recognized as women, immigrants, children and people with disabilities.

Бүлэг 1

1. Сургалтын гол агуулга



1. Сургалтын гол агуулга

Хичээлийн зорилго:

Оролцогчид дараах үндсэн мэдлэгийг олж авна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээл болон хүний эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд (Нэгдсэн үндэстний байгууллага болон бусад);
- Хүний эрхийн талаарх хууль, тогтоомж, соёлын үндсэн ойлголт.

1.1 Хүний эрхийн талаарх ерөнхий ойлголт

1.1.1 Хүний эрх, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын түүх

1.1.1.1 Хүний эрхийн ойлголтын товч түүх

“Хүний эрх”-ийн ойлголтын талаарх түүхэнд дэлхийн Хоёрдугаар дайнаас Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (1948)-ыг батлах хүртэлх хугацаанд түүний улс төр, нийгмийн хэрэглээ болон түүхийн хувьслыг хамруулж үзнэ. Түүнээс хойш хүний эрхийг хамгаалах олон улсын баримт бичгүүд бий болж бүсийн түвшинд хүртэл өргөжин хөгжсөөр байна. Хүний бүх эрх, үндсэн эрх чөлөө нь түгээмэл, хуваагдашгүй, харилцан хамааралтай, уялдаа холбоотой болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн билээ. Хөгжлийн бэрхшээлийн асуудал нь хүний эрхийг хамгаалахүйл ажиллагааны нэг шинэ талбар болон гарч ирсэн.

1.1.1.2 Бүс нутгийн болон үндэсний соёлын түвшин дэх хүний эрхийн ойлголт

Тунхаглал болон конвенцуудын үзэл санаа түгэн дэлгэрч, өөр өөр соёл иргэншил, байгууллагууд, тивүүд (Европ, Америк, Африк, Зүүн дундад болон Хойд Африкийн бүс, Ази Номхон далайн бүс)-д нөлөөлсөөр байна.

1.1.2 Хүний эрхийг хамгаалах үндсийг бүрдүүлсэн соёл, улс төр, хууль эрх зүйн үндэслэл

1.1.2.1 Эрх нь зөрчигдөх эрсдэлд байгаа хүмүүсийг хамгаалах

Хамгаалах механизм нь НҮБ-ын тодорхойлсноор эмэгтэйчүүд, цагаачлагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүүхдүүд гэх мэт онцлог бүлгийн хүмүүсийн эрхийг зөрчигдөж, алагчлалд өртөж байгаа эсэхийг илрүүлж, тогтооход чиглэгддэг.

1.1.2.2 Development of standards for an equitable treatment of people

The United Nations international Convention has become a leading human rights protection mechanism, with a corpus of norms and sentences representing the evolution of international law produced by national and international courts

1.1.2.3 Development of a universal human rights protection system

The international human rights system has been evolving and spreading to the various continents (e.g. international and regional legal mechanisms and special courts of justice). International bodies exist to control and monitor the application of the norms of the various conventions.

1.2 International Institutions Based on Human Rights and their Operation

1.2.1 Brief history of the United Nations and its structure

1.2.1.1 UN General Assembly, Security Council and Economic and Social Council

The United Nations was formed in 1946 and is based on three pillars: the United Nations General Assembly, currently made up of 191 countries; the Security Council, made up of five countries with the right of veto (China, France, the United Kingdom, Russia and the United States of America) and 10 other countries in rotation; and the Economic and Social Council which involves different regional offices and various responsibilities.

1.2.1.2 United Nations agencies: ILO, WHO, UNESCO and UNICEF

Over time the United Nations agencies have been created, each with specific responsibilities. The brief history of the International Labour Organization, World Health Organization, United Nations Educational, Scientific and Cultural Organization and UNICEF shows how responsibilities concerning disability have been progressively developed.

1.2.2 Brief history of other relevant regional institutions

The regional institutions that either have responsibility for human rights or have approved documents in this field are the European Communities, Council of Europe, Organization of American States, League of Arab States, Organization of African Unity/African Union and Association of Southeast Asian Nations (ASEAN).

Chapter 1. Key Training Concepts

1.3 The United Nations Conventions

1.3.1 Brief history of the conventions approved by the United Nations

1.3.1.1 The motivations for a convention on human rights

The conventions came about because of the documentation of human rights violations against people with certain characteristics who were the object of social stigma. Awareness of the need for international human rights protection mechanisms became clear after the Second World War, when the horrors of the Nazi regime against people with disabilities (the T4 Program), the Romany people and the Jews became well-known. At that time the United Nations approved the Universal Declaration of Human Rights (1948), which in 30 articles lays out the set of human rights requiring protection. Human rights violations against people with disabilities have been highlighted by studies, research and legal charges laid.

1.3.1.2 Procedures for approval and operation

The establishment of a human rights convention is based on the maximum consensus possible between the Member States of the UN; it is discussed in bodies defined by the General Assembly. When there is agreement on a text it is put before the General Assembly for approval and the ratification process begins. This consists of the signing of the convention and the process of absorbing the convention into national legislation, after having verified that its norms are consistent with national laws. A convention enters into force when a certain number of countries have ratified it. At that point an international body is nominated with the task of monitoring application and supporting the implementation process. These bodies receive periodical national reports on the monitoring and implementation of conventions by the ratifying states.

1.3.1.3 Brief description of the seven UN Conventions on human rights

- Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination (1965)
- International Covenant on Civil and Political Rights (1966)
- International Covenant on Economic, Social and Cultural Rights (1966)
- Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women (1979)
- Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (1984)
- Convention on the Rights of the Child (1989)
- International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families (1990)

1.1.2.2 Хүмүүст тэгш хандах стандартуудыг боловсруулах

Нэгдсэн Үндэстний Байгууллагын олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцууд нь улс орнууд болон олон улсын шүүхүүдийн бий болгосон олон улсын эрх зүйн хувьсал өөрчлөлтийг илэрхийлсэн өгүүлбэр, хэм хэмжээнүүдийн эмхэтгэл болж хүний эрхийг хамгаалах тэргүүлэх механизм болсон.

1.1.2.3 Түгээмэл хүний эрхүүдийг хамгаалах тогтолцоог боловсруулах

Олон улсын хүний эрхийн тогтолцоо нь бүхий л бүс нутагт (тухайлбал: олон улсын болон бүсийн хууль эрх зүйн механизм, шударга ёсны тусгай шүүх) тархаж, хувьсаж өөрчлөгдсөөр байна. Төрөл бүрийн конвенцуудын хэрэгжилтийг хянах олон улсын институтууд байдаг.

1.2 Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагууд

1.2.1 Нэгдсэн Үндэстний Байгууллагын түүх, түүний бүтцийн талаарх товч танилцуулга

1.2.1.1 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, Аюулгүйн зөвлөл болон Эдийн засаг нийгмийн зөвлөл

Disability is a cause and an effect of poverty. The differential treatment that people with disabilities undergo has produced a social impoverishment in access to rights, goods and services that combines and often multiplies with economic poverty in a negative cycle that leads to social exclusion. For this reason, people with disabilities represent almost half the world's poor, given that more than 80% of these people live in developing countries (Preamble Point t). In order to break this vicious circle it is necessary to act both by changing society's approach to people with disabilities and by working with these people for individual and social empowerment. The United Nations global initiative against poverty, the Millennium Development Goals, should focus on people with disabilities as a priority.

2.3.2.8 Social inclusion

In order to transform a society that excludes and discriminates, it is necessary to aim for the construction of inclusive societies, in which everyone can participate and contribute to the development of society. The path from exclusion to integration produces a presence in society of people with disabilities who adapt to rules that have already been established by the community that receives them. Inclusion, meanwhile, is a process that provides for the people included to have the same opportunities and decision-making powers on how to organize society as others. Inclusion is a right based on the full participation of people with disabilities in all aspects of life, on an equal footing with others, without discrimination, respecting dignity and valuing human diversity, through appropriate action: overcoming of obstacles and prejudices and support based on mainstreaming in order to live in local communities.

2.3.2.9 Participation

The construction of inclusive societies implies that the people included are protagonists in the process of inclusion, as experts on the way in which society must treat them. This means that people with disabilities must be present with the same opportunities as other members of society in decisions on all policies, action and plans that concern them. Therefore, the participation of people with disabilities and organizations that represent them is a necessary methodology/action, based on the slogan/right "Nothing about us without us".

Chapter 2. The Condition of People with Disabilities

2.3.2.10 Inclusive development

Economic development theories consider the creation of a group of people who are excluded from the benefits of development to be a necessary consequence of this development. Development mechanisms are in fact often tied to conditions of disadvantage and unequal opportunities created by society itself. In the case of people with disabilities these conditions are found to be caused by mechanisms of discrimination and social exclusion that the United Nations Convention has made clear. On this basis the necessity arises for inclusive development that does not produce mechanisms of social and economic impoverishment but ensures respect for the human rights of all citizens.

2.3.2.11 Human diversity

The condition of disability is an experience that all human beings have lived, live and will live through. It is therefore important to consider disability as one of the features of human diversity. The history of negative cultural views and of the treatment that some characteristics of human beings have undergone over the centuries has given people with disabilities a social stigma, loading these characteristics (and therefore all the people who possess them) with social undesirability. It is therefore important to include disability as one of the many differences that distinguish human beings, placing disability among the ordinary characteristics of human beings and removing social stigma.

2.4 The Situation of People with Disabilities within the Country

2.4.1 Available statistical data

Underline the importance of statistics concerning disability, which give the opportunity to know and monitor the status of actions, policies and legislation in a country. Illustrate the condition of the people with disabilities of the country in various areas related to rights using the available data, publications and reports.

2.4.2 National disability policies

Illustrate the policies, legislation and actions towards the country's people with disabilities and emphasize the working agenda at national level, highlighting the interrelationships with the contents of the Convention.

2.4.3 Evaluative elements and the requirements of the movement of people with disabilities

Have the organization of people with disabilities present its evaluations of national policies and the high-priority requirements that arise from them in the agenda.

Бүлэг 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдал

2.3.2.7 Нийгмийн ядуурал ба хууль ёсны эрх мэдэл

Хөгжлийн бэрхшээл нь ядуу болох шалтгаан төдийгүй түүний үр дүн юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ялгаатай харьцах харьцаа нь тэднийг эрхээ эдлэх, бараа, үйлчилгээнд хүрэх хүртээмжийг бууруулж нийгмийн ядуурлыг бий болгодог. Улмаар энэ нь эдийн засгийн ядууралтай хавсарч тэднийг нийгмээс тусгаарлахад хүргэж, сөрөг эргэх холбоо үүсгэдэг. Тийм учраас дэлхий дээрх ядуу хүмүүсийн бараг тэн хагасыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлж, тэдгээр хүмүүсийн 80-аас дээш хувь нь хөгжиж байгаа оронд амьдарч байна (Оршил. Заалт t). Энэхүү “эмгэнэлтэй” тойргийг таслахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах нийгмийн хандлагыг өөрчлөх, мөн тэдгээр хүмүүстэй биечилж ажиллаж, нийгмийн оролцоог нь дэмжих нь чухал. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зохион байгуулж буй ядуурлын тэмцэх дэлхий нийтийн үйл ажиллагаа болох Мянганы Хөгжлийн Зорилтууд ч мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэн тэргүүнд анхаарах ёстой.

2.3.2.8 Нийгэмт хамрагдалдт (Нийгэмшүүлэх)

Алагчилж тусгаарладаг нийгмийг өөрчлөхийн тулд хүн бүр нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломжтой, оролцоог хангасан хамтач нийгмийг бий болгохыг зорих нь чухал. Тусгаарлагдсан байдлаас ангижирч нийгэмд хамрагдах жим нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь дүрэм журмыг дагадаг, хамт олон нь тэднийг хүлээн зөвшөөрсөн байх байдлыг бий болгоход оршино. Нийгэмшүүлэх гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ижил тэгш боломж болон өөрийн амьдарч буй орчноо зохион байгуулах талаар шийдвэр гаргах эрх мэдлээр бусдын нэгэн адил хангагдах явц юм. Түүнчлэн энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдралын бүхий л хүрээнд бусадтай эн зэрэгцэн, ямар нэг алагчлалгүйгээр, нэр төр, эрхэм зэргээ хүндэтгүүлж, ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрүүлсэн байдлаар, өөрийн хүрээлэн орчиндоо амьдрахад дөхөм үзүүлэхүйц ерөнхий чиг хандлагад нийцсэн дэмжлэгийг хүртэж, тулгарах саад бэрхшээл, шударга бус байдлыг даван туулах гэх мэт зохих үйл ажиллагаа явуулах эрх мөн.

2.3.2.10 Оролцоо

Хүн бүрийг хамаарах нийгмийг бүтээн байгуулахад нийгмийн гишүүд энэ үйл явцыг манлайлж, нийгэм тэдэнтэй хэрхэн харьцах арга замын талаар мэргэжилтэн болж оролцоно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь тэдэнд хамаатай бүхий л бодлого, үйл ажиллагаа, төлөвлөгөөний талаар гаргах шийдвэрт нийгмийн бусад гишүүдийн нэгэн адил ижил тэгш оролцох ёстой. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийг төлөөлдөг байгууллагуудын оролцоо нь “Бидэнгүйгээр бидний тухай юу ч байхгүй” гэсэн уриа, /эрхэд суурилсан чухал арга зам/ үйл ажиллагаа юм.

Бүлэг 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдал

2.3.2.11 Хүн бүрт хамааралтай хөгжил

Эдийн засгийн хөгжлийн онолууд ямарваа хөгжлийн үр дүнд түүнээс ашиг хүртэж чадахгүй хүмүүсийн бүлэг бий болдог гэж үздэг. Хөгжлийн механизмууд ихэнхдээ нийгмийн өөрийнх нь бүтээсэн тэгш бус боломж, дутагдалтай нөхцөл байдлаар хүлэгдсэн байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд алагчлалын болон нийгмийн гадуурхалтаас болж ийм нөхцөл орж байгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенци нотолсон. Энэхүү үндэс суурь дээр тулгуурлан нийгэм, эдийн засгийн ядуурлын механизмыг бий болгох биш, харин бүх иргэдийн хүний эрхийг хүндлэхийг баталгаажуулдаг хүн бүрт хамааралтай хөгжлийн хэрэгцээ гарч ирж байна.

2.3.2.12 Хүний ялгаатай байдал

Бүх хүн төрөлхтөн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч ч байсан, амьдарч ч байна, цаашид ч амьдарсаар байх болно. Тийм учраас хөгжлийн бэрхшээлийг хүний ялгаатай байдлуудын нэг нь гэж ойлгох нь чухал. Хүний ялгаатай төрх байдлын талаарх соёлын сөрөг үзэл бодол болон сөрөг харьцааны талаар түүхээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь нийгмийн гутамшиг, нийгмийн хүсээгүй төрх байдал (ийм хүмүүсийн хувьд) гэж хэдэн зууны туршид үзэгдсээр ирсэн. Тиймээс хөгжлийн бэрхшээлийг хүн төрөлхтөний ялгаатай төрх байдлуудын ердийн нөхцөлд оруулж, нийгмийн сөрөг үзэл бодлыг арилгаж, түүнийг хүн төрөлхтөний олон ялгаануудын нэг нь гэж ойлгох нь чухал.

2.4 Тухайн орны Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн нөхцөл байдал

2.4.1 Статистикийн тоо баримт

Тухайн орны хөгжлийн бэрхшээлийн талаарх хууль, тогтоомж, бодлого, явуулж байгаа үйл ажиллагааны байдалд хяналт тавих, түүний талаар мэдэх боломжийг олгохуйц чухал статистикийн тоо баримтуудыг онцлон тэмдэглэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх төрөл бүрийн салбарт олдоцтой тайлан, мэдээ, ном, гарын авлага, тоо баримтыг ашиглаж нөхцөл байдлыг дүрсэл.

2.4.2 Хөгжлийн бэрхшээлийн талаарх үндэсний бодлого

Тухайн орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг дүрсэл, мөн Конвенцийн агуулгатай харилцаа хамаарлыг тодруулж үндэсний түвшинд гаргасан ажлын төлөвлөгөөг онцлон тэмдэглэ.

2.4.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлгөөний шаардлага, ба үнэлэх элементүүд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудаар өөрийнхөө үндэсний бодлогыг үнэлүүлж, ажлын төлөвлөгөөнд тэднээс нэн тэргүүнд шаардлагатай зүйлүүдийг тодорхойлуул.

Chapter 3

The United Nations Convention on the Rights of Persons with Disabilities



3. The United Nations Convention on the Rights of Persons with Disabilities

Learning Goals

The participants will gain a basic knowledge of:

- the text of the Convention on the Rights of Persons with Disabilities;
- the main concepts of legal protection and support for disability policies;
- the process of ratifying, monitoring and implementing the Convention.

3.1 The Structure, Principles and Obligations of the Convention

3.1.1 History of the Convention

As far back as 1987 and 1989 Italy and Sweden had put forward a proposal for a convention, which was rejected by the United Nations. Following the approval of a document at the United Nations World Conference against Racism in Durban (South Africa) in September 2001, Mexico presented a Resolution, which was approved by the General Assembly (Resolution 56/168, 19 December 2001), to form an Ad Hoc Committee that would verify the need to draw up a Convention on the Rights of Persons with Disabilities. At the 3rd session of the AHC (June 2003) it was decided that the Convention was needed and a working group was appointed to prepare a draft text (February 2004). At the 6th session of the AHC (August 2005) the chairman undertook to prepare a text summarizing the discussion so far (October 2005). At the 7th and 8th sessions the text was negotiated and approved (25 August 2006); then it was submitted to the General Assembly which finally approved it on December 13 2006. This was the United Nations Convention approved in the shortest ever time and with the greatest participation of civil society: throughout the writing and negotiating process the International Disability Caucus (which involved around 70 associations of people with disabilities and their families) played an important and at times decisive role, mobilizing energies from all over the world. In the August 2006 session 800 representatives of non-governmental organizations were present and 50 official government delegations included people with disabilities as experts.

Бүлэг 3

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц



3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц

Хичээлийн зорилго

Оролцогчид дараах үндсэн мэдлэгийг олж авна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн эх бичвэр
- Хөгжлийн бэрхшээлийн талаарх бодлогыг хуулиар хамгаалах, дэмжих гол ойлголтууд
- Конвенцийг соёрхон батлах, хяналт тавих, хэрэгжүүлэх явц

3.1 Конвенцийн бүтэц, зарчим, үүрэг

3.1.1 Конвенцийн түүх

1987, 1989 онуудад Итали, Швед улсууд конвенц боловсруулах санал тавьж Нэгдсэн Үндэстний Байгууллага татгалзсан билээ. 2001 оны 9 дүгээр сард Дурбанд (Өмнөд Африк) болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Арьс өнгөний эсрэг Дэлхийн Бага Хурал дээр батлагдсан баримт бичиг, мөн Мексикийн танилцуулж, Ерөнхий Ассамблейгаар батлагдсан (2001 оны 12 дугаар сарын 19, Тогтоол 56/168) Түр Хороо байгуулах тухай Тогтоол гарснаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн хэрэгцээ, шаардлагыг улам бүр баталгаажуулсан. Түр Хорооны 3 дугаар чуулганаар (2003 оны 6 дугаар сар) Конвенц гарах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн бөгөөд эх бичвэрийн төслийг бэлтгэх ажлын хэсгийг томилсон (2004 оны 2 дугаар сар). Түр Хорооны 6 дугаар чуулганаар (2005 оны 8 дугаар сар) хорооны дарга эх бичвэрийг эцэслэх хэрэлцүүлэгт бэлтгэх үүрэг авсан бөгөөд хэлэлцээ явагдаж эхэлсэн (2005 оны 10 дугаар сар). Долоо, наймдугаар чуулганаар эх бичвэрийн талаар зөвшилцөлд хүрч, батлагдсан (2006 оны 8 дугаар сарын 25) бөгөөд, дараа нь Ерөнхий Ассамблейд өргөн барьсан бөгөөд 2006 оны 12 дугаар сарын 13нд Конвенц батлагдсан юм. Энэ нь хамгийн бага хугацаанд, иргэний нийгмийн оролцоо сайтай байж батлагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц болсон юм. Эх бичвэрийг боловсруулах болон хэлэлцээ хийх явцад Олон улсын хөгжлийн бэрхшээлийн иргэдийн байгууллагуудын холбоо (70 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн нийгэмлэгүүдийг хамруулсан) нь дэлхийг тэр аяар нь хөдөлгөөнд оруулж, шийдвэр гаргах чухал үүрэгтэйгээр оролцсон. 2006 оны 8 дугаар сарын чуулганд иргэний нийгмийн байгууллагуудын 800 төлөөлөгч, 50 орны засгийн газраас томилогдсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөгчид шинжээчийн үүрэгтэйгээр оролцсон юм.

3.1.2 Description of the structure of the Convention

The Convention on the Rights of Persons with Disabilities consists of a preamble, which includes the motivations, references to documents and general considerations that inspired the writing of the convention, and the 50 articles, which can be divided into: general principles and obligations that apply to all the articles (Arts. 1-7); specific obligations that concern particular areas (Arts. 9-32); the national (Art. 33) and international monitoring system, with the establishment and regulation of the international Committee (Arts. 34-40); the procedures for entry into force and the amendment system (Arts. 35-50). The Convention is accompanied by the Optional Protocol, which discusses individual appeals (Arts. 1-8) and the international Committee's inquiries (Art. 6).

3.1.3 The purpose, definitions and principles of the Convention (Arts. 1-3)

The first three articles of the Convention describe the purpose (Art. 1), essential definitions (Art. 2) and principles (Art. 3) on which the whole system is based. It is important to link these articles to the human rights-based approach (see chapter 2). In outlining the Convention it is equally important to bear in mind the motivating and clarifying points contained in the Preamble. Given the universality, indivisibility, interdependence and interrelation of all human rights and fundamental freedoms, it is important to consider them, where necessary, throughout the illustration of the contents of the Convention. Furthermore, given the particular nature of the discrimination and unequal opportunities faced by people with disabilities, the responsibility of the state to treat all citizens with disabilities the same as other people can affect both individuals (who must in any case be protected) and behaviour and barriers related to society as a whole.

3.1.4 Obligations of states (Art. 4)

Article 4 lists and defines the obligations that states take on in ratifying the Convention. These commitments make up an essential frame of reference to which each specific right must be linked. Subsection 2 underlines that, although the convention is to be applied progressively with regard to economic and social rights, this does not prejudice recognized rights "that are immediately applicable according to international law." This means that individuals must in any case not be discriminated against and are protected by the Convention. There is an important recognition of the role of organizations of people with disabilities "in the development and implementation of legislation and policies to implement the (...) Convention, and in other decision-making processes concerning issues relating to persons with disabilities."

3.1.5 Knowledge of other United Nations conventions

The Convention on the Rights of Persons with Disabilities was written with a view to recognizing the rights that were already laid out in previous United Nations conventions, rather than introducing new rights. This means that in interpreting the text it is important to keep the text of the other conventions in mind.

3.2 Recognized Rights and Compliance Methods

3.2.1 Equal treatment and non-discrimination (Art. 5)

The Convention recognizes that “all persons are equal before and under the law and are entitled without any discrimination to the equal protection and equal benefit of the law.” States ratifying the Convention “shall prohibit all discrimination on the basis of disability and guarantee to persons with disabilities equal and effective legal protection against discrimination on all grounds.” “Discrimination on the basis of disability” means “any distinction, exclusion or restriction on the basis of disability which has the purpose or effect of impairing or nullifying the recognition, enjoyment or exercise, on an equal basis with others, of all human rights and fundamental freedoms in the political, economic, social, cultural, civil or any other field. It includes all forms of discrimination, including denial of reasonable accommodation” (Art. 2). From a legal perspective, discrimination means to differentiate between two people or treat them differently when there is actually no significant difference between them or to treat situations that are actually different in the same way. It is important to understand how the comparison between a person with a disability and another person is made, in order to reveal the discriminatory treatment. Discrimination can be direct or indirect. Direct discrimination is when a person is treated less favourably than another is, has been or would be treated in a similar situation, because of his or her disability. Indirect discrimination is when an apparently neutral provision, criterion or practice could particularly disadvantage people with disabilities compared with others. It is important to provide appropriate and easily understandable examples in the context of the country in which the course is being run.

3.1.2 Конвенцийн бүтэц

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц нь конвенцийг үндэслэл, шаардлага, ашиг сонирхолыг илэрхийсэн оршил хэсэг, дараах ерөнхий агуулга бүхий 50 зүйлтэй: ерөнхий зарчим, үүрэг (1-7 дугаар зүйлүүд), тодорхой салбарт хамаарах тусгайлсан үүрэг (9-32 дугаар зүйлүүд), үндэсний (33 дугаар зүйл) болон олон улсын Хороо байгуулах, түүнийг зохицуулах олон улсын хяналтын тогтолцоо (34-40 дүгээр зүйлүүд), хүчин төгөлдөр болох процедур болон нэмэлт оруулах тогтолцоо (35-50 дугаар зүйлүүд). Конвенцид хувь хүний гомдол гаргах эрх (1-8 дугаар зүйлүүд) болон олон улсын хорооны хяналт шалгалт хийх эрхийг (6 дугаар зүйл)-г олгосон Нэмэлт Протоколтой.

3.1.3 Конвенцийн зорилго, тодорхойлолт, зарчим (1-3 дугаар зүйлүүд)

Конвенцийн эхний гурван зүйл нь түүний зорилго (1 дүгээр зүйл), үндсэн тодорхойлолт (2 дугаар зүйл), зарчим (3 дугаар зүйл)-ыг тодорхойлсон байдаг. Эдгээр зүйлүүдийг хүний эрхэд суурилсан хандлага (Бүлэг 2-ыг үзнэ үү)-тай холбох нь чухал. Конвенцийн Оршил хэсэгт орсон заалтуудыг тодорхой ойлгож байх нь чухал. Бүх хүн төрөлхтний эрх, үндсэн эрх чөлөөний түгээмэл, хуваагдашгүй, харилцан хамааралтай, уялдаа холбоотой байдлыг Конвенцийн үзэл санаатай уялдуулан шаардлагатай үед нь анхаарч үзэх хэрэгтэй. Алагчлал болон тэгш бус боломж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч байдгийг арилгахад тухайн улс орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй бусдын нэгэн адил харьцах хариуцлага нь хувь хүнд ч (ямар ч тохиолдолд хувь хүн хамгаалагдах ёстой), мөн нийгэмтэй холбоотой саад бэрхшээл, зан төрхөд ч нөлөөлдөг.

3.1.4 Улс орнуудын үндсэн үүрэг (4 дүгээр зүйл)

4 дүгээр зүйлд Конвенцийг соёрхон батлахад улс орнуудын хүлээх үндсэн үүргүүдийг тодорхойлсон байна. Эдгээр нь тодорхой эрх бүрт хамааралтай ерөнхий үүргийн хүрээ мөн. Конвенцид заасан эдийн засаг, нийгмийн шинжтэй эрхүүдийг оролцогч улс аажмаар урагшуулан хэрэгжүүлэх боловч энэ нь “олон улсын хуулийн дагуу яаралтай арга хэмжээ авна” гэсэн эрхэд хохирол учруулахгүй гэж 2 дугаар дэд хэсэг тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, хувь хүмүүс ямар ч тохиолдолд алагчлалд өртөх ёсгүй бөгөөд Конвенцоор хамгаалуулах ёстой гэсэн үг. “(...) Конвенцийг хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоомж болон бодлогыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэхэд, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой шийдвэр гаргах явцад” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрөх нь чухал.

Бүлэг 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Эрхийн тухай НҮБ-ын Конвенц

3.1.5 НҮБ-ын бусад гэрээ, конвенцуудын тухай мэдлэг

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид заасан шинэ эрхүүдийг танилцуулахаас гадна НҮБ-ын өмнөх конвенцуудад тусгагдсан эрхүүдийн талаар мэдлэг олгохыг зорьсон. Өөрөөр хэлбэл, эх бичвэрийг орчуулахдаа бусад конвенцуудын зүйл заалтыг санаж байх хэрэгтэй.

3.2 Хүлээн зөвшөөрөгдсөн эрхүүд ба тэдгээрийг хэрэгжүүлэх аргууд

3.2.1 Тэгш харилцаа ба үл алагчлал (5 дугаар зүйл)

“Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар нэг алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулж, адил ашиг хүртэх эрхтэй” гэж Конвенц үздэг. Конвенцийг соёрхон баталж байгаа улс орнууд “хөгжлийн бэрхшээлээс нь болж гарах алагчлалын бүх хэлбэрийг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлалын эсрэг эрх зүйн хамгаалалт бий болгож, баталгаажуулна.” “Хөгжлийн бэрхшээлээс нь болж алагчлах” гэдэг нь “улс төр, эдийн засаг, нийгэм, иргэний болон бусад салбарт хүн бүрийн эдлэх ёстой эрх, үндсэн эрх чөлөөнд хохирол учруулах буюу үгүйсгэх зорилгоор хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас ямар нэгэн байдлаар ялгах, гадуурхах, хязгаарлахыг хэлнэ. Үүнд тохирох хэрэгслийг эс зөвшөөрч, хангахгүй байх алагчлалын бүх хэлбэрүүд хамрагдана (2 дугаар зүйл). Хууль зүйн талаасаа алагчлал гэдэг нь хоёр хүнийг хооронд нь ялгах, эсвэл тэдгээрийн хооронд онцгой чухал ялгаа байхгүй байхад тэдэнтэй өөрөөр харьцах эсвэл өөр орчинд ижил аргаар харилцах гэсэн агуулгатай. Алагчилж байгааг илрүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүн болон өөр хүн хоёрыг хооронд нь хэрхэн харьцуулах ёстойг мэдэж байх нь чухал. Алагчлал нь шууд ба шууд бус байж болно. Хэрэв тухайн хүнтэй хөгжлийн бэрхшээлээс нь болж ижилхэн харьцах ёстой өөр хүнээс арай доогуур байдалтайгаар харьцвал түүнийг шууд алагчлал гэнэ. Завсрын хангамж, шалгуур үзүүлэлт, эсвэл практик нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдлыг бусадтай харьцуулахад дордуулж байгаа бол үүнийг шууд бус алагчлал гэнэ. Сургалт хийж байгаа оронд түгээмэл, ойлгоход хялбар жишээг ашиглах энэ ойлголтыг тайлбарлах хэрэгтэй.

3.2.2 Reasonable accommodation (Art. 5)

The Convention states that “in order to promote equality and eliminate discrimination,” ratifying states “shall take all appropriate steps to ensure that reasonable accommodation is provided” to victims of violations of the human rights recognized in the Convention. “Reasonable accommodation” means “necessary and appropriate modification and adjustments not imposing a disproportionate or undue burden, where needed in a particular case, to ensure to persons with disabilities the enjoyment or exercise on an equal basis with others of all human rights and fundamental freedoms” (Art. 2). The concept of reasonable accommodation varies from country to country, according to cultural considerations, the legal protection system, rights protection policies and existing legislation. The interpretation of the word “reasonable” is influenced by cultural and material factors (i.e. what action is considered reasonable in a particular country for a person with a disability), as is the concept of “disproportionate or undue burden” (which depends on the wealth of the country, the resources that are available and therefore investable, and the level of rights recognition); equally, the interpretation of the word “accommodation” can vary on the basis of, for example, the technology available. It should nevertheless be remembered that based on article 4 subsection 2 of the Convention (see section 3.1.4) the lack of financial resources cannot prejudice recognized rights “that are immediately applicable according to international law.” Furthermore, the “denial of reasonable accommodation” is considered discrimination (Art. 2).

3.2.3 Recognition of rights present in other conventions (Arts. 10, 13-18, 29-30)

In the Convention there are many articles that recognize rights already recognized in other United Nations conventions, while nevertheless introducing appropriate methods of access to and enjoyment of these rights. When outlining these articles the other conventions must be kept in mind.

3.2.4 New rights: Accessibility, Living Independently and Personal Mobility

The Convention introduces protection for rights that can only be recognized for people with disabilities, specifically “accessibility” (Art. 9), “living independently” (Art. 19) and “personal mobility” (Art. 20). This means that it actually recognizes new forms of legal protection tied to the particular nature of the discrimination and unequal opportunity faced by people with disabilities. Of particular importance is the overcoming of institutionalizing practices (Art. 19), which can be connected to the right to not be subjected to torture or cruel, inhuman or degrading treatment or punishment (Art. 15).

3.3 Analysis of the Articles

3.3.1 Structural articles that spell out obligations and protections (Arts. 1-5)

It is important to show that the reading and interpretation of the Convention is based on the understanding of what can be defined as the “structural” articles, which must be used as a basis for explaining and interpreting the obligations and protections fundamental to the rights recognized in each individual article. These articles must, therefore, always be kept in mind when outlining the contents of the Convention.

3.3.2 Topic areas

3.3.2.1 Multiple discrimination (Arts. 6 and 7)

The Convention dedicates particular protection to people with disabilities who are subject to greater risk of discrimination, namely women (Art. 6) and children (Art. 7). These two articles must, therefore, be used as legal instruments that reinforce the protection of women and children with disabilities in all the articles of the Convention. Furthermore, given the existence of the Convention on the Rights of the Child and the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women, these documents interact with the contents of the Convention. In particular, the principles of inclusion and mainstreaming of actions and policies aimed at children with disabilities are reinforced, while the 1989 Convention relegated these principles to article 23, with a logic that was still based on special care. With regard to the protection of the rights of children with disabilities, subsections 3, 4, and 5 of article 23 (Respect for home and the family) should also be kept in mind.

3.3.2.2 Physical access and Universal Design (Arts. 9, 18-21)

Article 9 of the Convention requires ratifying states to “take appropriate measures to ensure to persons with disabilities access (...) to the physical environment, to transportation, to information and communications, including information and communications technologies and systems, and to other facilities and services open or provided to the public, both in urban and in rural areas” in order to “enable persons with disabilities to live independently and participate fully in all aspects of life.” This article must be linked to articles 19 (Living independently and being included in the community) and 20 (Personal mobility), as well as articles 18 (Liberty of movement and nationality) and 21 (Freedom of expression and opinion, and access to information).

3.2.2 Тохирох хэрэглэгдэхүүн (5 дугаар зүйл)

“Алагчлалыг устгаж, ижил тэгш дэмжихийн тулд” Конвенцийг соёрхон баталж байгаа улс орнууд Конвенцид тодорхойлсон хүний эрхүүд нь зөрчигдсөн хохирогчид “тохирох хэрэглэгдэхүүнээр хангах бүх арга хэмжээг авах ёстой” гэж заасан байна. “Тохирох хэрэглэгдэхүүн” гэдэг нь “тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс хэт их эсвэл хэт бага ачаа, саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулах болон өөрчлөх хэрэгсэл” юм (2 дугаар зүйл). Тохирох хэрэглэгдэхүүний ойлголт нь өөрийн соёлын үзэл бодол, хуулийн хамгаалалтын тогтолцоо, эрхийг хамгаалах бодлого, одоо байгаа хууль дүрэм гэх мэтийн зүйлүүдээс болоод орон оронд харилцан адилгүй байдаг. Энэ нь “хэт их эсвэл хэт бага ачаа, саад тотгор” (тухайн орон хэр баян, нөөц бололцоо нь хэр олдцотой, хөрөнгө оруулж чадах эсэх нь мөн хүний эрхийг хэрхэн таньж ойлгодог эсэхээс хамаарна)-ын тухай ойлголт учраас “Тохирох” гэдэг үгийг орчуулахад соёлын болон материаллаг хүчин зүйлүүд (тухайлбал: тухайн оронд хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд ямар ажиллагаа тохиромжтой, боломжийн байх вэ) нөлөөлнө; үүний нэгэн адилаар “хэрэглэгдэхүүн” гэдэг үгийг орчуулахад тухайлбал: олдцотой технологиос хамаарч харилцан адилгүй орчуулагдана. Конвенцийн 4 дүгээр зүйл, 2 дугаар дэд хэсэгт (3.1.4. хэсгийг үзнэ үү) үндэслэн санхүүгийн нөөц бололцоо нь “олон улсын хуулийн дагуу яаралтай арга хэмжээ авна” гэсэн эрхийг хохироож чадахгүй гэдгийг анхаарах ёстой. Цаашилбал “тохирох хэрэглэгдэхүүнийг үгүйсгэх” нь алагчлалд тооцогдоно (2 дугаар зүйл).

3.2.3 Бусад конвенцуудад тусгагдсан эрхүүд (10, 13-18, 29-30 дугаар зүйлүүд)

Энэ Конвенцид бусад НҮБ-ын конвенцуудар баталгаажуулсан эрхүүдийг тодорхойлсон олон зүйл, заалт бий бөгөөд тэдгээр эрхүүдийг эдлэхэд тохиромжтой арга замуудыг тодорхойлсон байдаг. Эдгээр зүйлүүдийн утга агуулгыг тайлбарлахдаа бусад конвенциудын заалтыг санаж байх ёстой.

3.2.4 Шинэ эрхүүд: Хүртээмж, Бие дааж амьдрах, Хувийн хөдөлгөөнт байдал

Конвенциор зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай эрхүүдийг баталгаажуулсан. Тухайлбал: “хүртээмж” (9 дүгээр зүйл), “бие дааж амьдрах” (19 дүгээр зүйл), “хувийн хөдөлгөөнт амьдрал” (20 дугаар зүйл). Өөрөөр хэлбэл эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч байдаг тэгш бус боломж, алагчлалын онцгой хэлбэрүүдээс хуулиар хамгаалах шинэ хэлбэрүүд юм. Онцгой нэгэн чухал ач холбогдол нь эрүүдэн шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх (15 дугаар зүйл)-ээс ангид байх эрхтэй холбоотой байж болох институтын практикийг (19 дүгээр зүйл) даван гарч байгаа явдал юм.

3.3 Зүйл, заалтуудыг шинжлэхүй

3.3.1 Үүрэг, хамгаалалтын тухай “тулгуур” заалтууд (1-5 дугаар зүйлүүд)

Конвенцийг зүйл тус бүрт заасан эрхүүдийн хамгаалалт, энэ талаар Оролцогч улсуудын хүлээх үүргийг тайлбарлахад иш үндэс болгох ёстой “суурь” заалтуудад тулгуурлана тайлбарлаж, унших ёстой гэдгийг таниулах нь чухал. Тиймээс Конвенцийн агуулгыг илэрхийлэхэд тэдгээрийг үргэлж санаж байх ёстой.

3.3.2 Хамааралт сэдвүүд

3.3.2.1 Давхар алагчлал (6, 7 дугаар зүйл)

Конвенц алагчлалд өртөмхий хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг, ялангуяа эмэгтэйчүүд (6 дугаар зүйл) болон хүүхдүүд (7 дугаар зүйл)-ийг онцгойлон хамгаалахыг зорьсон. Тиймээс Конвенцийн бүх зүйлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хамгаалахыг бэхжүүлэхийн тулд эдгээр хоёр зүйлийг хууль зүйн хэрэгсэл болгон ашиглах ёстой. Цаашилбал энэхүү Конвенцийн агуулга нь Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенциудтай харилцан хамааралтай байна. Ялангуяа, 1989 оны конвенцийн 23 дугаар зүйлд заасан тусгай тусламж үйлчилгээгээр хангах үзэл санааны дор хуульчлагдсан нийгэмд хамрагдах байдал (нийгэмшүүлэх), хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэгдсэн үйл ажиллагаа, бодлого хөтөлбөрийг ерөнхий чиг хандлагад нийцүүлэх зарчмуудыг ч мөн конвенц дахин баталгаажуулсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хамгаалахын тухайд 23 дугаар зүйлийн 3, 4, 5 дугаар хэсгүүдийг (орон гэр, гэр бүлийг хүндэтгэх) анхааралдаа авах ёстой.

3.3.2.2 Биечлэн оролцох байдал ба төгс хэв маяг (9, 18-21 дугаар зүйлүүд)

Конвенцийн 9 дүгээр зүйл нь “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох” зорилгоор соёрхон баталж байгаа улс орнуудаас “хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийн хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд үйлчлэх бусад төрлийн хэрэгсэл, үйлчилгээг хүртэх явдлыг баталгаажуулахад чиглэгдсэн арга хэмжээг авах”-ыг үүрэг болгодог. Энэ зүйл нь 19 дүгээр зүйл (Бие даан амьдрах болон хамт олон дотроо орох), 20 дугаар зүйл (Хувийн хөдөлгөөнт байдал) болон 18 дугаар зүйл (Чөлөөтэй зорчих болон иргэний харьяалалаа чөлөөтэй сонгох), 21 дүгээр зүйл (Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэлд хүрэх) –тэй холбоотой.

3.3.2.3 Access to rights and social services (Arts. 24-28)

3.3.2.3.1 Education (Art. 24)

The convention requires ratifying states to recognize “the right of persons with disabilities to education,” “without discrimination and on the basis of equal opportunity” and to “ensure an inclusive education system at all levels.” The stated aims of education are important: “full development of human potential and sense of dignity and self-worth, and the strengthening of respect for human rights, fundamental freedoms and human diversity”; “development (...) of (...) personality, talents and creativity, as well as (...) mental and physical abilities” and “enabling persons with disabilities to participate effectively in a free society.”

3.3.2.3.2 Health (Art. 25)

The Convention confirms “that persons with disabilities have the right to the enjoyment of the highest attainable standard of health without discrimination on the basis of disability” and requires ratifying states to “take all appropriate measures to ensure access for persons with disabilities to health services that are gender-sensitive.” Ratifying states must “provide persons with disabilities with the same range, quality and standard of (...) health care and programmes as provided to other persons,” and “provide those health services needed by persons with disabilities specifically because of their disabilities,” “as close as possible to people’s own communities, including in rural areas.”

3.3.2.3.3 Abilitation and rehabilitation (Art. 26)

The convention commits ratifying states to taking “effective and appropriate measures, including through peer support, to enable persons with disabilities to attain and maintain maximum independence, full physical, mental, social and vocational ability, and full inclusion and participation in all aspects of life.” This requires the organization, strengthening and extension of “comprehensive abilitation and rehabilitation services and programmes, particularly in the areas of health, employment, education and social services.” Abilitation and rehabilitation must “begin at the earliest possible stage” and be “based on the multidisciplinary assessment of individual needs and strengths;” “support participation and inclusion in the community and all aspects of society” and be “voluntary” and “available to persons with disabilities as close as possible to their own communities.”

3.3.2.3.4 Work and employment (Art. 27)

The convention commits ratifying states to recognizing “the right of persons with disabilities to work, on an equal basis with others,” including “the right to the opportunity to gain a living by work freely chosen or accepted in a labour market and work environment that is open, inclusive and accessible to persons with disabilities.” Ratifying states “shall safeguard and promote the realization of the right to work, including for those who acquire a disability during the course of employment, by taking appropriate steps.”

3.3.2.3.5 Adequate standard of living and social protection (Art. 28)

The convention commits ratifying states to recognizing “the right of persons with disabilities to an adequate standard of living for themselves and their families, including adequate food, clothing and housing, and to the continuous improvement of living conditions, and shall take appropriate steps to safeguard and promote the realization of this right without discrimination on the basis of disability.” Ratifying states must ensure “equal access (...) to clean water services, and (...) ensure access to (...) services, devices and other assistance for disability-related needs,” “access (...) to social protection programmes and poverty reduction programmes” and “access (...) to assistance from the State with disability-related expenses (...), to public housing programmes (...) [and] to retirement benefits and programmes.”

3.3.2.4 Protection of the private sphere (Arts. 19, 22-23)

Taking the right to independent living and social inclusion as a starting point (Art. 19), ratifying states recognize the right of people with disabilities to an appropriate standard of living for “themselves and their families, including adequate food, clothing and housing, and to the continuous improvement of living conditions, and shall take appropriate steps to safeguard and promote the realization of this right without discrimination on the basis of disability.” Article 23 recognizes “the right (...) to marry and to found a family,” “to decide freely and responsibly on the number (...) of their children” and to maintain “their fertility on an equal basis with others.”

3.3.2.3 Эрхээ эдлэх ба нийгмийн үйлчилгээнүүд (24-28 дугаар зүйлүүд)

3.3.2.3.1 Боловсрол (24 дүгээр зүйл)

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрх”-ийг, “ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр” эдлүүлэх үүднээс Конвенцийг соёрхон баталж байгаа улс орнууд нь “бүх шатны хамран сургалтын тогтолцоог баталгаажуулах”-ыг Конвенц шаардаж байна. Боловсролын дурдсан зорилтууд нь маш чухал юм. Үүнд: “хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хүний ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлж, хүний чадамж, эрхэм зэргийн ойлголт болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлэх”, “(...)хүний хувийн шинж чанар, авъяас чадвар, бүтээлч чанар, мөн (...) оюуны болон бие махбодын чадварыг хөгжүүлэх”, “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох” зэрэг юм.

3.3.2.3.2 Эрүүл мэнд (25 дугаар зүйл)

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийнх нь үндсэн дээр ямар ч алагчлалгүйгээр эрүүл мэндийн дээд түвшинд хүрсэн байх эрхтэй”-г Конвенц баталгаажуулсан бөгөөд соёрхон баталж байгаа улс орнуудыг “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээх эмчилгээг оролцуулан жендерийн мэдрэмжтэй эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах боломжийг баталгаажуулах бүхий л зохистой арга хэмжээг авах”-ыг шаардаж байна. Соёрхон баталж байгаа улс орнууд нь “бусад хүмүүст хүргэдэгтэй нэгэн ижил түвшин, чанар, стандартад эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээ, хөтөлбөрүүдээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хангах” бөгөөд “тэдгээрийг амьдарч байгаа хамт олон дотор (хөдөө орон нутагт) нь аль болохоор ойр байлгаж” “шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээг тэдгээр хүмүүсийн хөгжлийн бэрхшээл дээр нь онцгойлон үзүүлэх” ёстой.

3.3.2.3.3 Сэргээлт ба нөхөн сэргээлт (26 дугаар зүйл)

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгийн дээд түвшинд бие даасан байх, бие махбод, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн дүүрэн чадавхтай болох, нийгмийн бүх хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох, эзэмшүүлэх үүднээс бүхий л үр дүнтэй, зохистой арга хэмжээ авах”-ыг соёрхон баталж байгаа улс орнуудыг Конвенц уриалж байна. Үүний тулд, Оролцогч улсууд нь “эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт иж бүрэн сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ, хөтөлбөрүүд”-ийг зохион байгуулж, бэхжүүлж, өргөжүүлэхийг шаардаж байна. Сэргээлт, нөхөн сэргээлт нь “хувь хүний хэрэгцээ, чадавхийг олон талаас нь үнэлж, дүгнэсний үндсэн дээр” “аль болох эрт эхэлж”; “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрийнхөө амьдарч байгаа орчинд “сайн дурын” үндсэн дээр үзүүлж” “нийгмийн бүхий л үйлчилгээнд оролцож, хамрахад нь дэмжлэг үзүүлэх” ёстой.

3.3.2.3.4 Ажил ба хөдөлмөр эрхлэлт (27 дугаар зүйл)

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр хөдөлмөр эрхлэх, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг багтаасан, хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээл болон ажлын байрны орчинд хүлээн зөвшөөрөгдөж, чөлөөтэй сонгосон эрхэлж буй ажлынхаа үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжтой байх эрх”-ийг соёрхон баталж байгаа улс орнууд хүлээн зөвшөөрөхийг Конвенцуриалж байна. Соёрхон баталж байгаа улс орнууд нь “хөдөлмөр эрхэлж байх үедээ хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг эдлүүлэх үүднээс зохистой арга хэмжээг авч хамгаалж, хөхиүлэн дэмжинэ”.

3.3.2.3.5 Амьжиргааны хүрэлцэхүйц стандарт ба нийгмийн хамгаалал (28 дугаар зүйл)

“Хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас хунар, орон байраар хангагдах эрх, амьдралын нөхцлөө тасралтгүй сайжруулах явдлыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлэх явлыг хөхиүлэн дэмжих, баталгаажуулах үүднээс зохистой арга хэмжээ авах”-ыг соёрхон баталж байгаа улс орнуудаас Конвенц уриалж байна. “(...) цэвэр усны үйлчилгээнд тэгш хамрагдах, болон (...) үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлийн хэрэгцээнд зориулсан туслах хэрэгслүүдийг тэгш хүртэх” “(...) нийгмийн хамгааллын болон ядуурлыг буруулах хөтөлбөрүүдэд хамрагдах” мөн “хөгжлийн бэрхшээлтэй холбоотой тусгай хэрэгцээт зардлуудад төрөөс дэмжлэг авах, бүх нийтийн орон сууцаар хангах хөтөлбөрүүдэд болон тэтгэврийн үр ашиг, хөтөлбөрүүдэд хамрагдах” зэргийг соёрхон баталж байгаа улс орнууд баталгаажуулах ёстой.

3.3.2.4 Хувийн амьдралд хамаарах зүйлсийг хамгаалах нь (19, 22-23 дугаар зүйлүүд)

19 дүгээр зүйлд заагдсан бие дааж амьдрах болон нийгмийн үйл хэрэгт оролцох эрхийн дагуу соёрхон баталж байгаа улс орнууд “хөгжлийн бэрхшээлээс нь болж ямар нэгэн алагчлалгүйгээр энэхүү эрхийг эдлэх явлыг хөхиүлэн дэмжих, баталгаажуулахад зохих арга хэмжээнүүдийг авч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас хунар, орон байраар хангагдах эрх, амьдралын нөхцлөө тасралтгүй сайжруулж хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх”-ийг хүлээн зөвшөөрч байна. 23 дугаар зүйлд “(...) гэрлэх, гэр бүлтэй болох” “хүүхдийн тоогоо (...) чөлөөтэй, хариуцлагатай шийдвэрлэх” “бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр үр удмаа үлдээх” эрхүүдийг заасан байна.

3.3.2.5 Rights taken from other conventions (Arts. 10, 13-18, 29-30)

The right to life (Art. 10), access to justice (Art. 13), liberty and security of the person (Art. 14), the right to not be subjected to torture or to cruel, inhuman or degrading treatment or punishment (Art. 15), the right to not be subjected to exploitation, violence and abuse (Art. 16), the protection of the integrity of the person (Art. 17), liberty of movement and nationality (Art. 18), participation in political and public life (Art. 29) and participation in cultural life, recreation, leisure and sport (Art. 30) are all rights taken from other conventions, but at last also attributed to people with disabilities.

3.3.2.6 Systemic articles (Arts. 8, 12, 31)

The Convention identifies some areas that play an essential role in supporting the change in approach to people with disabilities as well as in transforming the social stigma attached to them.

3.3.2.6.1 Awareness-raising (Art. 8)

In order to transform society it is vital to raise awareness of the discrimination and unequal opportunities faced by people with disabilities. The Convention requires ratifying states to “adopt immediate, effective and appropriate measures (...) to raise awareness throughout society, including at the family level, regarding persons with disabilities, and to foster respect for the rights and dignity of persons with disabilities (...), to combat stereotypes, prejudices and harmful practices (...) [and] promote awareness of the capabilities and contributions of persons with disabilities.” The mass media, public awareness campaigns and correct information for children play an essential role, which is favoured by early and correct information about the conditions of people with disabilities.

3.3.2.6.2 Equal recognition before the law (Art. 12)

The Convention also introduces a profound innovation in the area of legal protection for people who cannot represent themselves. It obliges ratifying states to protect all people equally before the law and to ensure support for this right by tying it to the respect for human rights. This means that any treatment of people who are unable to represent themselves will not be allowed to violate the norms contained in both the Convention and the international human rights legislation. This implies a progressive change in services and treatments, which will have to overcome practices of institutionalization and forms of rights protection limited solely to inheritances and will introduce new attention to their quality of life. This also applies for people who are temporarily unable to represent themselves such as people subject to compulsory psychiatric treatment.

3.3.2.6.3 Statistics and data collection (Art. 31)

(w) Аливаа хувь хүн өөрийн харъяалагдах нийгэмлэг болон бусад хүмүүсийн өмнө хүлээсэн үүрэг болох Хүний эрхийн Олон улсын Билд заасан хүний эрхийг сахин биелүүлэх, хөхиүлэн дэмжихийн төлөө бүхий л хүчин чадлаа дайчлах ёстойг танин мэдэж,

(x) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах, хөхиүлэн дэмжих өргөн хүрээтэй бөгөөд олон улсын суурь конвенцийг батлан гаргах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй нийгмийн сөрөг нөлөөллийг арилгах болон хөгжингүй, хөгжиж байгаа аль ч оронд тэдгээр хүмүүс бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн бүхий л хүрээнд оролцох явдлыг дэмжихэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэн,

(y) Гэр бүл бол хүний мөн чанараас урган гарсан, нийгмийн үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрийн хамгаалалтанд байх эрхтэй ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ бүрэн дүүрэн, тэгш эдлэх нөхцлийг бий болгох үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд тусламж дэмжлэг хүртэх, шаардлагатай хамгаалалтад байх ёстойд түүнчлэн итгэн,

Дараах зүйлийг харилцан тохиролцов:

1 дүгээр зүйл

Зорилго

Энэхүү Конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, ямар нэг алагчлалгүйгээр эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих хийгээд тэдний салшгүй нэр төр, эрхэм зэргийг хүндэтгэн харилцахыг дэмжихэд оршино.

Хавсралт I - Конвенц ба Нэмэлт Протокол

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэдэгт урт хугацааны бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой бөгөөд тийм бэрхшээл нь орчны бусад хязгаарлалттай нэгдэн нийлж бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон хүмүүсийг ойлгоно.

2 дугаар зүйл

Тодорхойлолт

Энэхүү Конвенцийн зорилгод нийцүүлэн:

“Харилцаа” гэж хэл яриа, бичвэрийн үзүүлэн, Брайль болон тактил хэл, том үсгээр хэвлэгдсэн ба ойлгоход хялбар мультимедиа хэлбэртэй тухайлбал, бичмэл, аудио, ойлгомжтой хэл, ярьдаг ном зэрэг боломжит мэдээлэл, харилцаа холбооны технологийг оролцуулан нэмэлт болон сонголтот нэр төрөл, арга хэрэгсэл, хэлбэр маяг бүхий харилцааны хэрэглүүрүүдийг хэлнэ.

“Хэл яриа” гэдэгт ярианы болон бичгийн хэл, түүнчлэн ярианы бус бусад төрлийн хэлийг ойлгоно.

“Хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлах” гэдгийг улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан сулруулах буюу ийм эрхийг хүлээн зөвшөөрөхийг үгүйсгэх зорилго агуулсан эсвэл тийм үр дүнд хүргэсэн бүх төрлийн алагчлал, гадуурхалт, хязгаарлалт гэж ойлгоно.

“Тохирох хэрэглэгдэхүүн” гэж тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулах болон өөрчлөх хэрэгслийг хэлнэ.

“Төгсхэвмаяг” гэж ямар нэг нэмэлт тоноглол, тусгай тохируулга шаардагдахгүйгээр бүх хүмүүс байж болох хамгийн дээд хэмжээгээр хэрэглэхүйц бүтээгдэхүүн, хүрээлэн орчин, хөтөлбөр, үйлчилгээний хэв маягийг хэлнэ. Түгээмэл хэв маягт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шаардлагатай тохиолдолд хэрэглэгдэх туслах хэрэгслүүдийг орхигдуулж болохгүй.

3 дугаар зүйл

Ерөнхий зарчмууд

Энэхүү Конвенцийн зарчим нь:

- a) Сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан салшгүй эрхэм зэрэг, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх
- b) Алагчлахгүй байх
- c) Нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах
- d) Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүний ялгаатай байдлын нэг хэлбэр гэж хүлээн авах
- e) Тэгш боломж олгох

- (f) Accessibility;
- (g) Equality between men and women;
- (h) Respect for the evolving capacities of children with disabilities and respect for the right of children with disabilities to preserve their identities.

Article 4

General obligations

1. States Parties undertake to ensure and promote the full realization of all human rights and fundamental freedoms for all persons with disabilities without discrimination of any kind on the basis of disability. To this end, States Parties undertake:

- (a) To adopt all appropriate legislative, administrative and other measures for the implementation of the rights recognized in the present Convention;
- (b) To take all appropriate measures, including legislation, to modify or abolish existing laws, regulations, customs and practices that constitute discrimination against persons with disabilities;
- (c) To take into account the protection and promotion of the human rights of persons with disabilities in all policies and programmes;
- (d) To refrain from engaging in any act or practice that is inconsistent with the present Convention and to ensure that public authorities and institutions act in conformity with the present Convention;
- (e) To take all appropriate measures to eliminate discrimination on the basis of disability by any person, organization or private enterprise;
- (f) To undertake or promote research and development of universally designed goods, services, equipment and facilities, as defined in article 2 of the present Convention, which should require the minimum possible adaptation and the least cost to meet the specific needs of a person with disabilities, to promote their availability and use, and to promote universal design in the development of standards and guidelines;
- (g) To undertake or promote research and development of, and to promote the availability and use of new technologies, including information and communications technologies, mobility aids, devices and assistive technologies, suitable for persons with disabilities, giving priority to technologies at an affordable cost;
- (h) To provide accessible information to persons with disabilities about mobility aids, devices and assistive technologies, including new technologies, as well as other forms of assistance, support services and facilities;

Annex I - Text of the Convention and optional protocol

(i) To promote the training of professionals and staff working with persons with disabilities in the rights recognized in this Convention so as to better provide the assistance and services guaranteed by those rights.

2. With regard to economic, social and cultural rights, each State Party undertakes to take measures to the maximum of its available resources and, where needed, within the framework of international cooperation, with a view to achieving progressively the full realization of these rights, without prejudice to those obligations contained in the present Convention that are immediately applicable according to international law.

3. In the development and implementation of legislation and policies to implement the present Convention, and in other decision-making processes concerning issues relating to persons with disabilities, States Parties shall closely consult with and actively involve persons with disabilities, including children with disabilities, through their representative organizations.

4. Nothing in the present Convention shall affect any provisions which are more conducive to the realization of the rights of persons with disabilities and which may be contained in the law of a State Party or international law in force for that State. There shall be no restriction upon or derogation from any of the human rights and fundamental freedoms recognized or existing in any State Party to the present Convention pursuant to law, conventions, regulation or custom on the pretext that the present Convention does not recognize such rights or freedoms or that it recognizes them to a lesser extent.

5. The provisions of the present Convention shall extend to all parts of federal states without any limitations or exceptions.

Article 5

Equality and non-discrimination

1. States Parties recognize that all persons are equal before and under the law and are entitled without any discrimination to the equal protection and equal benefit of the law.

2. States Parties shall prohibit all discrimination on the basis of disability and guarantee to persons with disabilities equal and effective legal protection against discrimination on all grounds.

3. In order to promote equality and eliminate discrimination, States Parties shall take all appropriate steps to ensure that reasonable accommodation is provided.

4. Specific measures which are necessary to accelerate or achieve de facto equality of persons with disabilities shall not be considered discrimination under the terms of the present Convention.

f) Хүртээмжтэй байх

g) Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрх

h) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэх хандах

4 дүгээр зүйл

Үндсэн үүрэг

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалсан ямар нэг алагчлалгүйгээр хүний бүх үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хүлээн зөвшөөрч баталгаажуулна. Иймийн тул Оролцогч улсууд нь:

a) Энэхүү Конвенцид заасан эрхийг эдлэх явдлыг хангах ажиллагаанд бүхий л зохистой хууль тогтоох, захиргааны болон бусад арга хэмжээгээ нийцүүлнэ.

b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах явдлыг үүсгэх байгаа бүхий л хууль тогтоомж, дүрэм журам, зан заншил, дадал зуршлыг устгах, өөрчлөх бүхий л зохистой арга хэмжээг авна.

c) Төрийн бүх бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдлыг тусгана.

d) Энэхүү Конвенцийн зорилгод үл нийцэх үйлдэл, дадал зуршил гаргахаас татгалзаж, төрийн эрх бүхий байгууллага, институтууд Конвенцид нийцсэн үйл ажиллагаа явуулах байдлыг хангана.

e) Хувь хүн, байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлах явдлыг устгахад чиглэгдсэн бүхий л шаардлагатай арга хэмжээг авна.

f) Энэхүү Конвенцийн 2 дугаар зүйлд тодорхойлсончлон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг хангахад чиглэгдсэн хамгийн бага тохируулга шаардагдах бөгөөд хамгийн бага үнэ өртөгтэй төгс хэв маяг бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэгсэл болон байгууламжийг бүтээн бий болгох, хөгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх болон тэдгээр хүмүүсийн зүгээс ашиглах боломжийг бий болгох, стандарт, удирдамжуудад төгс хэв маягийг тусгуулах явдлыг дэмжинэ.

g) Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохиромжтой, боломжийн үнэтэй мэдээлэл харилцааны технологи, хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, туслах хэрэгсэл, туслах технологи гэх мэт шинэ технологийг ашиглах болон бэлэн болгохыг дэмжих, энэ талаарх судалгаа шинжилгээ хийхийг хөхүүлэн дэмжих.

h) Хөгжлийн бэрхшээлтэй хүнд шинэ технологийг оролцуулан хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологи түүнчлэн тусалцааны бусад хэв маяг, үйлчилгээ болон байгууламжийн талаарх

Хавсралт I - Конвенц ба Нэмэлт Протокол

боломжит мэдээллээр хангана.

i) Туслалцаа, үйлчилгээг сайжруулах үүднээс энэхүү Конвенцид заасан эрхийг эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцаж ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудыг сургах ажлыг дэмжих

2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлэх нөхцөл байдлыг шат дараатай бий болгох үүднээс Оролцогч улс бүр олон улсын эрх зүйн дагуу нэн даруй үүсэх энэхүү Конвенцоор хүлээсэн үүрэгтэй үл харшилдах байдлаар өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэнэ.

3. Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх чиглэгдсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг бий болгох, сайжруулах явцад болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахад Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэднийг төлөөлөх байгууллагыг оролцуулах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй сайтар зөвшилцож, оролцоог хангана.

4. Энэхүү Конвенцийн ямар ч зүйл заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрхээ эдлэх давуу боломж олгосон аливаа улсын дотоодын хууль тогтоомж, эсвэл тухайн улсын хувьд хүчин төгөлдөр олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх явдалд нөлөө үзүүлэхгүй. Энэхүү Конвенцид оролцогч аливаа улсад хууль тогтоомж, гэрээ конвенц, дүрэм журам, зан заншлаар хүлээн зөвшөөрсөн буюу хэрэгжүүлж байгаа хүний аливаа эрх, үндсэн эрх чөлөөг тус Конвенцид тэдгээр эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөөгүй буюу доогуур хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн гэх шалтгаанаар хязгаарлах буюу бууруулж болохгүй.

5. Энэхүү Конвенцийн зүйл заалт бүр холбооны улсын хувьд бүх нутаг дэвсгэрт ямар нэг ялгаа, хязгаарлалтгүй үйлчилнэ.

5 дугаар зүйл

Тэгш байдал ба үл алагчлал

1. Оролцогчулсууд хүн бүрхуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар нэг алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулж, адил ашиг хүртэх эрхтэй болохыг хүлээн зөвшөөрнө.

2. Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр алагчлах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ямарваа хэлбэрийн алагчлалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно.

3. Тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, алагчлалыг устгах үүднээс Оролцогч улсууд нь шаардлагатай бүхий л зохицуулалтыг хийнэ.

4. Энэхүү Конвенцид заагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлыг бодитоор хангах, ийм байдлыг бий болгоход чиглэгдсэн тусгай арга хэмжээнүүдийг алагчлал гэж үзэхгүй.

Article 6

Women with disabilities

1. States Parties recognize that women and girls with disabilities are subject to multiple discrimination, and in this regard shall take measures to ensure the full and equal enjoyment by them of all human rights and fundamental freedoms.
2. States Parties shall take all appropriate measures to ensure the full development, advancement and empowerment of women, for the purpose of guaranteeing them the exercise and enjoyment of the human rights and fundamental freedoms set out in the present Convention.

Article 7

Children with disabilities

1. States Parties shall take all necessary measures to ensure the full enjoyment by children with disabilities of all human rights and fundamental freedoms on an equal basis with other children.
2. In all actions concerning children with disabilities, the best interests of the child shall be a primary consideration.
3. States Parties shall ensure that children with disabilities have the right to express their views freely on all matters affecting them, their views being given due weight in accordance with their age and maturity, on an equal basis with other children, and to be provided with disability and age-appropriate assistance to realize that right.

Article 8

Awareness-raising

1. States Parties undertake to adopt immediate, effective and appropriate measures:
 - (a) To raise awareness throughout society, including at the family level, regarding persons with disabilities, and to foster respect for the rights and dignity of persons with disabilities;
 - (b) To combat stereotypes, prejudices and harmful practices relating to persons with disabilities, including those based on sex and age, in all areas of life;
 - (c) To promote awareness of the capabilities and contributions of persons with disabilities.
2. Measures to this end include:
 - (a) Initiating and maintaining effective public awareness campaigns designed:
 - (i) To nurture receptiveness to the rights of persons with disabilities;
 - (ii) To promote positive perceptions and greater social awareness towards persons with disabilities;

Annex I - Text of the Convention and optional protocol

- (iii) To promote recognition of the skills, merits and abilities of persons with disabilities, and of their contributions to the workplace and the labour market;
- (b) Fostering at all levels of the education system, including in all children from an early age, an attitude of respect for the rights of persons with disabilities;
- (c) Encouraging all organs of the media to portray persons with disabilities in a manner consistent with the purpose of the present Convention;
- (d) Promoting awareness-training programmes regarding persons with disabilities and the rights of persons with disabilities.

Article 9

Accessibility

1. To enable persons with disabilities to live independently and participate fully in all aspects of life, States Parties shall take appropriate measures to ensure to persons with disabilities access, on an equal basis with others, to the physical environment, to transportation, to information and communications, including information and communications technologies and systems, and to other facilities and services open or provided to the public, both in urban and in rural areas. These measures, which shall include the identification and elimination of obstacles and barriers to accessibility, shall apply to, inter alia:

- (a) Buildings, roads, transportation and other indoor and outdoor facilities, including schools, housing, medical facilities and workplaces;
- (b) Information, communications and other services, including electronic services and emergency services.

2. States Parties shall also take appropriate measures to:

- (a) Develop, promulgate and monitor the implementation of minimum standards and guidelines for the accessibility of facilities and services open or provided to the public;
- (b) Ensure that private entities that offer facilities and services which are open or provided to the public take into account all aspects of accessibility for persons with disabilities;
- (c) Provide training for stakeholders on accessibility issues facing persons with disabilities;
- (d) Provide in buildings and other facilities open to the public signage in Braille and in easy to read and understand forms;

6 дугаар зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид нь давхар алагчлалд өртөж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, иймийн тул тэднийг хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авна.
2. Оролцогч улсууд нь энэхүү Конвенцид заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг баталгаажуулах үүднээс эмэгтэйчүүдийг бүрэн хөгжүүлэх, дээшлүүлэх болон чадавхжуулахад чиглэгдсэн бүхий л зохистой арга хэмжээг авна.

7 дугаар зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдийн нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг баталгаажуулах үүднээс бүхий л шаардлагатай арга хэмжээг авна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа бүх арга хэмжээ нь нэн түрүүнд хүүхдийн эрх ашигт нийцсэн байх явдлыг урьтал болгоно.
3. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдийн нэгэн адил нь өөрсдийн нас болон биеийн онцлогт тохирсон байдлаар өөрсөд хамаарах аливаа асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлэх эрхтэй бөгөөд энэхүү эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээл болон насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх явдлыг баталгаажуулна.

8 дугаар зүйл

Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажиллагаа

1. Оролцогч улсууд нь дараах нэн яаралтай, үр дүнтэй, зохистой арга хэмжээг авна:
 - а) Гэр бүлийг оролцуулан нийгмийн бүх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ба хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, салшгүй нэр төрийг хүндэтгэх явдлыг дэмжих
 - б) Амьдралын бүх үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар хор уршигтай, хохирол учруулахуйц нас, хүйс зэрэгт үндэслэсэн дадал зуршлыг бий болгохуйц нийгэмд тогтсон үзэл хандлагатай тэмцэх
 - в) Хөгжлийн бэрхшээлтэй хүний чадавх, тэдний нийгэмд оруулж буй хувь нэмрийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

Эдгээр арга хэмжээ нь дараах төрөлтэй байж болно:

- а) Дараах төрлийн үр нөлөөтэй олон нийтэд чиглэгдсэн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажлыг санаачилж, зохион байгуулах:
 - (i) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүлээн зөвшөөрөх байдлыг бий болгох

Хавсралт I - Конвенц ба Нэмэлт Протокол

- (ii) Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар эерэг ойлголт, нийгмийн зөв хандлагыг тогтоохыг дэмжих
- (iii) Хөгжлийн бэрхшээлтэй хүний ур чадвар, авьяас билиг, чадавх, ажлын байр ба хөдөлмөрийн зах зээл дээр тэдний оруулж буй хувь нэмрийн талаар танин мэдэх явдлыг дэмжих
- b) Бүх хүүхдүүдэд бага наснаас нь олгох боловсролыг оролцуулан бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлага төлөвшүүлэх явдлыг дэмжих
- c) Бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар энэхүү Конвенцийн зорилгод нийцсэн байдлаар хэвлэн нийтлэх, дэлгэн харуулахыг дэмжих
- d) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх сургалт, сурталчилгааны ажлыг хөхиүлэн дэмжих

9 дүгээр зүйл

Хүртээмж

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор Оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийн хүрээлэн орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд үйлчлэх бусад төрлийн хэрэгсэл, үйлчилгээг хүртэх явдлыг баталгаажуулахад чиглэгдсэн арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээ нь дараах болон бусад газарт хүрэх боломжийг хязгаарлахуйц саад тотгорыг илрүүлэх, устгахад чиглэгдэнэ:

- a) Барилга байшин, зам гүүр, тээвэр болон сургууль, орон байр, эмнэлэг, ажлын байрыг оролцуулан бүх төрлийн дотор, гаднах байгууламж
- b) Мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ тухайлбал, түргэн тусламжийн болон электроникийн үйлчилгээ

2. Түүнчлэн Оролцогч улсууд нь дараах шаардлагатай арга хэмжээг авна:

- a) Нийтэд үйлчлэх үйлчилгээ, байгууламжийг хүртээмжтэй байлгахад чиглэгдсэн удирдамж, жишиг стандартыг боловсруулах, сайжруулах, хэрэгжилтэнд нь хяналт тавих
- b) Нийтэд үйлчлэх үйлчилгээ, байгууламжийг ажиллуулдаг хувийн хэвшлийн байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлыг бий болгох бүхий л хүчин зүйлийг бүрдүүлсэн байхыг баталгаажуулна.
- c) Холбогдогч талуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй хүртээмж асуудлаар сургалтанд хамруулах
- d) Нийтэд үйлчилдэг барилга, бусад байгууламжийн тэмдэг, тэмдэглэгээг Брайль үсгээр буюу хялбар уншигдах, ойлгогдохуйц байдлаар хийх

(e) Provide forms of live assistance and intermediaries, including guides, readers and professional sign language interpreters, to facilitate accessibility to buildings and other facilities open to the public;

(f) Promote other appropriate forms of assistance and support to persons with disabilities to ensure their access to information;

(g) Promote access for persons with disabilities to new information and communications technologies and systems, including the Internet;

(h) Promote the design, development, production and distribution of accessible information and communications technologies and systems at an early stage, so that these technologies and systems become accessible at minimum cost.

Article 10

Right to life

States Parties reaffirm that every human being has the inherent right to life and shall take all necessary measures to ensure its effective enjoyment by persons with disabilities on an equal basis with others.

Article 11

Situations of risk and humanitarian emergencies

States Parties shall take, in accordance with their obligations under international law, including international humanitarian law and international human rights law, all necessary measures to ensure the protection and safety of persons with disabilities in situations of risk, including situations of armed conflict, humanitarian emergencies and the occurrence of natural disasters.

Article 12

Equal recognition before the law

1. States Parties reaffirm that persons with disabilities have the right to recognition everywhere as persons before the law.

2. States Parties shall recognize that persons with disabilities enjoy legal capacity on an equal basis with others in all aspects of life.

3. States Parties shall take appropriate measures to provide access by persons with disabilities to the support they may require in exercising their legal capacity.

4. States Parties shall ensure that all measures that relate to the exercise of legal capacity provide for appropriate and effective safeguards to prevent abuse in accordance with international human rights law. Such safeguards shall ensure that measures relating to the exercise of legal capacity respect the rights, will and preferences of the person, are free of conflict of interest and undue influence, are proportional and tailored to the person's circumstances, apply for the shortest time possible and are subject to regular review by a competent, independent and impartial authority or judicial body. The safeguards shall be proportional to the degree to which such measures affect the person's rights and interests.

5. Subject to the provisions of this article, States Parties shall take all appropriate and effective measures to ensure the equal right of persons with disabilities to own or inherit property, to control their own financial affairs and to have equal access to bank loans, mortgages and other forms of financial credit, and shall ensure that persons with disabilities are not arbitrarily deprived of their property.

Article 13

Access to justice

1. States Parties shall ensure effective access to justice for persons with disabilities on an equal basis with others, including through the provision of procedural and age-appropriate accommodations, in order to facilitate their effective role as direct and indirect participants, including as witnesses, in all legal proceedings, including at investigative and other preliminary stages.

2. In order to help to ensure effective access to justice for persons with disabilities, States Parties shall promote appropriate training for those working in the field of administration of justice, including police and prison staff.

Article 14

Liberty and security of the person

1. States Parties shall ensure that persons with disabilities, on an equal basis with others:

(a) Enjoy the right to liberty and security of person;

(b) Are not deprived of their liberty unlawfully or arbitrarily, and that any deprivation of liberty is in conformity with the law, and that the existence of a disability shall in no case justify a deprivation of liberty.

2. States Parties shall ensure that if persons with disabilities are deprived of their liberty through any process, they are, on an equal basis with others, entitled to guarantees in accordance with international human rights law and shall be treated in compliance with the objectives and principles of this Convention, including by provision of reasonable accommodation.

е) Нийтэд үйлчилдэг барилга, бусад байгууламжийн хүргээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүд, тухайлбал, хөтөч, уншигч, мэргэжлийн дохионы хэлний орчуулагчийг бий болгох

f) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл хүлээн авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн дэмжлэг туслалцааны зохистой хэв маягийг хөхиүлэн дэмжих

g) Шинэ мэдээлэл, харилцаа технологи, систем тухайлбал интернетийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх

h) Хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн хэв маягийг тогтоох, сайжруулах, үйлдвэрлэх, түгээн борлуулахдаа тэдгээр технологи, системүүдийг байж болох хамгийн доод үнэтэй байх явдлыг хангах

10 дугаар зүйл.

Амьд явах эрх

Оролцогч улсууд нь хүн бүр амьд явах салшгүй эрхтэй гэдгийг дахин нотолж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил энэхүү эрхээ бүрэн дүүрэн эдлэх явдлыг баталгаажуулах үүднээс шаардлагатай бүх арга хэмжээг авна.

11 дүгээр зүйл.

Хүтүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал

Оролцогч улсууд нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын хүний эрхийн хуулийг оролцуулан олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүрэгтэй нийцүүлэн эрсдэл бүхий байдалд тухайлбал, зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн гамшиг, байгалийн аюул гамшиг тохиолдсон үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад чиглэгдсэн бүхий л шаардлагатай арга хэмжээг авна.

12 дугаар зүйл.

Хуулийн өмнө тэгш байх эрх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүн бүрийн нэгэн адил хуулийн өмнө адил тэгш байх эрхтэйг дахин нотолно.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр эрх зүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрнө.

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь шаардагдах дэмжлэг туслалцааг хүртээмжтэй байлгах үүднээс шаардлагатай арга хэмжээ авна.

4. Оролцогч улсууд нь олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, зохистой хамгаалалтыг бий болгохуйц эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх арга хэмжээг авна. Эрх зүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ийм хамгаалалт нь тухайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй, хувийн

нөхцөл байдалд нь тохирсон, байж болох хамгийн богино хугацаанд байх бөгөөд бүрэн эрхэт, хараат бус, бие даасан байгууллага буюу шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Ийм хамгаалалт нь тухай хүний эрх, ашиг сонирхолд нөлөөлөхүйц арга хэмжээтэй нийцсэн байна.

5. Энэхүү зүйлийн заалтуудын дагуу Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмч хөрөнгө эзэмших, өв залгамжлах ба банкны зээл, барьцаат зээл болон бусад төрлийн зээлийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай, үрдүнтэй арга хэмжээ авах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний өмч хөрөнгийг дур мэдэн хураахгүй байх явдлыг баталгаажуулна.

13 дугаар зүйл

Шударга шүүхээр шүүлгэх эрх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр тухайлбал, байцаан шийтгэх ажиллагаа болон насны онцлогт нийцсэн хэрэглэгдэхүүнийг ашиглах замаар мөрдөн байцаалт болон бусад шүүхийн өмнөх шатны ажиллагааг оролцуулан хууль зүйн ажиллагааны бүхий л шатанд шууд болон шууд бус оролцогч, тухайлбал гэрчийн хувьд үр нөлөөтэй оролцох боломжийг бий болгох замаар шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад туслалцаа үзүүлэх зорилгоор Оролцогч улсууд нь шүүхийн захиргааны байгууллагуудад тухайлбал, цагдаа болон хорих ангийн албан хаагчдыг шаардлагатай сургалтанд хамруулах явдлыг дэмжинэ.

14 дүгээр зүйл

Хүн бүрийн эрх чөлөөтэй, халдашгүй байх эрх

1. Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний дараах эрхийг баталгаажуулна:

а) Хувийн эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхээ эдлэх

б) Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур тэдгээр хүмүүсийн эрх чөлөөг нь хасч болохгүй бөгөөд зөвхөн хуульд нийцсэн журмын дагуу эрх чөлөөг хасна. Ямар ч тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй байх нь эрх чөлөөг нь хасах үндэслэл болохгүй.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх чөлөөг бусадтай адил тэгш нөхцөлийн үндсэн дээр хассан ямар ч тохиолдолд ийм ажиллагааг тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах эрхийг оролцуулан энэхүү Конвенцийн зорилго, зарчимд нийцсэн байдлаар гүйцэтгэх бөгөөд олон улсын хүний эрхийн эрх зүйд нийцсэн байх явдлыг баталгаажуулна.

Article 15

Freedom from torture or cruel, inhuman or degrading treatment or punishment

1. No one shall be subjected to torture or to cruel, inhuman or degrading treatment or punishment. In particular, no one shall be subjected without his or her free consent to medical or scientific experimentation.
2. States Parties shall take all effective legislative, administrative, judicial or other measures to prevent persons with disabilities, on an equal basis with others, from being subjected to torture or cruel, inhuman or degrading treatment or punishment.

Article 16

Freedom from exploitation, violence and abuse

1. States Parties shall take all appropriate legislative, administrative, social, educational and other measures to protect persons with disabilities, both within and outside the home, from all forms of exploitation, violence and abuse, including their gender-based aspects.
2. States Parties shall also take all appropriate measures to prevent all forms of exploitation, violence and abuse by ensuring, inter alia, appropriate forms of gender- and age-sensitive assistance and support for persons with disabilities and their families and caregivers, including through the provision of information and education on how to avoid, recognize and report instances of exploitation, violence and abuse. States Parties shall ensure that protection services are age-, gender- and disability-sensitive.
3. In order to prevent the occurrence of all forms of exploitation, violence and abuse, States Parties shall ensure that all facilities and programmes designed to serve persons with disabilities are effectively monitored by independent authorities.
4. States Parties shall take all appropriate measures to promote the physical, cognitive and psychological recovery, rehabilitation and social reintegration of persons with disabilities who become victims of any form of exploitation, violence or abuse, including through the provision of protection services. Such recovery and reintegration shall take place in an environment that fosters the health, welfare, self-respect, dignity and autonomy of the person and takes into account gender- and age-specific needs.
5. States Parties shall put in place effective legislation and policies, including women- and child-focused legislation and policies, to ensure that instances of exploitation, violence and abuse against persons with disabilities are identified, investigated and, where appropriate, prosecuted.

Annex I - Text of the Convention and optional protocol

Article 17

Protecting the integrity of the person

Every person with disabilities has a right to respect for his or her physical and mental integrity on an equal basis with others.

Article 18

Liberty of movement and nationality

1. States Parties shall recognize the rights of persons with disabilities to liberty of movement, to freedom to choose their residence and to a nationality, on an equal basis with others, including by ensuring that persons with disabilities:

- (a) Have the right to acquire and change a nationality and are not deprived of their nationality arbitrarily or on the basis of disability;
- (b) Are not deprived, on the basis of disability, of their ability to obtain, possess and utilize documentation of their nationality or other documentation of identification, or to utilize relevant processes such as immigration proceedings, that may be needed to facilitate exercise of the right to liberty of movement;
- (c) Are free to leave any country, including their own;
- (d) Are not deprived, arbitrarily or on the basis of disability, of the right to enter their own country.

2. Children with disabilities shall be registered immediately after birth and shall have the right from birth to a name, the right to acquire a nationality and, as far as possible, the right to know and be cared for by their parents.

Article 19

Living independently and being included in the community

States Parties to this Convention recognize the equal right of all persons with disabilities to live in the community, with choices equal to others, and shall take effective and appropriate measures to facilitate full enjoyment by persons with disabilities of this right and their full inclusion and participation in the community, including by ensuring that:

- (a) Persons with disabilities have the opportunity to choose their place of residence and where and with whom they live on an equal basis with others and are not obliged to live in a particular living arrangement;
- (b) Persons with disabilities have access to a range of in-home, residential and other community support services, including personal assistance necessary to support living and inclusion in the community, and to prevent isolation or segregation from the community;

15 дугаар зүйл

Эрүүдэн шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх

1. Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлэгийн буюу шинжлэх ухааны туршилтанд оруулж болохгүй.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс урьдчилан сэргийлэх бүхий л үр дүнтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээг авна.

16 дугаар зүйл

Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь орон гэрийнхээ дотор, гадна хаана ч хүйсэд үндэслэсэн байдлыг оролцуулан аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах үүднээс бүхий л зохистой хууль тогтоох, захиргааны, боловсролын болон бусад арга хэмжээг авна.

2. Оролцогч улсууд нь нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн мэдрэмжтэй туслалцаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, асран халамжлагчдад нь аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой бодит явдлын талаар мэдээлэх, таниулах болон эдгээрээс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл түгээх боловсрол олгох ажиллагааг оролцуулан дэмжлэг үзүүлэх явдлыг хангах замаар аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх бүхий л зохистой арга хэмжээг авна.

3. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлол гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан бүхий материаллаг хэрэглэгдэхүүн, хөтөлбөрүүд нь хараат бус эрх бүхий байгууллагаар үр нөлөөтэй хянагдсан байх явдлыг баталгаажуулна.

4. Оролцогч улсууд нь хамгаалах үйлчилгээний талаарх нөхцөл заалтыг оролцуулан аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие махбодь, танин мэдэхүй, сэтгэлзүйн хувьд сэргээх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд дахин оролцуулах үүднээс бүхий л зохистой арга хэмжээг авна. Тийм төрлийн сэргээх, нийгэмд оролцуулах арга хэмжээ нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, өөрийгөө хүндэтгэх байдал, эрхэм зэрэг, хувь хүний хараат бус байдлыг хангасан орчин нөхцөлд авагдана.

5. Оролцогч улсууд нь хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэгдсэн бодлого, хууль тогтоомжийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мөлжсөн, хүчирхийлсэн, доромжилсон тохиолдлыг тогтоох, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах явдлыг баталгаажуулсан үр дүнтэй хууль тогтоомж, бодлогыг боловсруулна.

17 дугаар зүйл

Хүний бүрэн бүтэн байдлыг хамгаалах

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил өөрийнхөө бие махбодь болон сэтгэхүйн бүрэн бүтэн байдлаа хүндэтгүүлэх эрхтэй.

18 дугаар зүйл

Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг баталгаажуулна:

- а) Иргэний харьяалал олж авах болон өөрчлөх, иргэний харьяаллыг нь хуульд заасан журмаас гадуур буюу хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаан хасахыг хориглоно.
- б) Хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан иргэний харьяалал болон бусад төрлийн тодорхойлох баримт бичгийг олж авах, эзэмших, ашиглах буюу чөлөөтэй зорчих эрхээ хэрэгжүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай цагаачлалын журам зэрэг холбогдох ажиллагааг ашиглах эрхийг хасахыг хориглоно.
- с) Төрөлх улсыг нь оролцуулан аливаа улсыг орхин явах эрхтэй.
- д) Хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан эсвэл хуульд заасан үндэслэл журмаас гадуур өөрийн улс орондоо эргэн ирэх эрхийг хязгаарлаж болохгүй.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь төрсөн даруй улсын бүртгэлд бүртгэгдэх, нэртэй болох, иргэний харьяалал олж авах болон боломжтой тохиолдолд эцэг эхээ мэдэх, тэднээрээ асран тэтгүүлэх эрхтэй.

19 дүгээр зүйл

Бие даан амьдрах болон нийгмийн үйл хэрэгт оролцох эрх

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний бусдын нэгэн адил сонголттойгоор нийгэмд амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгэмд бүрэн дүүрэн хамрагдаж оролцохыг дэмжих үүднээс дараах байдлыг баталгаажуулах замаар зохистой, үр дүнтэй арга хэмжээг авна:

- а) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын нэгэн адил оршин суух газар болон хаана, хэнтэй амьдрах эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой бөгөөд тусгай нөхцөл байдалд амьдрахыг шаардаж болохгүй.
- б) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь нийгэмд оролцох болон амьдрахад нь шаардлагатай хувийн туслалцааг оролцуулан гэрийн, оршин суугаа газрын болон бусад төрлийн нийтийн туслах үйлчилгээг хүртэх боломжтой байх бөгөөд нийгмээс тусгаарлах, таслагдахаас хамгаалагдана.

(c) Community services and facilities for the general population are available on an equal basis to persons with disabilities and are responsive to their needs.

Article 20

Personal mobility

States Parties shall take effective measures to ensure personal mobility with the greatest possible independence for persons with disabilities, including by:

- (a) Facilitating the personal mobility of persons with disabilities in the manner and at the time of their choice, and at affordable cost;
- (b) Facilitating access by persons with disabilities to quality mobility aids, devices, assistive technologies and forms of live assistance and intermediaries, including by making them available at affordable cost;
- (c) Providing training in mobility skills to persons with disabilities and to specialist staff working with persons with disabilities;
- (d) Encouraging entities that produce mobility aids, devices and assistive technologies to take into account all aspects of mobility for persons with disabilities.

Article 21

Freedom of expression and opinion, and access to information

States Parties shall take all appropriate measures to ensure that persons with disabilities can exercise the right to freedom of expression and opinion, including the freedom to seek, receive and impart information and ideas on an equal basis with others and through all forms of communication of their choice, as defined in article 2 of the present Convention, including by:

- (a) Providing information intended for the general public to persons with disabilities in accessible formats and technologies appropriate to different kinds of disabilities in a timely manner and without additional cost;
- (b) Accepting and facilitating the use of sign languages, Braille, augmentative and alternative communication, and all other accessible means, modes and formats of communication of their choice by persons with disabilities in official interactions;
- (c) Urging private entities that provide services to the general public, including through the Internet, to provide information and services in accessible and usable formats for persons with disabilities;
- (d) Encouraging the mass media, including providers of information through the Internet, to make their services accessible to persons with disabilities;
- (e) Recognizing and promoting the use of sign languages.

Article 22

Respect for privacy

1. No person with disabilities, regardless of place of residence or living arrangements, shall be subjected to arbitrary or unlawful interference with his or her privacy, family, home or correspondence or other types of communication or to unlawful attacks on his or her honour and reputation. Persons with disabilities have the right to the protection of the law against such interference or attacks.
2. States Parties shall protect the privacy of personal, health and rehabilitation information of persons with disabilities on an equal basis with others.

Article 23

Respect for home and the family

1. States Parties shall take effective and appropriate measures to eliminate discrimination against persons with disabilities in all matters relating to marriage, family, parenthood and relationships, on an equal basis with others, so as to ensure that:
 - (a) The right of all persons with disabilities who are of marriageable age to marry and to found a family on the basis of free and full consent of the intending spouses is recognized;
 - (b) The rights of persons with disabilities to decide freely and responsibly on the number and spacing of their children and to have access to age-appropriate information, reproductive and family planning education are recognized, and the means necessary to enable them to exercise these rights are provided;
 - (c) Persons with disabilities, including children, retain their fertility on an equal basis with others.
2. States Parties shall ensure the rights and responsibilities of persons with disabilities, with regard to guardianship, wardship, trusteeship, adoption of children or similar institutions, where these concepts exist in national legislation; in all cases the best interests of the child shall be paramount. States Parties shall render appropriate assistance to persons with disabilities in the performance of their child-rearing responsibilities.

с) Нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, материаллаг хэрэглэгдэхүүн нь бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хэрэглэх боломжтой байх бөгөөд хэрэгцээнд нь нийцсэн байна.

20 дугаар зүйл

Хувийн хөдөлгөөнт байдал

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даасан байдлыг байж болох хамгийн дээд түвшинд хангах замаар хувийн хөдөлгөөнт байдлыг баталгаажуулах үүднээс дараах зүйлсийг оролцуулан үр дүнтэй бүх арга хэмжээг авна:

а) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн хөдөлгөөнт байдлыг тэдний сонгосон арга замаар, сонгосон цаг хугацаанд нь аль болох хамгийн бага зардлаар хангах явдлыг дэмжих

б) Чанарын шаардлагатай хангасан хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологи болон амьд туслалцаа, зуучлалын хэлбэрүүдийг аль болох хамгийн хямд өртөгөөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүртэх явдлыг дэмжих

с) Хөгжлийг бэрхшээлтэй хүмүүс болон тэдэнтэй ажилладаг мэргэшсэн ажилтнуудыг хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулах

д) Хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологиудыг үйлдвэрлэхдээ аж ахуйн нэгжүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний бүхий л хэрэгцээ, талыг бодолцож байх явдлыг хангах

21 дүгээр зүйл

Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлд хүрэх эрх

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр Энэхүү Конвенцийн 2-р зүйлд заасан өөрсдийн сонгосон бүх төрлийн харилцааны хэрэглүүрүүдээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлд хүрэх эрх, тухайлбал, төрөл бүрийн мэдээлэл, санаа бодлыг хайх, хүлээн авах, түгээх эрхээ эдлэх нөхцөл байдлыг бий болгох үүднээс бүхий л зохистой арга хэмжээ авна.

а) Нийгмийн бүх гишүүдэд зориулсан мэдээллийг түгээхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглахад зориулж хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн хэлбэрт нийцсэн арга замаар, тухайн цаг хугацаанд нь, ямар нэг нэмэлт өртөг зардалгүйгээр түгээх

б) Албан харилцааг явуулахдаа дохионы хэл, Брайль үсэг, нэмэлт болон сонголтот харилцуур, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгосон бусад боломжит арга зам, төрөл хэлбэр, хэв маягийн харилцааны хэрэглүүрүүдийг ашиглах явдлыг хүлээн авах, дэмжих

с) Интернэтийг оролцуулан нийгмийн бүх гишүүдэд зориулсан үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг мэдээлэл түгээх, үйлчилгээ үзүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглаж болохуйц хэлбэрээр түгээх нөхцөл

Хавсралт I - Конвенц ба Нэмэлт Протокол

бололцоо бий болгохыг шаардах

d) Интернэтээр мэдээлэл түгээдэг байгууллагуудыг оролцуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх явдлыг нэмэгдүүлэх

e) Дохионы хэлнүүдийг хэрэглэх явдлыг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжих

22 дугаар зүйл

Хувийн нууцыг хүндэтгэх

1. Амьдран буй газар, орон байрны нөхцөл байдлаасаа үл шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байр буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.

2. Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн, эрүүл мэндийн болон нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийн нууцлалыг хамгаална.

23 дугаар зүйл

Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэрлэлт, гэр бүл, эцэг эх, төрөл садны харьцаанд бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр алагчлах явдлыг устгах үр дүнтэй, шаардлагатай арга хэмжээг авна. Үүний тул дараах зүйлсийг баталгаажуулна:

a) Гэрлэх насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний гэрлэх хүнийх нь чөлөөтэй бүрэн зөвшөөрсний үндсэн дээр гэр бүл болох эрх

b) Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь хүүхдийн тоо болон хүүхэд төрүүлэх хоорондын зайгаа чөлөөтэй, хариуцлагатай шийдвэрлэх эрхтэй бөгөөд насныхаа онцлогт тохирсон мэдээлэл, нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн боловсрол эзэмшиж, эдгээр эрхээ эдлэхэд нь шаардлагатай нөхцөл бололцоо болон үр удмаа үлдээх тэгш боломжоор хангах

c) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр үр удмаа үлдээх эрх

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалалт, харгалзан дэмжих, итгэмжлэл, хүүхэд үрчлэх эсвэл ижил төрлийн байгууллага болон үндэсний хууль тогтоомжид заасан эдгээртэй төсөөтэй арга хэмжээнд оролцох эрх, үүргийг баталгаажуулна. Ямар ч тохиолдолд хүүхдийн ашиг сонирхол нэн тэргүүнд тавигдана. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүүхэд өсгөхтэй холбогдсон үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай тусламжийг үзүүлнэ.

3. States Parties shall ensure that children with disabilities have equal rights with respect to family life. With a view to realizing these rights, and to prevent concealment, abandonment, neglect and segregation of children with disabilities, States Parties shall undertake to provide early and comprehensive information, services and support to children with disabilities and their families.

4. States Parties shall ensure that a child shall not be separated from his or her parents against their will, except when competent authorities subject to judicial review determine, in accordance with applicable law and procedures, that such separation is necessary for the best interests of the child. In no case shall a child be separated from parents on the basis of a disability of either the child or one or both of the parents.

5. States Parties shall, where the immediate family is unable to care for a child with disabilities, undertake every effort to provide alternative care within the wider family, and failing that, within the community in a family setting.

Article 24

Education

1. States Parties recognize the right of persons with disabilities to education. With a view to realizing this right without discrimination and on the basis of equal opportunity, States Parties shall ensure an inclusive education system at all levels and life long learning directed to:

(a) The full development of human potential and sense of dignity and self-worth, and the strengthening of respect for human rights, fundamental freedoms and human diversity;

(b) The development by persons with disabilities of their personality, talents and creativity, as well as their mental and physical abilities, to their fullest potential;

(c) Enabling persons with disabilities to participate effectively in a free society.

2. In realizing this right, States Parties shall ensure that:

(a) Persons with disabilities are not excluded from the general education system on the basis of disability, and that children with disabilities are not excluded from free and compulsory primary education, or from secondary education, on the basis of disability;

(b) Persons with disabilities can access an inclusive, quality and free primary education and secondary education on an equal basis with others in the communities in which they live;

Annex I - Text of the Convention and optional protocol

- (c) Reasonable accommodation of the individual's requirements is provided;
- (d) Persons with disabilities receive the support required, within the general education system, to facilitate their effective education;
- (e) Effective individualized support measures are provided in environments that maximize academic and social development, consistent with the goal of full inclusion.

3. States Parties shall enable persons with disabilities to learn life and social development skills to facilitate their full and equal participation in education and as members of the community. To this end, States Parties shall take appropriate measures, including:

- (a) Facilitating the learning of Braille, alternative script, augmentative and alternative modes, means and formats of communication and orientation and mobility skills, and facilitating peer support and mentoring;
- (b) Facilitating the learning of sign language and the promotion of the linguistic identity of the deaf community;
- (c) Ensuring that the education of persons, and in particular children, who are blind, deaf or deafblind, is delivered in the most appropriate languages and modes and means of communication for the individual, and in environments which maximize academic and social development.

4. In order to help ensure the realization of this right, States Parties shall take appropriate measures to employ teachers, including teachers with disabilities, who are qualified in sign language and/or Braille, and to train professionals and staff who work at all levels of education. Such training shall incorporate disability awareness and the use of appropriate augmentative and alternative modes, means and formats of communication, educational techniques and materials to support persons with disabilities.

5. States Parties shall ensure that persons with disabilities are able to access general tertiary education, vocational training, adult education and lifelong learning without discrimination and on an equal basis with others. To this end, States Parties shall ensure that reasonable accommodation is provided to persons with disabilities.

3. Оролцогч улсууд нь гэр бүлийн харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш эрхийг баталгаажуулна. Энэхүү эрхийг хэрэгжүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нууцлах, орхих, үл тоомсорлох, тусгаарлахаар хамгаалахын тулд Оролцогч улсууд нь шаардлагатай эрт үед нь, өргөн хүрээтэй мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний гэр бүлийн гишүүдэд туслалцаа үзүүлнэ.

4. Оролцогч улсууд нь холбогдох хууль тогтоомж, горимын дагуу тийм тусгаарлалт нь хүүхдийн эрх ашигт хамгийн ихээр нийцтэй байх тухай эрх бүхий байгууллагаас тодорхойлж, шүүхээр шийдвэрлэгдснээс бусад тохиолдолд хүүхэд өөрийнхөө хүсэл зоригоос гадуур эцэг эхээсээ тусгаарлагдахгүй байх эрхийг баталгаажуулна. Ямар ч тохиолдолд эцэг эхийн аль нэг нь, эсхүл хоёулаа буюу хүүхдэд нь хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар хүүхдийг эцэг эхээс нь тусгаарлаж болохгүй.

5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үндсэн гэр бүл нь асран халамжлах боломжгүй тохиолдолд төрөл садангийн гэр бүлийн хүрээнд асран хамгаалуулах бүх төрлийн арга хэмжээг авах бөгөөд ийм арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд гэр бүлийн журмаар зохион байгуулагдсан нийгмийн дунд асран хамгаална.

24 дүгээр зүйл

Боловсрол

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс Оролцогч улсууд нь дараах зорилгод чиглэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг багтаасан бүх шатны болон насан туршийн тасралтгүй сургалтын боловсролын тогтолцоог баталгаажуулна:

а) Хүний чадамж, эрхэм зэргийн ойлголт болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хүний ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх

б) Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн шинж чанар, авъяас чадвар, бүтээлч чанар ба тэдний оюуны болон бие махбодийн чадварыг байж болох хамгийн бүрэн дүүрэн хэмжээгээр хөгжүүлэх

с) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох

2. Эдгээр эрхийг хэрэгжүүлэх үүднээс Оролцогч улсууд нь дараах зүйлсийг баталгаажуулна:

а) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь ерөнхий боловсролын тогтолцооноос хөгжлийн бэрхшээлээсээ шалтгаалж хасагдахгүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд заавал, үнэ төлбөргүй олгогдох ёстой бага боловсрол, дунд боловсролын үйл ажиллагаанаас хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хасагдахгүй байх

b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн амьдарч буй орчиндоо бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг багтаасан, чанартай, үнэ төлбөргүй бага, дунд боловсролыг эзэмших боломжтой байх

c) Хувь хүний онцлог шаардлагад нийцсэн боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдах

d) Ерөнхий боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн үр дүнтэйгээр сурч боловсрох нөхцөл байдлыг хангуулах үүднээс шаардлагатай дэмжлэг туслалцаа авах

d) Түүнчлэн, хувь хүнд зориулагдсан үр дүнтэй туслах арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг бүрэн багтаасан байх зорилгод нийцсэн онолын болон нийгмийн хөгжлийг нэмэгдүүлэхүйц орчинд хэрэглэгдэх

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн гишүүний хувьд боловсролд бүрэн дүүрэн, тэгш оролцоход нь дэмжлэг үзүүлэх амьдралын болон нийгмийн хөгжлийн ур чадваруудыг эзэмших боломжийг олгоно. Үүний тул Оролцогч улсууд нь дараах зүйлсийг оролцуулан бусад шаардлагатай арга хэмжээг авна:

a) Брайль үсэг болон бусад өөр төрлийн бичиг, нэмэлт болон сонголтот арга зам, төрөл хэлбэр, хэв маягийн харилцуурыг сурах, орон зайн чиг баримжаа олгох болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмших, харилцан туслалцах болон сургах явдлыг дэмжих

b) Дохионы хэл сурах болон дүлий хүмүүсийн хэл ярианы онцлог байдлыг хөхиүлэн дэмжих

c) Хүмүүст ялангуяа сохор, дүлий, дүлий-сохор хүүхдүүдэд боловсрол нь тухайн хүний онцлогт нийцсэн хамгийн зохистой хэл яриа, хэлбэр төрөл, арга замаар олгогдох бөгөөд онолын болон нийгмийн хөгжлийг нэмэгдүүлэхүйц орчинд хэрэглэгдэх байдлыг баталгаажуулах

4. Эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Оролцогч улсууд нь багш нарыг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй болон Брайль бичиг, дохионы хэл эзэмшсэн багш нарыг ажиллуулах, боловсролын бүх түвшинд ажилладаг ажилтнууд, мэргэжилтнүүдийг сургах зохистой арга хэмжээ авна. Ийм сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх болон зохистой нэмэлт болон сонголтот арга зам, төрөл хэлбэр, хэв маягийн харилцуур, хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах боловсролын техник, материалыг хэрэглэх зэргийг хамарвал зохино.

5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр дээд боловсрол эзэмших, мэргэжлийн сургалтанд хамрагдах, насанд хүрэгсдийн болон насан туршийн сургалтанд хамрагдах явдлыг баталгаажуулна. Үүний тул Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдах байдлыг баталгаажуулна.

Article 25

Health

States Parties recognize that persons with disabilities have the right to the enjoyment of the highest attainable standard of health without discrimination on the basis of disability. States Parties shall take all appropriate measures to ensure access for persons with disabilities to health services that are gender-sensitive, including health-related rehabilitation. In particular, States Parties shall:

- (a) Provide persons with disabilities with the same range, quality and standard of free or affordable health care and programmes as provided to other persons, including in the area of sexual and reproductive health and population-based public health programmes;
- (b) Provide those health services needed by persons with disabilities specifically because of their disabilities, including early identification and intervention as appropriate, and services designed to minimize and prevent further disabilities, including among children and older persons;
- (c) Provide these health services as close as possible to people's own communities, including in rural areas;
- (d) Require health professionals to provide care of the same quality to persons with disabilities as to others, including on the basis of free and informed consent by, inter alia, raising awareness of the human rights, dignity, autonomy and needs of persons with disabilities through training and the promulgation of ethical standards for public and private health care;
- (e) Prohibit discrimination against persons with disabilities in the provision of health insurance, and life insurance where such insurance is permitted by national law, which shall be provided in a fair and reasonable manner;
- (f) Prevent discriminatory denial of health care or health services or food and fluids on the basis of disability.

Article 26

Habilitation and rehabilitation

1. States Parties shall take effective and appropriate measures, including through peer support, to enable persons with disabilities to attain and maintain maximum independence, full physical, mental, social and vocational ability, and full inclusion and participation in all aspects of life. To that end, States Parties shall organize, strengthen and extend comprehensive habilitation and rehabilitation services and programmes, particularly in the areas of health, employment, education and social services, in such a way that these services and programmes:

- (a) Begin at the earliest possible stage, and are based on the multidisciplinary assessment of individual needs and strengths;

Annex I - Text of the Convention and optional protocol

(b) Support participation and inclusion in the community and all aspects of society, are voluntary, and are available to persons with disabilities as close as possible to their own communities, including in rural areas.

2. States Parties shall promote the development of initial and continuing training for professionals and staff working in habilitation and rehabilitation services.

3. States Parties shall promote the availability, knowledge and use of assistive devices and technologies, designed for persons with disabilities, as they relate to habilitation and rehabilitation.

Article 27

Work and employment

1. States Parties recognize the right of persons with disabilities to work, on an equal basis with others; this includes the right to the opportunity to gain a living by work freely chosen or accepted in a labour market and work environment that is open, inclusive and accessible to persons with disabilities. States Parties shall safeguard and promote the realization of the right to work, including for those who acquire a disability during the course of employment, by taking appropriate steps, including through legislation, to, inter alia:

(a) Prohibit discrimination on the basis of disability with regard to all matters concerning all forms of employment, including conditions of recruitment, hiring and employment, continuance of employment, career advancement and safe and healthy working conditions;

(b) Protect the rights of persons with disabilities, on an equal basis with others, to just and favourable conditions of work, including equal opportunities and equal remuneration for work of equal value, safe and healthy working conditions, including protection from harassment, and the redress of grievances;

(c) Ensure that persons with disabilities are able to exercise their labour and trade union rights on an equal basis with others;

(d) Enable persons with disabilities to have effective access to general technical and vocational guidance programmes, placement services and vocational and continuing training;

25 дугаар зүйл

Эрүүл мэнд

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийнх нь үндсэн дээр алагчлалгүйгээр эрүүл мэндийн дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээх эмчилгээг оролцуулан жендерийн мэдрэмжтэй эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах боломжийг баталгаажуулах бүхий л зохистой арга хэмжээг авна. Тухайлбал, Оролцогч улсууд нь:

- а) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүнд амд суурилсан нийтийн эрүүл мэндийн хөтөлбөр ба бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарыг оролцуулан бусад хүмүүст хүргэдэгтэй ижил түвшин, чанар, стандарт бүхий бөгөөд үнэ төлбөргүй буюу худалдан авах чадавхад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрүүдээр хангах
- б) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор зохистой байдлаар эрт илрүүлэх, таслан зогсоох буюу багасгахад чиглэгдсэн болон хүүхдүүд, ахмадуудыг ирээдүйд хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах
- в) Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан эмнэлэгийн үйлчилгээг бүх газарт тухайлбал, хөдөө орон нутагт ч аль болох гэрт нь ойр газар үзүүлэх
- д) Эмч, эмнэлгийн ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдад үзүүлдэгийн нэгэн адил чанартай үйлчилгээг тухайлбал, чөлөөтэй, мэдээллээр хангасны үндсэн дээр үзүүлэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын хүний эрх, эрхэм зэрэг, хараат бус байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээний талаарх ойлголтыг сургалт, хувийн болон олон нийтийн эмнэлэгийн байгууллагуудын ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээг бий болгох замаар нэмэгдүүлэх
- е) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн шударга, зохистой арга замаар хүргэгдэх ёстой нийгмийн даатгал, амь насны даатгалд хамруулахад алагчлах явдлыг устгах
- ф) Хөгжлийн бэрхшээлийнх нь үндсэн дээр эмнэлэгийн тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, хоол хүнс, ундны асуудалд алагчилж, үгүйсгэхээс урьдчилан сэргийлэх

26 дугаар зүйл

Сэргээлт, нөхөн сэргээлт

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгийн дээд түвшинд бие даасан байх, бие махбодь, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн дүүрэн чадавхтай болох, нийгмийн бүх хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох, эзэмшүүлэх үүднээс бүхий л үр дүнтэй, зохистой арга хэмжээ авна. Үүний тул, Оролцогч улсууд нь эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт өргөн хүрээтэйгээр сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ,

Хавсралт I - Конвенц ба Нэмэлт Протокол

хөтөлбөрүүдийг дараах арга замаар зохион байгуулж, бэхжүүлж, өргөжүүлнэ. Үүнд:

- а) Хувь хүний хэрэгцээ, чадавхийг олон талаас нь үнэлж, дүгнэсний үндсэн дээр аль болох эрт үед үзүүлэх
- б) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн бүхий л салбарт болон өөрийнхөө орчин тойронд хамрагдах, оролцоход нь үзүүлэх сайн дурын тусламж үйлчилгээг хөдөө, орон нутгийг оролцуулан тэдгээр хүмүүсийн орчинд үзүүлэх

2. Оролцогч улсууд нь сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх салбарт ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудад зориулсан анхан болон үргэлжилсэн шатны сургалт зохион байгуулах ажлыг хөхиүлэн дэмжинэ.

Оролцогч улсууд нь сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээнд хэрэглэгдэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан туслах тоног төхөөрөмж, технологиудын хүртээмж, тэдгээрийг хэрэглэх талаарх мэдлэг олгох явдыг хөхиүлэн дэмжинэ.

27 дугаар зүйл

Ажил ба хөдөлмөр эрхлэлт

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр хөдөлмөр эрхлэх, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг багтаасан, хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээл болон ажлын байрны орчинд хүлээн зөвшөөрөгдөж, чөлөөтэй сонгосон эрхэлж буй ажлынхаа үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжтой байх эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөдөлмөр эрхлэх явцдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг эдлүүлэх үүднээс зохистой арга хэмжээ тухайлбал, хууль тогтоомжийн болон дараах хэмжээ авах явдлыг баталгаажуулж, хөхиүлэн дэмжинэ:

- а) Ажилд авах шаардлага тавих, хөлслөн ажиллуулах, ажил олгох, ажил хөдөлмөр эрхлэх явцад, мэргэжлийн хувьд өсөн дэвжих, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах явдлыг оролцуулан хөдөлмөрийн бүх дэвшилтэй холбогдсон бүхий л асуудалд хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлахыг хориглох
- б) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр тэгш боломж, ижил адил хөдөлмөрт адил тэгш цалин хөлс авах, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах, тухайлбал, дарамтлалаас хамгаалагдах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхийг хамгаалах
- с) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр хөдөлмөрлөх, үйлдвэрчний байгууллагатай холбогдсон эрхээ эдлэх боломжийг баталгаажуулах
- д) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ерөнхий техникийн болон техник мэргэжлийн чиглэмж хөтөлбөрүүд, ажлын дадал олголт, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтанд үр дүнтэйгээр хамрагдах боломжийг бий болгох

- (e) Promote employment opportunities and career advancement for persons with disabilities in the labour market, as well as assistance in finding, obtaining, maintaining and returning to employment;
- (f) Promote opportunities for self-employment, entrepreneurship, the development of cooperatives and starting one's own business;
- (g) Employ persons with disabilities in the public sector;
- (h) Promote the employment of persons with disabilities in the private sector through appropriate policies and measures, which may include affirmative action programmes, incentives and other measures;
- (i) Ensure that reasonable accommodation is provided to persons with disabilities in the workplace;
- (j) Promote the acquisition by persons with disabilities of work experience in the open labour market;
- (k) Promote vocational and professional rehabilitation, job retention and return-to-work programmes for persons with disabilities.

2. States Parties shall ensure that persons with disabilities are not held in slavery or in servitude, and are protected, on an equal basis with others, from forced or compulsory labour.

Article 28

Adequate standard of living and social protection

1. States Parties recognize the right of persons with disabilities to an adequate standard of living for themselves and their families, including adequate food, clothing and housing, and to the continuous improvement of living conditions, and shall take appropriate steps to safeguard and promote the realization of this right without discrimination on the basis of disability.
2. States Parties recognize the right of persons with disabilities to social protection and to the enjoyment of that right without discrimination on the basis of disability, and shall take appropriate steps to safeguard and promote the realization of this right, including measures:
 - (a) To ensure equal access by persons with disabilities to clean water services, and to ensure access to appropriate and affordable services, devices and other assistance for disability-related needs;
 - (b) To ensure access by persons with disabilities, in particular women and girls with disabilities and older persons with disabilities, to social protection programmes and poverty reduction programmes;

Annex I - Text of the Convention and optional protocol

- (c) To ensure access by persons with disabilities and their families living in situations of poverty to assistance from the State with disability-related expenses, including adequate training, counselling, financial assistance and respite care;
- (d) To ensure access by persons with disabilities to public housing programmes;
- (e) To ensure equal access by persons with disabilities to retirement benefits and programmes.

Article 29

Participation in political and public life

States Parties shall guarantee to persons with disabilities political rights and the opportunity to enjoy them on an equal basis with others, and shall undertake to:

- (a) Ensure that persons with disabilities can effectively and fully participate in political and public life on an equal basis with others, directly or through freely chosen representatives, including the right and opportunity for persons with disabilities to vote and be elected, *inter alia*, by:
 - (i) Ensuring that voting procedures, facilities and materials are appropriate, accessible and easy to understand and use;
 - (ii) Protecting the right of persons with disabilities to vote by secret ballot in elections and public referendums without intimidation, and to stand for elections, to effectively hold office and perform all public functions at all levels of government, facilitating the use of assistive and new technologies where appropriate;
 - (iii) Guaranteeing the free expression of the will of persons with disabilities as electors and to this end, where necessary, at their request, allowing assistance in voting by a person of their own choice;
- (b) Promote actively an environment in which persons with disabilities can effectively and fully participate in the conduct of public affairs, without discrimination and on an equal basis with others, and encourage their participation in public affairs, including:
 - (i) Participation in non-governmental organizations and associations concerned with the public and political life of the country, and in the activities and administration of political parties;
 - (ii) Forming and joining organizations of persons with disabilities to represent persons with disabilities at international, national, regional and local levels.

- е) Хөдөлмөрийн зах зээл болон ажил хайх, ажилд орох, ажиллах болон ажилдаа буцаж ороход боломж нөхцөл, мэргэжлийн хувьд дэвших боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох явдлыг хөхиүлэн дэмжих
- ф) Хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах, нөхөрлөл, хоршоо ажиллуулах, хувийн бизнесээ эрхлэх боломжийг дэмжих
- г) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн албанд авах
- h) Дагаж мөрдөхүйц мөрийн хөтөлбөр, урамшуулал, өдөөлт болон бусад арга хэмжээг оролцуулах зохистой бодлого, арга хэмжээгээр дамжуулан хувийн хэвшлийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөр эрхлэх явдлыг хөхиүлэн дэмжих
- i) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байранд боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдсан байх явдлыг баталгаажуулах
- j) Нээлттэй хөдөлмөрийн зах зээлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажлын туршлага хуримтлуулах явдлыг хөхиүлэн дэмжих
- k) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжлийн болон техник мэргэжлийн нөхөн сэргээлт, ажлын байр хадгалагдах болон ажилд нь буцааж оруулах хөтөлбөрүүдийг хөхиүлэн дэмжих

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжлөг, боолын байдалд орохгүй байх, бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр албадан хөдөлмөрөөс хамгаалагдах явдлыг баталгаажуулна.

28 дугаар зүйл

Хүрэлцэхүйц амьжиргаатай байх ба нийгмийн хамгаалал хүртэх эрх

1. Оролцогч улсууд нь хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас хунар, орон байраар хангагдах эрх, амьдралын нөхцлөө тасралтгүй сайжруулах явдлыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлэх явдлыг хөхиүлэн дэмжих, баталгаажуулах үүднээс зохистой арга хэмжээ авна.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгаалал хүртэх эрх, энэ эрхийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалсан ямар нэг алагчлалгүйгээр эдлэх явдлыг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, баталгаажуулах үүднээс зохистой арга хэмжээ авна. Тухайлбал:

- a) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг цэвэр усны үйлчилгээнд тэгш хамрагдах явдлыг баталгаажуулах болон хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотой шаардлагатай, боломжийн өртөгтэй үйлчилгээ, тоног төхөөрөмж болон бусад тусалцааг хүртэх байдлыг баталгаажуулах
- b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид болон хөгжлийн бэрхшээлтэй ахмад настнуудыг нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд, ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдэд хамрагдах байдлыг баталгаажуулах

с) Ядуу нөхцөлд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийнхнийг хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээт зардалд тухайлбал, шаардлагатай сургалт, зөвлөгөө, санхүүгийн туслалцаа болон түр хугацааны туслалцаа авахдаа төрөөс дэмжлэг авах боломжийг баталгаажуулах

d) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүх нийтийг орон сууцаар хангах явдлыг баталгаажуулах

e) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэтгэврийн үр ашиг, хөтөлбөрүүдэд тэгш хүртээмжтэй хамрагдах явдлыг баталгаажуулах

29 дүгээр зүйл

Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрх

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараах арга хэмжээг авна:

a) Бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийтийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох байдлыг баталгаажуулна.

i) Сонгох горим журам, хэрэглэгдэхүүн, материалыг зохистой, хүртээмжтэй, хялбар ойлгомжтой, хэрэглэх боломжтой байх явдлыг хангах

ii) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль болон ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, сонгуульд оролцох, болон албан тушаал хаших, төр, засгийн газрын ямар ч түвшинд төрийн алба хаах, шаардлагатай тохиолдолд туслах, шинэ технологийг хэрэглэх явдлыг дэмжих эрхийг хамгаалах

iii) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогчийн хувьд өөрийн санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүний тул шаардлагатай тохиолдолд тэдгээр хүмүүсийн хүсэлтээр, тэдний сонгосон хүнээр саналаа өгөхөд нь туслалцаа үзүүлэх

b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр нийтийн үйл хэрэгт бүрэн дүүрэн, үр нөлөөтэй оролцох орчин бүрдүүлэх явдлыг идэвхийлэн хөхиүлэн дэмжиж, тэдний нийтийн үйл хэрэгт оролцох оролцоог урамшуулах, тухайлбал,

i) Улсынхаа олон нийтийн болон төр засгийн асуудлаар ажилладаг төрийн бус байгууллага, холбоо болон улс төрийн намын бүтцийн байгууллага, үйл ажиллагаанд нэгдэх

ii) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон улсын, үндэсний, бүсийн болон орон нутгийн түвшинд төлөөлөх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байгуулах, тийм байгууллагад элсэх

Article 30

Participation in cultural life, recreation, leisure and sport

1. States Parties recognize the right of persons with disabilities to take part on an equal basis with others in cultural life, and shall take all appropriate measures to ensure that persons with disabilities:

- (a) Enjoy access to cultural materials in accessible formats;
- (b) Enjoy access to television programmes, films, theatre and other cultural activities, in accessible formats;
- (c) Enjoy access to places for cultural performances or services, such as theatres, museums, cinemas, libraries and tourism services, and, as far as possible, enjoy access to monuments and sites of national cultural importance.

2. States Parties shall take appropriate measures to enable persons with disabilities to have the opportunity to develop and utilize their creative, artistic and intellectual potential, not only for their own benefit, but also for the enrichment of society.

3. States Parties shall take all appropriate steps, in accordance with international law, to ensure that laws protecting intellectual property rights do not constitute an unreasonable or discriminatory barrier to access by persons with disabilities to cultural materials.

4. Persons with disabilities shall be entitled, on an equal basis with others, to recognition and support of their specific cultural and linguistic identity, including sign languages and deaf culture.

5. With a view to enabling persons with disabilities to participate on an equal basis with others in recreational, leisure and sporting activities, States Parties shall take appropriate measures:

- (a) To encourage and promote the participation, to the fullest extent possible, of persons with disabilities in mainstream sporting activities at all levels;
- (b) To ensure that persons with disabilities have an opportunity to organize, develop and participate in disability-specific sporting and recreational activities and, to this end, encourage the provision, on an equal basis with others, of appropriate instruction, training and resources;
- (c) To ensure that persons with disabilities have access to sporting, recreational and tourism venues;
- (d) To ensure that children with disabilities have equal access with other children to participation in play, recreation and leisure and sporting activities, including those activities in the school system;

Annex I - Text of the Convention and optional protocol

- (e) To ensure that persons with disabilities have access to services from those involved in the organization of recreational, tourism, leisure and sporting activities.

Article 31

Statistics and data collection

1. States Parties undertake to collect appropriate information, including statistical and research data, to enable them to formulate and implement policies to give effect to the present Convention. The process of collecting and maintaining this information shall:

- (a) Comply with legally established safeguards, including legislation on data protection, to ensure confidentiality and respect for the privacy of persons with disabilities;

- (b) Comply with internationally accepted norms to protect human rights and fundamental freedoms and ethical principles in the collection and use of statistics.

2. The information collected in accordance with this article shall be disaggregated, as appropriate, and used to help assess the implementation of States Parties' obligations under the present Convention and to identify and address the barriers faced by persons with disabilities in exercising their rights.

3. States Parties shall assume responsibility for the dissemination of these statistics and ensure their accessibility to persons with disabilities and others.

Article 32

International cooperation

1. States Parties recognize the importance of international cooperation and its promotion, in support of national efforts for the realization of the purpose and objectives of the present Convention, and will undertake appropriate and effective measures in this regard, between and among States and, as appropriate, in partnership with relevant international and regional organizations and civil society, in particular organizations of persons with disabilities. Such measures could include, inter alia:

- (a) Ensuring that international cooperation, including international development programmes, is inclusive of and accessible to persons with disabilities;

30 дугаар зүйл

Соёлын амьдрал, зугаа цэнгээн болон чөлөөт цагаа өнгөрүүлэх арга хэмжээ, спортод оролцох эрх

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр соёлын амьдралд оролцох эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг баталгаажуулах бүхий л зохистой арга хэмжээг авна.

- а) Соёлын хэрэглэгдэхүүнийг хүрээмжтэй хэлбэрүүдээр олж авах
- б) Телевизийн хөтөлбөр, кино, театр болон бусад соёлын үйл ажиллагааг хүрээмжтэй хэлбэрүүдээр хүлээн авах
- в) Театр, музей, кино театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг соёлын үзвэр, үйлчилгээ эрхэлдэг газруудад орох боломжтой байх бөгөөд түүнчлэн хөшөө дурсгал болон үндэсний соёлын ач холбогдол бүхий газруудад ч мөн хүрэх боломжтой байх

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиг олох үүднээс төдийгүй нийгмийн баялагийг бүтээхийн тулд ур дүй, урлагийн болон оюуны чадавхаа ашиглах болон хөгжүүлэх боломжийг бий болгох бүхий л зохистой арга хэмжээг авна.

3. Оролцогч улсууд нь олон улсын эрх зүйн дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалсан хууль тогтоомж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс соёлын хэрэглэгдэхүүнээс хүртэхэд үндэслэлгүй, алагчлах шинжтэй хязгаарлалтыг бий болгоогүй байдлыг хангах үүднээс бүхий л зохистой арга хэмжээг авна.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр өөрсдийн тусгай соёлын болон хэл ярианы онцлог байдал тухайлбал, дохионы хэл, дүлий хүмүүсийн өвөрмөц орчныг хүлээн зөвшөөрүүлж, туслалцаа авах эрхтэй.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр зугаа цэнгээн, чөлөөт цагаа өнгөрүүлэх болон спортын арга хэмжээнд оролцох боломжоор хангах үүднээс Оролцогч улсууд нь дараах зохистой арга хэмжээг авна:

- а) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүх шатны нийтлэг спортын арга хэмжээнд байж болох хамгийн дээд хэмжээгээр оролцуулах явдлыг дэмжиж урамшуулах
- б) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэдгээр хүмүүст тусгайлан зориулагдсан спорт, чөлөөт цагийн арга хэмжээг зохион байгуулах, хөгжүүлэх болон оролцох боломжтой байх явдлыг баталгаажуулах, түүний тул бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр шаардлагатай зааварлалт, сургалт, нөөцөөр хангагдсан байх нөхцлийг дэмжих
- в) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс спорт, зугаа цэнгээн, аялал жуулчлалын байгууллагуудад хүрэх боломжтой байх явдлыг баталгаажуулах

д) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тоглоом наадгай, зугаа цэнгээн, чөлөөт цаг, спортын арга хэмжээнд тухайлбал, сургууль дээр зохион байгуулагдаж байгаа ийм төрлийн арга хэмжээнд оролцох тэгш боломжтой байх явдлыг хангах

е) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зугаа цэнгээн, аялал жуулчлал, чөлөөт цаг, спортын үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллагуудын үйлчилгээг хүртэх боломжтой байх явдлыг баталгаажуулах

31 дүгээр зүйл

Статистик болон тоон мэдээлэл цуглуулах ажиллагаа

1. Оролцогч улсууд нь статистик, судалгааны тоон мэдээллийг оролцуулан шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулах, тэдгээр мэдээллийг энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд ашиглах явдлыг зохион байгуулна. Ийм мэдээллийг олж авах, цуглуулах ажиллагаа нь:

а) Мэдээллийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийг оролцуулан хуулиар тогтоосон хамгаалалтад нийцүүлэн мэдээллийн нууцлалыг хангах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн нууцийг хүндэтгэнэ.

б) Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ болон мэдээлэл цуглуулах болон хэрэглэх статистик ажиллагааны ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байна.

2. Энэхүү зүйлийн дагуу цуглуулсан мэдээлэл нь боломжтой байдлаар нарийвчлагдсан байх бөгөөд Оролцогч улсууд энэхүү Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа байдалд үнэлэлт өгөх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэх явцад учирч буй бэрхшээлүүдийг тодорхойлох, анхаарал хандуулахад эх сурвалж болж хэрэглэгдэнэ.

3. Оролцогч улсууд нь эдгээр статистик мэдээллийг түгээх үүрэг хүлээх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад хүмүүс энэ мэдээллийг олж авах явдлыг баталгаажуулна.

32 дугаар зүйл

Олон улсын хамтын ажиллагаа

1. Оролцогч улсууд нь энэхүү Конвенцийн объект, зорилгыг хэрэгжүүлэх өөрийн улсынхүчинзүтгэлддэмжлэгүзүүлэхэд олон улсын харилцаа чухал болохыг хүлээн зөвшөөрч, хөгжүүлэх бөгөөд үүний тул улс орнууд, шаардлагатай тохиолдолд холбогдох олон улсын, бүс нутгийн болон иргэний нийгмийн байгууллагууд тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай хамтран ажиллах бүхий л зохистой арга хэмжээг авна. Ийм арга хэмжээ нь дараах байдалтай байж болно:

а) Олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдийг оролцуулан олон улсын хамтын ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамарсан, хүртээмжтэй байх явдлыг баталгаажуулах

(b) Facilitating and supporting capacity-building, including through the exchange and sharing of information, experiences, training programmes and best practices;

(c) Facilitating cooperation in research and access to scientific and technical knowledge;

(d) Providing, as appropriate, technical and economic assistance, including by facilitating access to and sharing of accessible and assistive technologies, and through the transfer of technologies.

2. The provisions of this article are without prejudice to the obligations of each State Party to fulfil its obligations under the present Convention.

Article 33

National implementation and monitoring

1. States Parties, in accordance with their system of organization, shall designate one or more focal points within government for matters relating to the implementation of the present Convention, and shall give due consideration to the establishment or designation of a coordination mechanism within government to facilitate related action in different sectors and at different levels.

2. States Parties shall, in accordance with their legal and administrative systems, maintain, strengthen, designate or establish within the State Party, a framework, including one or more independent mechanisms, as appropriate, to promote, protect and monitor implementation of the present Convention. When designating or establishing such a mechanism, States Parties shall take into account the principles relating to the status and functioning of national institutions for protection and promotion of human rights.

3. Civil society, in particular persons with disabilities and their representative organizations, shall be involved and participate fully in the monitoring process.

Article 34

Committee on the Rights of Persons with Disabilities

1. There shall be established a Committee on the Rights of Persons with Disabilities (hereafter referred to as “the Committee”), which shall carry out the functions hereinafter provided.

2. The Committee shall consist, at the time of entry into force of the present Convention, of twelve experts. After an additional sixty ratifications or accessions to the Convention, the membership of the Committee shall increase by six members, attaining a maximum number of eighteen members.

3. The members of the Committee shall serve in their personal capacity and shall be of high moral standing and recognized competence and experience in the field

Annex I - Text of the Convention and optional protocol

covered by the present Convention. When nominating their candidates, States Parties are invited to give due consideration to the provision set out in article 4.3 of the present Convention.

4. The members of the Committee shall be elected by States Parties, consideration being given to equitable geographical distribution, representation of the different forms of civilization and of the principal legal systems, balanced gender representation and participation of experts with disabilities.

5. The members of the Committee shall be elected by secret ballot from a list of persons nominated by the States Parties from among their nationals at meetings of the Conference of States Parties. At those meetings, for which two thirds of States Parties shall constitute a quorum, the persons elected to the Committee shall be those who obtain the largest number of votes and an absolute majority of the votes of the representatives of States Parties present and voting.

6. The initial election shall be held no later than six months after the date of entry into force of the present Convention. At least four months before the date of each election, the Secretary-General of the United Nations shall address a letter to the States Parties inviting them to submit the nominations within two months. The Secretary-General shall subsequently prepare a list in alphabetical order of all persons thus nominated, indicating the State Parties which have nominated them, and shall submit it to the States Parties to the present Convention.

7. The members of the Committee shall be elected for a term of four years. They shall be eligible for re-election once. However, the term of six of the members elected at the first election shall expire at the end of two years; immediately after the first election, the names of these six members shall be chosen by lot by the chairperson of the meeting referred to in paragraph 5 of this article.

8. The election of the six additional members of the Committee shall be held on the occasion of regular elections, in accordance with the relevant provisions of this article.

9. If a member of the Committee dies or resigns or declares that for any other cause she or he can no longer perform her or his duties, the State Party which nominated the member shall appoint another expert possessing the qualifications and meeting the requirements set out in the relevant provisions of this article, to serve for the remainder of the term.

10. The Committee shall establish its own rules of procedure.

11. The Secretary-General of the United Nations shall provide the necessary staff and facilities for the effective performance of the functions of the Committee under the present Convention, and shall convene its initial meeting.

б) Мэдээлэл, туршлага, сургалтын хөтөлбөрүүд болон тэргүүн туршлагуудаа хуваалцах, харилцан солилцох замаар чадавхийг бэхжүүлэх явдлыг дэмжих, туслалцаа үзүүлэх

с) Шинжлэх ухааны болон техникийн мэдлэгийг хүртэх, судлахад хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх

д) Хүртээмжийг дээшлүүлэх ба туслах технологиудыг ашиглах, харилцан суралцахад нь дэмжлэг үзүүлэх, технологи нэвтрүүлэх арга замыг оролцуулан шаардлагатай техник, эдийн засгийн туслалцаагаар хангах

2. Энэхүү зүйлийн заалтыг аливаа Оролцогч улс энэхүү Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд харшлах байдлаар тайлбарлаж болохгүй.

33 дугаар зүйл

Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа

1. Оролцогч улсууд нь төрийн байгууллагын тогтолцоондоо нийцүүлэн, Засгийн газрынхаанэг буюу хэдхэдэн төв байгууллагыг энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг гүйцэтгүүлэхээр томилох бөгөөд өөр түвшний ялгаатай салбарын холбогдох асуудлыг зохицуулах механизмийг Засгийн газрын бүрэлдэхүүнд бий болгох, томилох асуудлыг анхааралдаа авна.

2. Оролцогч улсууд нь өөрсдийн хууль зүйн болон засаг захиргааны тогтолцоондоо нийцүүлэн өөрийн улсын хувьд шаардлагатай нэг буюу хэд хэдэн бие даасан механизмийг оролцуулан энэхүү Конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалах, хөхиүлэн дэмжих ажиллагааны хүрээг бий болгох, томилох, бэхжүүлэх, тогтвортойгоор ажиллуулахад анхаарна. Ийм механизмийг бий болгохдоо Оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын тухай зарчмуудыг анхааралдаа авна.

3. Иргэний нийгмийн байгууллагууд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийг төлөөлөх байгууллагууд энэхүү хяналт тавих ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох, хамрагдах ёстой.

34 дүгээр зүйл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо

1. Хойно заасан чиг үүргийг гүйцэтгэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороог (цаашид Хороо гэх) байгуулна.

2. Энэхүү Конвенцийг хүчин төгөлдөр болох үед Хороог 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 60 улс нэгдэн орсон, соёрхон баталсан нөхцөлд гишүүний тоог 6-гаар нэмэгдүүлэх бөгөөд Хорооны гишүүдийн тоо нь 18-аас ихгүй байна.

3. Хорооны гишүүд нь өөрийн нэрийн өмнөөс ажиллах бөгөөд ёс суртахууны эрхэм дээд чанарыг эзэмшсэн, энэхүү Конвенцид заагдсан салбарт хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг чадвар бүхий байна. Хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгохдоо Оролцогч

Хавсралт I – Конвенц ба Нэмэлт Протокол

улсууд нь энэхүү Конвенцийн 4.3-р зүйлийн нөхцлийг харгалзан үзэхийг зөвлөж байна.

4. Хорооны гишүүд нь Оролцогч улсуудаас сонгогдох бөгөөд ийнхүү сонгохдоо улсууд нь газар зүйн шударга хувиарлалт, соёл иргэншлийн янз бүрийн хэлбэр, эрх зүйн үндсэн тогтолцооны болон хүйсийн тэгш төлөөлөл, хөгжлийн бэрхшээлийн талаар мэргэшсэн байдлыг харгалзаж үзнэ.

5. Хорооны гишүүдийг Оролцогч улсуудын Бага Хурлаас Оролцогч улсуудын өөрсдийн үндэстнүүдийн нэр дэвшигчдээс бүрдсэн жагсаалтаас нууцаар санал хурааж сонгоно. Оролцогч улсуудын гуравны хоёрын оролцоотой санал хураалт явуулах бөгөөд хуралдаанд байлцаж санал өгсөн Оролцогч улсын төлөөлөгчдийн хамгийн олон бөгөөд дийлэнх олонхийн саналыг авсан хүмүүсийг Хорооны гишүүнээр сонгоно.

6. Анхны сонгуулийг энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дотор явуулна. Ээлжит сонгууль явуулахаас наад зах нь дөрвөн сарын өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Оролцогч улсуудад захидал илгээж хоёр сарын дотор нэр дэвшүүлэхийг санал болгоно. Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү нэр дэвшсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг үсгийн дарааллаар нь дэвшүүлсэн улсын хамт гаргаж Оролцогч Улсуудад хүргүүлнэ.

7. Хорооны гишүүд нь дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар сонгогдох бөгөөд нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Гэхдээ анхны сонгуулиар сонгогдсон зургаан гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жил бөгөөд анхны сонгуулийг явуулж дуусмагц эдгээр зургаан гишүүний нэрийг энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан хуралдааны дарга шодож тогтооно.

8. Нэмж сонгогдох зургаан гишүүнийг энэхүү зүйлийн холбогдох заалтын дагуу жирийн сонгууль зохион байгуулж сонгоно.

9. Хорооны гишүүн нас барах, огцрох буюу бусад шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүний нэрийг дэвшүүлсэн Оролцогч улс энэхүү зүйлийн холбогдох заалтыг шаардлагад нийцсэн өөр шинжээчийн нэрийг дэвшүүлж үлдсэн хугацаанд томилуулж ажиллуулна.

10. Хороо нь үйл ажиллагааныхаа горим, журмыг өөрөө бий болгоно.

11. Энэхүү Конвенцийн дагуу Хорооны ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай боловсон хүчин, материаллаг хэрэгслээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хангах бөгөөд Хорооны анхны хуралдааныг зарлаж хуралдуулна.

Annex I - Text of the Convention and optional protocol

12. With the approval of the General Assembly, the members of the Committee established under the present Convention shall receive emoluments from United Nations resources on such terms and conditions as the Assembly may decide, having regard to the importance of the Committee's responsibilities.

13. The members of the Committee shall be entitled to the facilities, privileges and immunities of experts on mission for the United Nations as laid down in the relevant sections of the Convention on the Privileges and Immunities of the United Nations.

Article 35

Reports by States Parties

1. Each State Party shall submit to the Committee, through the Secretary-General of the United Nations, a comprehensive report on measures taken to give effect to its obligations under the present Convention and on the progress made in that regard, within two years after the entry into force of the present Convention for the State Party concerned.

2. Thereafter, States Parties shall submit subsequent reports at least every four years and further whenever the Committee so requests.

3. The Committee shall decide any guidelines applicable to the content of the reports.

4. A State Party which has submitted a comprehensive initial report to the Committee need not, in its subsequent reports, repeat information previously provided. When preparing reports to the Committee, States Parties are invited to consider doing so in an open and transparent process and to give due consideration to the provision set out in article 4.3 of the present Convention.

5. Reports may indicate factors and difficulties affecting the degree of fulfilment of obligations under the present Convention.

Article 36

Consideration of reports

1. Each report shall be considered by the Committee, which shall make such suggestions and general recommendations on the report as it may consider appropriate and shall forward these to the State Party concerned. The State Party may respond with any information it chooses to the Committee. The Committee may request further information from States Parties relevant to the implementation of the present Convention.

2. If a State Party is significantly overdue in the submission of a report, the Committee may notify the State Party concerned of the need to examine the implementation of the present Convention in that State Party, on the basis of reliable information available to the Committee, if the relevant report is not submitted within three months following the notification. The Committee shall invite the State Party concerned to

Annex I - Text of the Convention and optional protocol

participate in such examination. Should the State Party respond by submitting the relevant report, the provisions of paragraph 1 of this article will apply.

3. The Secretary-General of the United Nations shall make available the reports to all States Parties.

4. States Parties shall make their reports widely available to the public in their own countries and facilitate access to the suggestions and general recommendations relating to these reports.

5. The Committee shall transmit, as it may consider appropriate, to the specialized agencies, funds and programmes of the United Nations, and other competent bodies, reports from States Parties in order to address a request or indication of a need for technical advice or assistance contained therein, along with the Committee's observations and recommendations, if any, on these requests or indications.

Article 37

Cooperation between States Parties and the Committee

1. Each State Party shall cooperate with the Committee and assist its members in the fulfilment of their mandate.

2. In its relationship with States Parties, the Committee shall give due consideration to ways and means of enhancing national capacities for the implementation of the present Convention, including through international cooperation.

Article 38

Relationship of the Committee with other bodies

In order to foster the effective implementation of the present Convention and to encourage international cooperation in the field covered by the present Convention:

(a) The specialized agencies and other United Nations organs shall be entitled to be represented at the consideration of the implementation of such provisions of the present Convention as fall within the scope of their mandate. The Committee may invite the specialized agencies and other competent bodies as it may consider appropriate to provide expert advice on the implementation of the Convention in areas falling within the scope of their respective mandates. The Committee may invite specialized agencies and other United Nations organs to submit reports on the implementation of the Convention in areas falling within the scope of their activities;

(b) The Committee, as it discharges its mandate, shall consult, as appropriate, other relevant bodies instituted by international human rights treaties, with a view to ensuring the consistency of their respective reporting guidelines, suggestions and general recommendations, and avoiding duplication and overlap in the performance of their functions.

12. Хорооны гишүүн нь Хорооны үүрэг, хариуцлагын ач холбогдлыг харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоосон журам, нөхцлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөрөнгөөс Ерөнхий Ассамблейн баталсан хөлс авна.

13. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дархан эрх, эрх ямбын тухай конвенцийн холбогдох зүйл заалтын дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын томилолтоор ажиллахдаа Хорооны гишүүд нь шинжээчийн эрх ямба, дархан эрх, материаллаг хэрэгслээр хангагдана.

35 дугаар зүйл

Оролцогч улсуудын тайлан илтгэл

1. Оролцогч улс энэхүү Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээний тухай дэлгэрэнгүй тайлангаа энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Хороонд хүргүүлнэ.

2. Оролцогч улс цаашид шинээр авсан арга хэмжээнийхээ тухай нэмэлт илтгэлийг 4 жилд 1 удаа, түүнчлэн Хорооны хүссэнээр бусад илтгэлийг гарган өгч байна.

3. Хороо нь тайлангийн агуулгатай холбоотой удирдамжаар хангах эсэхийг шийднэ.

4. Анхны дэлгэрэнгүй тайлангаа Хороонд хүргүүлсэн Оролцогч улсын хувьд дараагийн тайландаа өмнө нь дурдагдсан мэдээллийг давтах шаардлагагүй. Хороонд хүргүүлэх илтгэлийг бэлтгэхдээ Оролцогч улсууд нь нээлттэй, ил тод зарчмыг баримтлах бөгөөд энэхүү Конвенцийн 4.3-р зүйлд заасан нөхцлийн харгалзан үзнэ.

5. Тайландаа энэхүү Конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх нь саад учруулж буй хүндрэл, нөхцөл байдлын талаар дурдаж болно.

36 дугаар зүйл.

Тайлан илтгэлийг хянан хэлэлцэх

1. Хороо нь тайлан бүрийг авч хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл зөвлөмж, ерөнхий шинж чанартай анхааруулгыг Оролцогч улсад илгээнэ. Оролцогч улс энэхүү анхааруулгын талаарх санал бодлоо Хороонд хүргүүлж болно. Түүнчлэн Хороо нь энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодруулах мэдээллийг Оролцогч улсуудаас хүсч болно.

2. Оролцогч улсууд нь тайлангаа хүргүүлэх хугацааг ихээр хэтрүүлсэн тохиолдолд Хороо нь өөрт байгаа бодит мэдээлэлдээ тулгуурлан энэхүү Конвенцийн хэрэгжилтийг газар дээр шалгах шаардлагатай байгаа тухайгаа мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг авснаас хойш гурван сарын дотор холбогдох тайланг хүргүүлээгүй тохиолдолд Хороо нь тухайн Оролцогч улсыг тийнхүү зохион байгуулагдах шалгалтад оролцохыг урина. Оролцогч улсын зүгээс мэдэгдлийн дагуу тайланг хүргүүлсэн тохиолдолд энэхүү зүйлийн нэгдүгээр хэсгийн заалтыг удирдлага болгоно.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нь тайланг Оролцогч бүх улсуудад илгээнэ.

4. Оролцогч улсууд нь өөрийн орондоо тайланг олон нийтэд өргөн хэмжээгээр танилцуулах бөгөөд тайлантай нь холбогдуулан гаргасан зөвлөмж, анхааруулгыг олон нийтэд хүртээмжтэй байлгана.

5. Хороо нь шаардлагатай гэж үзвэл техникийн зөвлөгөө, дэмжлэг туслалцаа хүсэх зорилгоор Оролцогч улсуудын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусгай байгууллагууд, сангууд, хөтөлбөрүүдэд хүргүүлнэ. Ингэхдээ тухайн тайлан илтгэлтэй холбогдуулж Хорооны ажиглалт, анхааруулга байгаа тохиолдолд хавсарган хүргүүлнэ.

37 дугаар зүйл

Оролцогч улсууд болон Хорооны хамтын ажиллагаа

1. Оролцогч улсууд нь Хороотой хамтран ажиллах бөгөөд Хороо нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд туслалцаа үзүүлнэ.

2. Оролцогч улсуудтай хамтран ажиллахдаа Хороо нь олон улсын хамтын ажиллагааг оролцуулан энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг дээшлүүлэх арга замыг бий болгохыг эрмэлзэнэ.

38 дугаар зүйл

Хороо болон бусад байгууллагуудын харилцаа

Энэхүү Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх болон Конвенцид заагдсан салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусгай байгууллагууд болон бусад байгууллагууд өөрийн бүрэн эрхийн хүрээнд багтах асуудлаарх энэхүү Конвенцийн холбогдох зүйл заалтын хэрэгжилттэй холбоотой асуудлыг хэлэлцэхэд төлөөллөө байлцуулж болно. Хороо нь шаардлагатай гэж үзвэл тусгай байгууллага болон бусад эрх бүхий байгууллагуудыг өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар энэхүү Конвенцийн хэрэгжилтийн тухайд шинжээчийн зөвлөгөө өгөхийг хүсч болно. Түүнчлэн Хороо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусгай байгууллагууд болон бусад байгууллагуудыг үйл ажиллагааных нь хүрээний асуудлаар энэхүү Конвенцийн хэрэгжилтийн талаар тайлан хүргүүлэхийг хүсч болно.

2. Тухайнасуудал Хорооны бүрэн эрхийн хүрээнд үлбагтах тохиолдолд шаардлагатай гэж үзвэл олон улсын хүний эрхийн гэрээний үндсэн дээр байгуулагдсан бусад холбогдох байгууллагуудтай өөрсдийн тайлан хянах хэлэлцэх болон зөвлөмж, анхааруулга гаргах журмын нийцлийг хангах үүднээс зөвлөлдөх бөгөөд үйл ажиллагааны давхцал, хийдэл гарахаас сэргийлнэ.

Article 39

Report of the Committee

The Committee shall report every two years to the General Assembly and to the Economic and Social Council on its activities, and may make suggestions and general recommendations based on the examination of reports and information received from the States Parties. Such suggestions and general recommendations shall be included in the report of the Committee together with comments, if any, from States Parties.

Article 40

Conference of States Parties

1. The States Parties shall meet regularly in a Conference of States Parties in order to consider any matter with regard to the implementation of the present Convention.
2. No later than six months after the entry into force of the present Convention, the Conference of the States Parties shall be convened by the Secretary-General of the United Nations. The subsequent meetings shall be convened by the Secretary-General of the United Nations biennially or upon the decision of the Conference of States Parties.

Article 41

Depositary

The Secretary-General of the United Nations shall be the depositary of the present Convention.

Article 42

Signature

The present Convention shall be open for signature by all States and by regional integration organizations at United Nations Headquarters in New York as of 30 March 2007.

Article 43

Consent to be bound

The present Convention shall be subject to ratification by signatory States and to formal confirmation by signatory regional integration organizations. It shall be open for accession by any State or regional integration organization which has not signed the Convention.

Article 44

Regional integration organizations

1. "Regional integration organization" shall mean an organization constituted by sovereign States of a given region, to which its member States have transferred competence in respect of matters governed by this Convention. Such organizations shall declare, in their instruments of formal confirmation or accession, the extent of their

Annex I - Text of the Convention and optional protocol

competence with respect to matters governed by this Convention. Subsequently, they shall inform the depositary of any substantial modification in the extent of their competence.

2. References to “States Parties” in the present Convention shall apply to such organizations within the limits of their competence.

3. For the purposes of article 45, paragraph 1, and article 47, paragraphs 2 and 3, any instrument deposited by a regional integration organization shall not be counted.

4. Regional integration organizations, in matters within their competence, may exercise their right to vote in the Conference of States Parties, with a number of votes equal to the number of their member States that are Parties to this Convention. Such an organization shall not exercise its right to vote if any of its member States exercises its right, and vice versa.

Article 45

Entry into force

1. The present Convention shall enter into force on the thirtieth day after the deposit of the twentieth instrument of ratification or accession.

2. For each State or regional integration organization ratifying, formally confirming or acceding to the Convention after the deposit of the twentieth such instrument, the Convention shall enter into force on the thirtieth day after the deposit of its own such instrument.

Article 46

Reservations

1. Reservations incompatible with the object and purpose of the present Convention shall not be permitted.

2. Reservations may be withdrawn at any time.

Article 47

Amendments

1. Any State Party may propose an amendment to the present Convention and submit it to the Secretary-General of the United Nations. The Secretary-General shall communicate any proposed amendments to States Parties, with a request to be notified whether they favour a conference of States Parties for the purpose of considering and deciding upon the proposals.

In the event that, within four months from the date of such communication, at least one third of the States Parties favour such a conference, the Secretary-General shall convene the conference under the auspices of the United Nations. Any amendment adopted by a majority of two thirds of the States Parties present and voting shall be submitted by the Secretary-General to the General Assembly for approval and thereafter to all States Parties for acceptance.

39 дүгээр зүйл

Хорооны илтгэл

1. Хороо нь хоёр жил тутамд өөрийн үйл ажиллагааныхаа талаар Ерөнхий Ассамблей болон Эдийн засаг, Нийгмийн Зөвлөлд тайлан тавих бөгөөд Оролцогч улсуудаас хүлээн авсан мэдээлэл, тайлангийн дагуу хийсэн шалгалтын үр дүнд үндэслэн зөвлөмж, ерөнхий шинжтэй анхааруулга хийж болно. Ийнхүү хийсэн зөвлөмж, ерөнхий шинжтэй анхааруулга нь Хорооны тайланд багтах бөгөөд Оролцогч улсуудын дүгнэлт бий бол мөн хамтатган хүргүүлнэ.

40 дүгээр зүйл

Оролцогч улсуудын Бага Хурал

1. Энэхүү Конвенцийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг хэлэлцэх зорилгоор Оролцогч улсууд нь Оролцогч улсуудын Бага Хурлыг хуралдуулж тогтмол уулзана.

2. Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сараас илүүгүй хугацаанд Оролцогч улсуудын Бага Хурлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулна. Удаах Бага Хурлууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын зарлан хуралдуулснаар хоёр жил тутамд эсвэл Оролцогч улсуудын Бага Хурлаас шийдвэрлэсэн тухай бүр хуралдана.

41 дүгээр зүйл

Батламж жуух бичгийг хадгалуулах

Энэхүү Конвенцийн батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

42 дугаар зүйл

Гарын үсэг зурах

Энэхүү Конвенц нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нью-Йорк дахь төв байранд 2007 оны 3 дугаар сарын 30-наас эхлэн гарын үсэг зурахад бүх улсууд болон бүсийн хамтын ажиллагааны байгууллагуудад нээлттэй болно.

43 дугаар зүйл.

Дагаж төрдөх зөвшөөрөл

Энэхүү Конвенцийг гарын үсэг зурсан улсуудын хувьд соёрхон батлагдсан, гарын үсэг зурагч бүсийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд албан ёсны мэдэгдэл хийгдсэн байвал зохино. Конвенцид гарын үсэг зураагүй улсууд болон бүсийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд нэгдэн ороход нээлттэй байна.

44 дүгээр зүйл

Бүсийн хамтын ажиллагааны байгууллагууд

1. “Бүсийн хамтын ажиллагааны байгууллагууд” гэж тодорхой бүс нутгийн тусгаар тогтносон улсуудаас бүрдсэн, Гишүүн улсууд нь энэхүү Конвенцид заагдсан асуудлаар шийдвэр гаргах эрх мэдлээ шилжүүлсэн байгууллагыг хэлнэ. Тийм

байгууллагууд нь өөрсдийн албан ёсны зөвшөөрөл болон нэгдэн орох баримт бичигтээ энэхүү Конвенцид заасан асуудлаар шийдвэр гаргах эрх мэдэл бүхий болгохоо нотлосон байвал зохино. Түүнчлэн, тэдгээр байгууллагууд нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гарсан аливаа өөрчлөлтийн талаар батламж жуух бичиг хадгалагчид тогтмол мэдээлнэ.

2. Энэхүү Конвенцийн “Оролцогч улс” хэмээх ойлголт нь тэдгээр байгууллагуудын хувьд тэдгээрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд үйлчилнэ.

3. 45-р зүйлийн 1 дэх хэсэг, 47-р зүйлийн 2 болон 3 дахь хэсгийн зорилгын хүрээнд бүсийн хамтын ажиллагааны байгууллагаас хадгалуулсан ямарваа баримт бичиг тоологдохгүй.

4. Бүсийн хамтын ажиллагааны байгууллагууд Оролцогч улсуудын Бага Хуралд нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Гишүүн улсуудынхаа тоотой тэнцүү хэмжээний саналын эрхтэй оролцож болно. Чингэхдээ Гишүүн улсуудынх нь аль нэг нь санал өгөх эрхээ эдэлсэн тохиолдолд хамтын ажиллагааны байгууллагууд санал өгөх эрхээ эдлэхгүй.

45 дугаар зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Конвенц нь соёрхон баталсан болон нэгдэн орсон хорь дахь батламж жуух бичгийг хүлээн авснаас хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Хорь дахь соёрхон баталсан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш энэхүү Конвенцийг соёрхон баталсан буюу нэгдэн орсон улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гуч дахь өдрөөс энэхүү Конвенц хүчин төгөлдөр болно.

46 дугаар зүйл

Гэрээнд тайлбар хийх

1. Энэхүү Конвенцийн зорилго, зорилттой үл нийцэх тайлбарыг хүлээн авахгүй.

2. Тайлбарыг ямар ч үед буцааж авч болно.

47 дугаар зүйл

Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

1. Энэхүү Конвенцид Оролцогч аль ч улс нэмэлт өөрчлөлт хийх саналаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь уг саналыг оролцогч улсуудад мэдээлж, хэлэлцэж санал хураахаар оролцогч улсуудын бага хурал хуралдуулах саналтай эсэхээ хариу мэдэгдэхийг хүснэ. Сонордуулах захидлыг ийнхүү илгээснээс хойш дөрвөн сарын дотор оролцогч улсын гуравны нэгээс доошгүй нь Бага Хурал хуралдуулах саналтай байвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор зарлан хуралдуулна. Нэмэлт өөрчлөлт нь хуралд оролцогч улсуудын гуравны хоёроос доошгүй саналаар дэмжигдэх бөгөөд ийнхүү дэмжигдсэн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий Ассамблейгаар батлуулахаар, Оролцогч улсуудад хүлээн авахуулахаар тус тус хүргүүлнэ.

2. An amendment adopted and approved in accordance with paragraph 1 of this article shall enter into force on the thirtieth day after the number of instruments of acceptance deposited reaches two thirds of the number of States Parties at the date of adoption of the amendment. Thereafter, the amendment shall enter into force for any State Party on the thirtieth day following the deposit of its own instrument of acceptance. An amendment shall be binding only on those States Parties which have accepted it.

3. If so decided by the Conference of States Parties by consensus, an amendment adopted and approved in accordance with paragraph 1 of this article which relates exclusively to articles 34, 38, 39 and 40 shall enter into force for all States Parties on the thirtieth day after the number of instruments of acceptance deposited reaches two thirds of the number of States Parties at the date of adoption of the amendment.

Article 48

Denunciation

A State Party may denounce the present Convention by written notification to the Secretary-General of the United Nations. The denunciation shall become effective one year after the date of receipt of the notification by the Secretary-General.

Article 49

Accessible format

The text of the present Convention shall be made available in accessible formats.

Article 50

Authentic texts

The Arabic, Chinese, English, French, Russian and Spanish texts of the present Convention shall be equally authentic.

In witness thereof the undersigned plenipotentiaries, being duly authorized thereto by their respective Governments, have signed the present Convention.

Optional Protocol to the Convention on the Rights of Persons with Disabilities

The States Parties to the present Protocol have agreed as follows:

Article 1

1. A State Party to the present Protocol ("State Party") recognizes the competence of the Committee on the Rights of Persons with Disabilities ("the Committee") to receive and consider communications from or on behalf of individuals or groups of individuals subject to its jurisdiction who claim to be victims of a violation by that State Party of the provisions of the Convention.
2. No communication shall be received by the Committee if it concerns a State Party to the Convention that is not a party to the present Protocol.

Article 2

The Committee shall consider a communication inadmissible when:

- (a) The communication is anonymous;
- (b) The communication constitutes an abuse of the right of submission of such communications or is incompatible with the provisions of the Convention;
- (c) The same matter has already been examined by the Committee or has been or is being examined under another procedure of international investigation or settlement;
- (d) All available domestic remedies have not been exhausted. This shall not be the rule where the application of the remedies is unreasonably prolonged or unlikely to bring effective relief;
- (e) It is manifestly ill-founded or not sufficiently substantiated; or when
- (f) The facts that are the subject of the communication occurred prior to the entry into force of the present Protocol for the State Party concerned unless those facts continued after that date.

2. 1 дэх хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт өөрчлөлт нь тухайн нэмэлт өөрчлөлтийг дэмжих үед байсан Оролцогч улсуудын гуравны хоёрын тоотой тэнцүү тооны батламж жуух бичгийг хүлээн авснаас хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Түүнчлэн Оролцогч улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гуч дахь өдрөөс энэхүү Конвенц хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь зөвхөн түүнийг баталсан Оролцогч улсуудын хувьд заавал дагаж мөрдөх хүчин чадалтай байна.

3. Хэрвээ Оролцогч улсуудын Бага Хурлаас түүнчлэн зөвшилцөж шийдвэрлэсэн бол энэхүү Конвенцийн 34, 38, 39 ба 40 дүгээр зүйлийн заалтад хийсэн, энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт өөрчлөлт нь тухайн нэмэлт өөрчлөлтийг дэмжих үед байсан Оролцогч улсуудын гуравны хоёрын тоотой тэнцүү тооны батламж жуух бичгийг хүлээн авсан өдрөөс хойш гуч хоногийн дараа Оролцогч бүх улсуудын хувьд хүчин төгөлдөр болно.

48 дугаар зүйл

Конвенцийг цуцлах

Оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэж энэхүү Конвенцийг цуцалж болно. Цуцлалт нь Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

49 дүгээр зүйл

Конвенцийн бичвэрийн боломжит хувилбар

Энэхүү Конвенцийн эх бичвэр нь бүхий л боломжит, хүрээмжтэй хувилбараар хийгдэнэ.

50 дугаар зүйл

Ижил хүчинтэй эх бичвэр

Энэхүү Конвенцийн араб, хятад, англи, франц, орос, испани хэл дээрх эх бичвэр нь ижил хүчинтэй байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛ

Энэхүү Протоколд Оролцогч улсууд нь дараах зүйлийн талаар харилцан тохиролцов:

1 дүгээр зүйл

1. Энэхүү Протоколд Оролцогч улсууд (“Оролцогч улсууд”) нь Конвенцид тусгасан аль нэг эрхийг нь тухайн Оролцогч улс зөрчсний улмаас хохирсон хэмээн мэдүүлж буй харьяат этгээдийнх нь мэдээллийг хүлээн авч, хянан хэлэлцэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн Хорооны (“Хороо”) эрх мэдлийг хүлээн зөвшөөрнө.

2. Энэхүү Протоколд нэгдэн ороогүй Конвенцийн Оролцогч улсын холбогдол бүхий нэг ч мэдээллийг Хороо хүлээн авахгүй.

2 дугаар зүйл

Хороо нь дараах тохиолдолд мэдээллийг хүлээн авах боломжгүй гэж үзнэ:

a) Ирүүлсэн нэргүй.

b) Мэдээлэл нь тийнхүү мэдээлэх эрхээ урвуулан ашигласан буюу энэхүү Конвенцийн зүйл заалттай нийцээгүй.

c) Тухайн асуудал олон улсын мөрдөн шалгах буюу зохицуулах өөр журмын дагуу шалгагдсан эсвэл Хороогоор хэлэлцэгдсэн .

d) Дотоодын эрх зүйн хамгаалалтын бүхий л арга хэрэгслийг барагдуулаагүй. Эдгээр арга хэрэгслийг ашиглах явдал хүндэтгэх шалтгаангүйгээр удааширсан бол энэ журмыг мөрдөхгүй.

e) Мэдээлэл нь хангалттай үндэслэл болж чадахгүй нь илэрхий байгаа бөгөөд хангалттай нотлогдоогүй.

f) Мэдээлэлд дурдагдсан баримт нь тухайн Оролцогч улсын хувьд энэхүү Конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө бий болсон бөгөөд тухайн мэдээлэл хүргэгдэх өдрийг хүртэл үргэлжлээгүй.

Article 3

Subject to the provisions of article 2 of the present Protocol, the Committee shall bring any communications submitted to it confidentially to the attention of the State Party. Within six months, the receiving State shall submit to the Committee written explanations or statements clarifying the matter and the remedy, if any, that may have been taken by that State.

Article 4

1. At any time after the receipt of a communication and before a determination on the merits has been reached, the Committee may transmit to the State Party concerned for its urgent consideration a request that the State Party take such interim measures as may be necessary to avoid possible irreparable damage to the victim or victims of the alleged violation.

2. Where the Committee exercises its discretion under paragraph 1 of this article, this does not imply a determination on admissibility or on the merits of the communication.

Article 5

The Committee shall hold closed meetings when examining communications under the present Protocol. After examining a communication, the Committee shall forward its suggestions and recommendations, if any, to the State Party concerned and to the petitioner.

Article 6

1. If the Committee receives reliable information indicating grave or systematic violations by a State Party of rights set forth in the Convention, the Committee shall invite that State Party to cooperate in the examination of the information and to this end submit observations with regard to the information concerned.

2. Taking into account any observations that may have been submitted by the State Party concerned as well as any other reliable information available to it, the Committee may designate one or more of its members to conduct an inquiry and to report urgently to the Committee. Where warranted and with the consent of the State Party, the inquiry may include a visit to its territory.

3. After examining the findings of such an inquiry, the Committee shall transmit these findings to the State Party concerned together with any comments and recommendations.

4. The State Party concerned shall, within six months of receiving the findings, comments and recommendations transmitted by the Committee, submit its observations to the Committee.

Annex I - Text of the Convention and optional protocol

5. Such an inquiry shall be conducted confidentially and the cooperation of the State Party shall be sought at all stages of the proceedings.

Article 7

1. The Committee may invite the State Party concerned to include in its report under article 35 of the Convention details of any measures taken in response to an inquiry conducted under article 6 of the present Protocol.

2. The Committee may, if necessary, after the end of the period of six months referred to in article 6.4, invite the State Party concerned to inform it of the measures taken in response to such an inquiry.

Article 8

Each State Party may, at the time of signature or ratification of the present Protocol or accession thereto, declare that it does not recognize the competence of the Committee provided for in articles 6 and 7.

Article 9

The Secretary-General of the United Nations shall be the depositary of the present Protocol.

Article 10

The present Protocol shall be open for signature by signatory States and regional integration organizations of the Convention at United Nations Headquarters in New York as of 30 March 2007.

Article 11

The present Protocol shall be subject to ratification by signatory States of this Protocol which have ratified or acceded to the Convention. It shall be subject to formal confirmation by signatory regional integration organizations of this Protocol which have formally confirmed or acceded to the Convention. It shall be open for accession by any State or regional integration organization which has ratified, formally confirmed or acceded to the Convention and which has not signed the Protocol.

Article 12

1. "Regional integration organization" shall mean an organization constituted by sovereign States of a given region, to which its member States have transferred competence in respect of matters governed by the Convention and this Protocol. Such organizations shall declare, in their instruments of formal confirmation or accession, the extent of their competence with respect to matters governed by the Convention and this Protocol. Subsequently, they shall inform the depositary of any substantial modification in the extent of their competence.

3 дугаар зүйл

2 дугаар зүйлийн заалтын дагуу Хороо энэхүү Протоколын дагуу ирүүлсэн аливаа мэдээллийг Конвенцийн аль нэг заалтыг зөрчиж байгаа гэгдэж буй Оролцогч улсуудын сонорт хүргэнэ. Мэдээлэл хүлээн авсан улс дурдагдсан асуудлын талаар, түүнчлэн тухайн улсаас авсан байж болох аливаа арга хэмжээ байгаа бол тэр тухайгаа тодруулсан тайлбар буюу мэдэгдэл бичгээр гаргаж зургаан сарын дотор Хороонд ирүүлнэ.

4 дүгээр зүйл

1. Хороо мэдээллийг хүлээн авсны дараа ямар ч үед болон түүний талаар зарчмын шийдвэр гаргахаасаа өмнө холбогдогч оролцогч улсад хандаж, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй хохирогч буюу хохирогчдод нөхөж болшгүй гарз хохирол учрахаас урьдчилан сэргийлэх үүднээс тухайн Оролцогч улсууд зайлшгүй шинжтэй түр арга хэмжээ авахыг хүсч болно.

2. Хорооны энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу өрийн эрх мэдлийн бүрээнд багтах эрхээ элдэж байгаа тохиолдолд энэ мэдээллийг хүлээн авч болох эсэх буюу түүний талаар зарчмын шийдвэр гаргаж байгаа хэрэг биш болно.

5 дугаар зүйл

Энэхүү Протоколд дурдагдсан мэдээллийг Хороо нь хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Мэдээллийг шалгаж тогтоосныхоо дараа Хороо нь хэрэв холбогдох зөвлөмж, чиглэмж гаргасан бол тэдгээрийг Оролцогч улс болон гомдол гаргагчид мэдээлнэ.

6 дугаар зүйл

1. Конвенцид заагдсан эрхийг Оролцогч улс ноцтойгоор удаа дараа зөрчиж байгаа тухай баталгаатай мэдээллийг Хороо хүлээн авсан бол мэдээллийг шалгахад хамтран оролцож, мэдээллийн талаарх саналаа ирүүлэхийг Оролцогч улсаас хүсч болно.

2. Холбогдох Оролцогч улсаас ирүүлж болох аливаа санал, түүнчлэн Хороонд байгаа баталгаатай бусад мэдээллийг харгалзан Хороо хянан шалгах ажиллагаа явуулж, дүнг яаралтай илтгэх зорилгоор нэг буюу хэд хэдэн гишүүнээ томилж болно. Шаардлагатай гэж үзсэн бөгөөд Оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд тухайн улсын нутаг дэвсгэрт очиж хянан шалгах ажиллагаа явуулж болно.

3. Тэрхүү хянан шалгах ажиллагааны дүнг судалж үзсэний дараа Хороо нь уг дүнг санал зөвлөмжийнхөө хамт холбогдох Оролцогч улсад хүргүүлнэ.

4. Хорооноос илгээсэн дүн, санал, зөвлөмжийг хүлээн авснаас хойш 6 сарын дотор холбогдогч оролцогч улс Хороонд хариу илгээнэ.

5. Хянан шалгах ажиллагааг нууцлалыг хадгалсан байдлаар явуулах бөгөөд энэ ажлын бүхий л үе шатанд Оролцогч улсын зүгээс хамтын ажиллагааг хангах бүх арга хэмжээг авна.

7 дугаар зүйл

1. Энэхүү Протоколын 6-р зүйлийн дагуу явуулсан хяналт шалгалтын ажиллагаатай холбогдуулан авсан аливаа арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг Конвенцийн 35-р зүйлийн дагуу ирүүлэх тайландаа тусгахыг Хороо холбогдогч Оролцогч улсаас хүсч болно.

2. Шаардлагатай тохиолдолд 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан 6 сарын хугацаа дууссаны дараа хяналт шалгалтын ажиллагаатай холбогдуулан авсан аливаа арга хэмжээний тухай мэдээлэхийг Хороо холбогдогч Оролцогч улсаас хүсч болно.

8 дугаар зүйл

Аливаа Оролцогч улс энэхүү Протоколыг соёрхон батлах, гарын үсэг зурахад болон нэгдэж орохдоо 6 болон 7 дугаар зүйлд заасан Хорооны бүрэн эрхийг зөвшөөрөхгүй байгаагаа мэдэгдэж болно.

9 дүгээр зүйл

Энэхүү Протоколын батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

10 дугаар зүйл

Энэхүү Протокол нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нью-Йорк дахь төв байранд 2007 оны 3 дугаар 30-наар гарын үсэг зурахад бүх улсууд болон бүсийн хамтын ажиллагааны байгууллагуудад нээлттэй болно.

11 дүгээр зүйл

Энэхүү Протокол нь Конвенцийг соёрхон баталсан буюу нэгдэн орсон, энэхүү Протоколд гарын үсэг зурсан Оролцогч улсуудын хувьд соёрхон баталбал зохино. Түүнчлэн Конвенцийг албан ёсоор зөвшөөрсөн, нэгдэн орсон бүсийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд албан ёсны мэдэгдэл хийгдсэн байвал зохино. Конвенцийг соёрхон баталсан, нэгдэн орсон буюу албан ёсоор зөвшөөрсөн боловч Протоколд гарын үсэг зураагүй Оролцогч улсууд болон бүсийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд энэхүү Протоколд нэгдэн ороход нээлттэй байна.

12 дугаар зүйл

1. “Бүсийн хамтын ажиллагааны байгууллагууд” гэж тодорхой бүс нутгийн тусгаар тогтносон улсуудаас байгуулагдсан, Гишүүн улсууд нь Конвенц болон энэхүү Протоколд заагдсан асуудлаар шийдвэр гаргах эрх мэдлээ шилжүүлсэн байгууллагыг хэлнэ. Тийм байгууллагууд нь өөрсдийн албан ёсны зөвшөөрөл болон нэгдэн орох баримт бичигтээ Конвенц болон энэхүү Протоколд заасан асуудлаар шийдвэр гаргах эрх мэдэл бүхий болгохоо нотлосон байвал зохино. Түүнчлэн, тэдгээр байгууллагууд нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гарсан аливаа өөрчлөлтийн талаар батламж жуух бичиг хадгалагчид тогтмол мэдээлнэ.

2. References to "States Parties" in the present Protocol shall apply to such organizations within the limits of their competence.

3. For the purposes of article 13, paragraph 1, and article 15, paragraph 2, any instrument deposited by a regional integration organization shall not be counted.

4. Regional integration organizations, in matters within their competence, may exercise their right to vote in the meeting of States Parties, with a number of votes equal to the number of their member States that are Parties to this Protocol. Such an organization shall not exercise its right to vote if any of its member States exercises its right, and vice versa.

Article 13

1. Subject to the entry into force of the Convention, the present Protocol shall enter into force on the thirtieth day after the deposit of the tenth instrument of ratification or accession.

2. For each State or regional integration organization ratifying, formally confirming or acceding to the Protocol after the deposit of the tenth such instrument, the Protocol shall enter into force on the thirtieth day after the deposit of its own such instrument.

Article 14

1. Reservations incompatible with the object and purpose of the present Protocol shall not be permitted.

2. Reservations may be withdrawn at any time.

Article 15

1. Any State Party may propose an amendment to the present Protocol and submit it to the Secretary-General of the United Nations. The Secretary-General shall communicate any proposed amendments to States Parties, with a request to be notified whether they favour a meeting of States Parties for the purpose of considering and deciding upon the proposals. In the event that, within four months from the date of such communication, at least one third of the States Parties favour such a meeting, the Secretary-General shall convene the meeting under the auspices of the United Nations. Any amendment adopted by a majority of two thirds of the States Parties present and voting shall be submitted by the Secretary-General to the General Assembly for approval and thereafter to all States Parties for acceptance.

2. An amendment adopted and approved in accordance with paragraph 1 of this article shall enter into force on the thirtieth day after the number of instruments of acceptance deposited reaches two thirds of the number of States Parties at the date of adoption of the amendment. Thereafter, the amendment shall enter into force for any State Party on the thirtieth day following the deposit of its own instrument of acceptance. An amendment shall be binding only on those States Parties which have accepted it.

Annex I - Text of the Convention and optional protocol

Article 16

A State Party may denounce the present Protocol by written notification to the Secretary-General of the United Nations. The denunciation shall become effective one year after the date of receipt of the notification by the Secretary-General.

Article 17

The text of the present Protocol shall be made available in accessible formats.

Article 18

The Arabic, Chinese, English, French, Russian and Spanish texts of the present Protocol shall be equally authentic.

In witness thereof the undersigned plenipotentiaries, being duly authorized thereto by their respective Governments, have signed the present Protocol.

2. Энэхүү Конвенцийн “Оролцогч улс” хэмээх ойлголт нь тэдгээр байгууллагуудын хувьд тэдгээрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд үйлчилнэ.

3. 13-р зүйлийн 1 дэх хэсэг, 15-р зүйлийн 2 дахь хэсгийн зорилгын хүрээнд бүсийн хамтын ажиллагааны байгууллагаас хадгалуулсан ямарваа баримт бичиг тооцогдохгүй.

4. Бүсийн хамтын ажиллагааны байгууллагууд Оролцогч улсуудын Бага Хуралд нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Гишүүн улсуудынхаа тоотой тэнцүү хэмжээний саналын эрхтэй оролцож болно. Чингэхдээ Гишүүн улсуудынх нь аль нэг нь санал өгөх эрхээ эдэлсэн тохиолдолд хамтын ажиллагааны байгууллагууд санал өгөх эрхээ эдлэхгүй.

13 дугаар зүйл

1. Энэхүү Протокол нь соёрхон баталсан болон нэгдэн орсон арав дахь батламж жуух бичгийг хүлээн авснаас хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Хорь дахь соёрхон баталсан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш энэхүү Протоколыг соёрхон баталсан буюу нэгдэн орсон улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гуч дахь өдрөөс энэхүү Протокол хүчин төгөлдөр болно.

14 дүгээр зүйл

1. Энэхүү Протоколын зорилго, зорилттой үл нийцэх тайлбарыг хүлээн авахгүй.

2. Тайлбарыг ямар ч үед буцааж авч болно.

15 дугаар зүйл

1. Энэхүү Протоколд оролцогч аливаа улс түүнд нэмэлт өөрчлөлт хийх саналаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь уг саналыг оролцогч улсуудад уламжилж, уг саналыг хэлэлцэж, санал хураахаар оролцогч улсуудын бага хурал хуралдуулах эсэхээ хариу мэдэгдэхийг хүснэ. Сонордуулах захидлыг ийнхүү илгээснээс хойш дөрвөн сарын дотор оролцогч улсын гуравны нэгээс доошгүй нь Бага Хурал хуралдуулах саналтай байвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор зарлан хуралдуулна. Нэмэлт өөрчлөлт нь хуралд оролцогч улсуудын гуравны хоёроос доошгүй саналаар дэмжигдэх бөгөөд ийнхүү дэмжигдсэн нэмэлт өөрчлөлийг Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий Ассамблейгаар батлуулахаар, Оролцогч улсуудад хүлээн авахуулахаар тус тус хүргүүлнэ.

2. 1 дэх хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт өөрчлөлт нь тухайн нэмэлт өөрчлөлтийг дэмжих үед байсан Оролцогч улсуудын гуравны хоёрын тоотой тэнцүү тооны батламж жуух бичгийг хүлээн авснаас хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Түүнчлэн Оролцогч улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гуч дахь өдрөөс энэхүү Протокол хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь зөвхөн түүнийг баталсан Оролцогч улсуудын хувьд заавал дагаж мөрдөх хүчин чадалтай байна.

16 дугаар зүйл

Оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэж энэхүү Протоколыг цуцалж болно. Цуцлалт нь Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

17 дугаар зүйл

Энэхүү Протоколын эх бичвэр нь бүхий л боломжит, хүрээмжтэй хувилбараар хийгдэнэ.

18 дугаар зүйл

Энэхүү Протоколын араб, хятад, англи, франц, орос, испани хэл дээрх эх бичвэр нь ижил хүчинтэй байна.

Annex II – The UN and people with disabilities

United Nations Commitment to Advancement of the Status of Persons with Disabilities

More than half a billion persons are disabled as a result of mental, physical or sensory impairment and no matter which part of the world they are in, their lives are often limited by physical or social barriers. Approximately 80 per cent of the world's disabled population lives in developing countries.

Disabled persons often suffer from discrimination, because of prejudice or ignorance, and also may lack access to essential services.

